# ГЭМТ ХЭРГИЙН УРЬДЧИЛАН ТААМАГЛАЛТ, ТҮҮНИЙ ТӨРӨЛ

***М.Хүрэлбаатар***
*ДХИС-ийн магистрант,*
*цагдаагийн ахмад*

**Товчлол.** Тодорхой урьдчилан харалт хийх, ийм урьдчилан харалтыг гаргаж ирэх судалгааны тусгай ажил гэсэн хоёр тал урьдчилан харалтад байна. Урьдчилан харалт буюу гэмт явдлын болзошгүй өөрчлөлт, тодорхой хүнээс /бүлэг хүмүүсээс/ гэмт хэрэг үйлдэх /үйлдэхгүй байх/ боломж, нийгэмд аюултай зан үйлийн шинэ хэлбэр үүсч болох тухай магадлал бүхий шүүмж нь судалгааны үр дүнд бий болно.

Энэхүү өгүүлэлд гэмт хэргийн урьдчилан таамаглалтын тухай ойлголт, хамаарч болох хүчин зүйлс, таамаглах арга, түүний төрөл, криминологийн таамгалалаар шийдвэрлэж болох үндсэн асуудлуудын талаар товч авч үзсэн болногэмт зан үйл.

Түлхүүр үг. Гэмт хэргийн таамаглал, урьдчилан харалт,

**Үндсэн хэсэг.** Гэмт хэргийн урьдчилан таамаглал нь шинжлэх ухааны эсвэл энгийн байж ч болно. Цагдаагийн байгууллагын практик ажилтан, гэмт хэрэг, зөрчилд хяналт тавих, хууль, дүрэм журмыг бататгах ажилтай ямар нэг холбоотой байдаг бусад хүмүүсийн ажлын туршлага, тэдний энгийн ажиглалт, ердийн ухамсар, зөн билэгт үндэслэн хийгдсэн урьдчилсан таамаглалын дүгнэлтийг энгийн урьдчилан таамаглалт гэнэ. Энэ нь цагдаагийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд байнга хэрэглэгдэж байдаг.

Энэхүү урьдчилан сэргийлэх таамаглалын:

1. Гэмт явдлыг урьдчилан харах;
2. Нэг бүрийн гэмт зан үйлийн урьдчилан харалт;
3. Хүний зан үйлийн зарим төрөл нийгэмд аюултай байх хэлбэрийг олж хөгжиж хувирахыг цаг тухайд нь олж мэдэж гэмт хэрэг хийхийн урьдчилан харалт гэсэн гурван төрлийг авч үзье.

Судалгааны үр дүн болон гарч ирсэн урьдчилан харалт нь урьдчилан харагдсан гэмт хэрэг, нийгэмд хортой бусад илрэлтэй хийх тэмцлийг төлөвлөх практик шийдвэрийн үндэслэл болно.

Гэмт явдал ба тодорхой гэмт хэргийн шалтгаан, гэмт зан үйлийн сэдэхүй, тодорхой ирээдүйд криминоген ба сөрөг криминоген хүчин зүйлийн хөгжлийн зүй тогтол зэргийн тухай мэдлэгийн тогтолцоонд ба шинжлэх ухааны урьдчилан таамаглалтын нийтлэг, тусгай аргуудад үндэслэгдэж шинжлэх ухааны урьдчилан таамаглалт боловсруулагдана.[1]

Шинжлэх ухаанч урьдчилан таамаглалт нь объектив баримт мэдээлэл дээр хийгдэнэ. Урьдчилан харах ирээдүй цаг бий болоогүй байхад ямар бодит баримт мэдээллийн тухай

[1] Ж.Болдбаатар, О.Нямдаваа нар “Криминологи” УБ 2010 он 132 тал

яригдах болж байна вэ? Нийгмийн аливаа үзэгдэл, түүний дотор гэмт хэргийн холбогдолтой үзэгдлийг хагжилд нь авч үзэх юм бол өнгөрсний үлдэгдэл, одоогийн үндэс суурь, ирээдүйнх нь үр хөврөлийг байнга харж болно. Гэмт явдал, тодорхой төрлийн гэмт хэрэг, нийгэмд харш биш зан үйл нийгэмд аюултай болж өөрчлөгдөх зэрэг нь одоод суурилж, өнгөрснөөс хөрс үндэс авч, болзошгүй ирээдүйгээ тодорхой хэмжээгээр зааж байдаг. Ирээдүйн боломжит хувилбарыг олж тогтоож сурах шаардлагатай. Энэ бол хэцүү асуудал. Гэвч зохих онолын бэлтгэл, практик туршлага байгаа үед тодорхой хэмжээнд боломжтой юм.

Гэмт хэргийн урьдчилан таамаглалтыг хялбаршуулсан бүдүүвчид оруулах юм бол дараах дүр зураг гарна.

**Урьдчилсан таамаглал хийгдэж буй цаг үе**




Нийгэм /бие хүн/ хөгжлийн явц

Бүдүүвчээс харахад гэмт хэргийн урьдчилан таамаглалд хамаарч болох зүйлс нь:

1. Гэмт хэрэгт ач холбогдол бүхий өнгөрсний болон ирээдүйн гол гол зүй тогтол, чиглэлийн агуулгын дүн шинжилгээ
2. Гэмт явдал, хүний зан үйл гэмт хэрэгт ач холбогдолтой бусад үзэгдэлд хийх ажиглалтын гүний хэмжээ /үе/
3. Өнгөрсөн ба одоо цагийн криминоген ба криминогены эсрэг тодорхой хүчин зүйлийн нийлбэр
4. Урьдчилан таамагаллын гүний хэмжээ /хугацаа/
5. Төсөөлж болох ирээдүйд болох крминоген ба криминогены эсрэг хүчийн зүйлийн хөгжлийн зүй тогтлын тухай мэдлэгийн байдал /хэмжээ/.

Гэмт хэргийг урьдчилан таамаглах нь гарч болох гэмт хэргийн тоо, тодорхой хүний хийж болох үйлдлийн тодорхой байдал, үйлдлийг криминализаци ба декриминализаци хийх тодорхой хугацааг зааж хэлж чадахгүй.

Гэмт хэргийг урьдчилан таамаглах зорилго нь тоон ба бусад үзүүлэлтийг яг гаргах бус тодорхой хүний зан үйлийн хөгжлийн гэмт хэрэгт холбогдолтой бусад үйл явцын болзошгүй чиглэл, зүй тогтлыг илрүүлэх явдал мөн.

**Таамаглах арга.** Криминологийн судалгаанд шинжлэх ухааны аливаа тодорхой судалгааны ерөнхий болон тусгай аргуудыг хэрэглэдэг. Танин мэдэхүйн түгээмэл арга бол криминологийн судалгааны хамгийн ерөнхий арга юм. Тэгвэл криминологийн судалгаанд маш өргөн хэрэглэж байгаа тусгай аргуудыг экстрапольцын арга, загварчлах арга, шинжээчийн дүгэлтийг үнэлэх арга гэсэн үндсэн гурван бүлэгт хувааж болно.

*Таамаглах экстраполяцын арга:* Энэ арга нь аливаа таамаглад туйлын өргөн хэрэглэгддэг бөгөөд түүнийг хамгийн дэлгэрэнгүй утгаар нь тайлбарлавал экстраполяци гэдэг нь таамаглаж байгаа объектын түүхийг судлан хөнжлийнх нь зүй тогтлын өнгөрсөн, өнөөгийн байдлыг ирээдүйнх нь төлөвөөр тодорхойлох арга байна.

Экстраполяцийн аргыг гол төлөв тооны болон үзэгдлийн шинж чанарын аргад хамааруулж ямар нэгэн юмс үзэгдэл, үйл явцын нэгэнт мэдэгдэж байгаа зүй тогтол, хандлагыг ирээдүйн хэтийн төлөв байдлаар нь болон боловсруулж байгаа сэтгэлгээний хөгжлийн процесс гэж үздэг. Тэгвэл статистикийн ойлголтоор экстраполяци гэдэг нь динамик цувааны үл мэдэгдэж байгаа түвшинг, өөрөөр хэлбэл ирээдүйн гарах үзүүлэлт /түвшин/-ийг тодорхойлох арга юм.

Криминологийн таамаглалд чухамхүү статистикийн экстраполяцийн аргыг өргөн хэргэлэдэг бөгөөд богино хугацааны таамаглал хийхэд гол төлөв ашиглаж байна. Инерци нь маргаашийг нь тодорхойлж байна гэсэн үг. Эрчимтэй өсөлт бас ойр зууртаа нэг, хоёр жилдээ буурдаг зүйл биш болно. Гэмт явдлын өөрчлөлт нь гагцхүү дараах хэдэн шатыг заавал дамжина.

- Өсөлтийн хурд багасалт
- Тогтножилт
- Бууралт гэсэн шатуудыг нэг жил тэр ч байтугай хэд хэдэн жилээр үргэлжлэх буюу бүр тогтвортой байдлаа удаан хадгаласаар ч байх талтай.

Аливаа нэгэн хүний гэмт зан төлөвийн урьдчилан тооцоололтын үндэс нь бие хүнийх нь хувьд хийсэн судалгаа түүний зан төлөвийн зүй тогтолт байдлын үзүүлэлт, тодорхой үе дэх илэрхийллүүдийнх нь онцлогууд болж байдаг. Экстраполяцийн аргаар урьдчилан таамаглалт хийх нь адил нөхцөл дэх зан төлвийн илэрхийллүүдийг ижилсүүлэн үзэх л явдал дээр үндэслэгдэнэ.

Бие хүн өөрчлөгдөх болбол түүний элдэв холбоо бүхий илэрхийллүүд дагаад өөрчилөгдөх нь ойлгомжтой. Ер нь өөрчлөлтийн үйл явц яах аргагүй удаанаар явагдах болохоор богино хугацааны хүрээндэх урьдчилан таамгалалт алдаа багатай болдог. Харин гэмт зан төлвийн урьдчилсан таамаглалтыг удаан явуулбал нарийвчлалт буурдаг тул алив зорилгод төдийлөн тохирхоо больдог талтай.

*Таамаглах загварчлалын арга*: Криминологийн судалгаанд загварчлалын арга таамаглаж байгаа объектын чанарыг тодрхойлон харуулахад ашигладаг бөгөөд шалтгаан үр дагаврын харилцан хамаарлыг анализ, синтиз, индукци, дедукци, оюун дүгнэлтийн аргаар тодорхойлдог. Криминологийн таамаглаллын загварчлал нь гэмт явдлын хөдөлгөөн хэлбэлзлийн бодит үйл явцыг үнэн зөв тусган илэрхийлж байх ёстой. Үүний тулд загварчлал нь

- Гэмт явдалын тодорхой төрөл /анхны, рецидив, насанд хүрээгүй хүмүүсийн г.м/ бүрт тохирсон, тэдгээрийн онцлогийг илэрхийлсэн байх
- Тийнхүү тодорхой төрөл бүрд тохирсон загварчлалын хэлбэрийг боловсруулах

- Загварчлалыг боловсруулахдаа таамаглал хийж буй тэр цаг үеийн онцлогийг, нэн ялангуяа түүний хөгжлийн хэтийн хандлагыг онцгой харгалзан үзэх хэрэгтэй.

*Жишээ нь: Барууны криминологичид ажилгүйдэл 1%-ийн өсөлттэй байхад гэмт явдал 5%-ийн өсөлттэй байна гэж үзсэн байдаг.*

Ер нь кримиологийн салбарт математик нь санаанд хүрэх хэмжээнд хэрэглэгдэхгүй байгаагаас загварчлалын арга өнөөдөр шинжээчийн дүгнэлтийг үнэлэх, загварчлал хоёрын дунд оршин байгаа юм. Нийгмийн тэгш биш байдал гэмт явдлын өсөлтийг бий болгоно.

Илрүүлэлтийн түвшин доошлох нь гэмт явдлын өсөлтийг дээшлүүлнэ гэсэн хөдлөшгүй үнэн тодорхойлолтууд математик өгөгдөхүүн илэрхийллүүд дээр нарийвчлагдан гарч байвал ихээхэн ач хобогдолтой байх болно. Өөрөөр хэлбэл гэмт явдал түүний хүчин зүйлүүдийн хоорондох харьцаанааны коэффицентийг тодорхойлж чадвал урьдчилан тооцоололтын оновчтой байдал улам дээшлэх юм.

Харьцааны коэффицент хэдий чинээ их байвалтухайн юмс үзэгдлийнх нь шалтгаан тэр чинээгээрээ их болох бөгөөд тодорхой хэлбэрээр хүчин зүйлүүдийг өөрчлөхөд гэмт явдал өөрөөр өөрчлөгдөж байх бүрд магадлалтай байна. Харьцааны коэффицент /+/ мөн /-/ тэмдэгтэй байна. Тэмдэг /+/ гэмт уг бүхий хүчин зүйлийг, тэмдэг /-/ гэмт угт сөрөг хүчин зүйлийг харуулна. Энэ мэтчилэнгээр зүй тогтолт байдлын тухай мэдлэг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамаатай байж болох нь зайлшгүй.[2]

Гэмт явдалд нөлөөлөх төлөвлөлт өөрөө харьцааны судалгаа шинжилгээнийхээ хажуугаар эдийн засгийн судалгаа шинжилгээнд түшиглэх ёстой байдаг. Коэффицент өндөртэй, харьцааны /+/ нэмэх тэмдэгтэй байгаа ьэдгээр хүчин зүйлүүдийг бага зардлаар арилгах арга хэмжээг эхний шатанд төлөвлөх нь чухал. Ингэснээрээ тухайн йл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх бололцоог олгоно.

*Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх арга:* Энэ нь таамаглаж буй объектын талаар тухайн тодорхой салбарын мэргэжилтэн эрдэмтдийн практикийн болон судалгаа шинжилгээний материалыг үндэслэн хийсэн таамаглал юм. Одоо практикь мэргэжлийн шинжээчдийн дүгнэлтийг асууж сурвалжилж үнэлэхэд

- Нэг бүрчлэн асуух
- Хэсэг бүлгээр нь асуух хоёр үндсэн аргыг хэрэглэж байна.

*Нэгдүгээр үе.* Криминологийн таамгалалын зорилго, хугацаа, таамгалах объект, субъект, тэдгээрийн бүтэц, таамаглалыг агуулга, хэлбэр, таамаглах арга болон судлан тогтоох онолын асуудлууд, ажлын болон судалгааны гипотезийг тодорхойлно.

*Хоёрдугаар үе.* Таамаглалд шаардлагатай бүх мэдээ, материалыг бүрэн дүүрэг цуглуулах;

*Гуравдугаар үе.* Цуглуулсан мэдээ, материалыг боловсруулж хэсэгчилсэн таамгалал гаргаж улмаар төрлийн тогтоох;

*Дөрөвдүгээр үе.* Таамаглалын зохих засвар, баяжуулалтыг хийх бөгөөд хэрвээ шаардлагатай бол таамгалаллыг дахин боловсруулах;

*Тавдугаар үе.* Таамгалалын төгсгөлийн буюу дүгнэлтийн шат юм. Энэ үед таамаглах материалаа нарийвчлан задлан шинжилж цогцолбор дүгнэлийг гаргана.

---

[2] Н.Баатаржав “Криминологи” УБ 2004 он 52 тал

Криминологийн таамгалалаар доор дурьдсан үндсэн асуудлуудыг шийдвэрлэж болох юм. Үүнд:

- Таамаглал хийж буй тухайн үед гэмт явдлын ерөнхий зүй тогтол, түвшин, хандлага ямар байх, өөрчлөгдөх эсвэл хэвээр байх
- Гэмт явдлын зүй тогтол, хандлага нь таамаглахаар урьдчилан тодорхойлогдсон нөхцөл, тохироотой холбоотойгоор хэрхэн өөрчлөгдөж болох гэх мэт.

Криминологийн таамгалал нь юуны өмнө гэмт явдалтай тэмцэх ажлыг шинжлэх ухааны үндэстэй төлөвлөхөд зайлшгүй шаардлагатай зүйл юм. Яагаад гэвэл таамаглах нь таамаглаж байгаа объектын бодит зүй тогтол болон дотоод, гадаад хэлхээ холбоог нь илэрхийлж байдаг.

**Дүгнэлт.** Криминологи урьдчилсан тооцоо нь зуун хувийн баталгаатай буюу тухайн гэмт уг хүний бүр тодорхойллоор гэмт хэрэг үйлдэнэ эсвэл үйлдэхгүй гэж ялгасан илэрхийллийг гаргадаггүй болохыг тэмдэглэх хэрэгтэй юм байна.

Энд урьдчилан таамагласны үндсэн дээр цээрлүүлэлтийн бус харин хүмүүжлийн арга хэмжээтэй шаардлагын талаар тодорхой ажлыг бодох хэрэгтэй болно. Төлөвлөлт бол хүн өөрийн өмнө хэрэг үйл явдлынхаа гол зүйлүүдийг дотооддоо тоймлон баримтлаж бүтээлчээр сэтгэсэн боловсруулалт юм байна.

Төлөвлөлт өөртөө урьдчилан таамаглалтай нягт холбоотой төдийгүй чухамдаа түүнд л үндэслэж байдаг. Төлөвлөлт нь тохиолдож болох тодорхой хүндрэлүүдийг урьдчилан харах түүнээс зайлсхийх аль эсвэл түүнд чиглэсэн бэлтгэл хийх боломжуудыг олгодог учир ач холбогдолтой гэж үзэж болно. Үүний зэрэгцээ гэмт үйл ажиллагааных нь шалтгаан нөхцлийг мөрдөн шалгаж буй гэмт хэргийн бүрэлдэхүүнийг нотлон тогтоох мэтчилэнгээр аливаа хүнд хэцүү ажлуудад аль болох бага алдагдалтай байх боломжийг хангадаг байна.

**Санал.** Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсруулахдаа урьдчилан гаргасан таамаглал дээр тулгуурлаж хийх арга зүйн сургалтыг төлөвлөлт хариуцсан алба хаагч нарыг хамруулан явуулах.
2. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд гэмт хэргийн таамаглалыг ашигласан эсэх тал дээр судалгаа явуулж, шинжилгээ хийх.
3. Гэмт хэргийн таамаглалыг ашиглан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тодорхой аргыг шинээр боловсруулах.

# ЭРҮҮГИЙН МӨРДӨГЧИЙН АЖЛЫГ ДҮГНЭХ АРГЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

***Л.Энхтуяа***
*ДХИС-ийн магистрант,*
*цагдаагийн ахлах ахлагч*

**Хураангуй.** Эрүүгийн мөрдөгчийн ажлын дүн мэдээг тайлагнах арга нь нутаг дэвсгэрийн онцлог, хүн амын тоо, гэмт хэргийн гаралт, байршил зэргээс шалтгаалан өөр, өөр байдаг тул эрх бүхий алба хаагчдын дүн мэдээг дүгнэх аргыг боловсронгуй болгох аргыг тодорхойлоход оршино.

**Түлхүүр үг.** Цагдаагийн байгууллага, эрүүгийн мөрдөгч, гүйцэтгэх ажилтан, дүн мэдээ, ажлын үзүүлэлт, нутаг дэвсгэр, шалгуур үзүүлэлт.

## Нэг. Оршил хэсэг

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийнхээ хүрээнд гэмт хэргийг илрүүлэх, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх замаар шүүхээр гэмт хэргийг үнэн зөв шийдвэрлэхэд урьдчилан нөхцөл бүрдүүлдэг болохоор шүүх эрх мэдлийн байгууллагад хамаардаг гэж үзэх үндэстэй. Харин захиргааны байгууллага гэдэг утгаараа гүйцэтгэх засаглалд багтана. Цагдаагийн байгууллага нь нутаг дэвсгэрийн болон ажил үүргийн зарчмаар зохион байгуулагдана.

Тус байгууллага нь үүсэн байгуулагдсан цагаасаа хойш улс орны нийгэм, төрийн байгууламжийн хөгжлийн бүхий л үе шатуудад хөгжиж, бэхжиж ирсэн Монгол төрийн ууган байгууллагын нэг юм. Ардын Засгийн газрын 6 дугаар хурлаар 1921 онд “Цагдаагийн тухай” хэлэлцээд ард түмний амь бие, эд хөрөнгөд халдагсадтай тэмцэх, хэв журам, энх амгалан байдлыг сахиулах үүрэг бүхий “Сэргийлэх цэргийн салаа”-г байгуулсан нь Монгол Улсын шинэ үеийн Цагдаагийн байгууллагын үүсэл болжээ.

Өнөөдөр Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж-оос гадна гэмт хэргийн дүн мэдээг нэгтгэх, боловсруулах, дүгнэх, дүн шинжилгээ хийх, цаашид явуулах арга хэмжээний нөхцөл байдлын боловсруулалтыг явуулдаг.

## Хоёр. Үндсэн хэсэг

Монгол Улсад гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн үүргийг хэрэгжүүлдэг Эрүүгийн цагдаагийн алба нь 1934 онд байгуулагдсан бөгөөд одоогийн байдлаар гэмт хэргийн нөхцөл байдалтай холбогдуулан алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор аар тус алба нь Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газар, Захиргааны удирдлагын хэлтэс, Гүйцэтгэх ажлын дүн шинжилгээний хэлтэс, Зохион байгуулалттай гэмт бүлэг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Кибер гэмт

хэрэгтэй тэмцэх хэлтэс, Хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Эрэн сурвалжлах хэлтэс, Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс гэсэн 1 газар, 10 хэлтэстэй-гээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус алба нь Цагдаагийн ерөнхий газрын шууд удирдлагын дор гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан далд аргаар үйлдэгдсэн эсхүл тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүний үйлдсэн этгээдийг олж тогтоох, түүнчлэн сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, оргосон сэжигтэн, яллагдагч шүүгдэгч, яллагдагч, прокурор шүүхээс даалгасан буюу хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан галт зэвсэг, сум, хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох зорилгоор хуульд заасан үндэслэл, журмын дагуу арга хэрэгсэл ашиглан гүйцэтгэх ажил явуулах үүрэг бүхий эрүүгийн тагнуулын байгууллага юм.

Мөн Улсын Ерөнхий Прокурорын 2020 оны “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих, харьяалал тогтоох тухай” А/33 дугаар тушаалаар харьяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлтийн чиглэлээр мөрдөн шалгах ажиллагааг хариуцан явуулах, нууц, далд аргаар бүлэг зохион байгуулалттай үйлдэгдсэн үндэстэн дамнасан тодорхой төрөл /эдийн засаг, зохион байгуулалттай гэмт бүлэг, хүн худалдаалах, цахим, нийтийн аюулгүй байдлын эсрэг, хүнийг алах, хүчиндэх, дээрэмдэх, хулгайлах зэрэг/-ийн гэмт хэргийг гүйцэтгэх ажлын шугамаар илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох ажиллагааг улсын хэмжээнд хариуцан зохион байгуулах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна.

Албаны үндсэн чиг үүргийн нэг болох гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулахын тулд үйлдэгдсэн гэмт хэрэг бүрийг шинжлэх ухааны арга зүйгээр зөв бүртгэж, бодитой хэмжих, шалтгаан, нөхцөлийг нарийн тогтооход статистикийн шинжлэх ухаан чухал үүрэгтэй бөгөөд тухайн ажиллагааг явуулахдаа дараах Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /КОД/-д заасны дагуу явуулдаг. Үүнд:

- Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах ЦБҮАЖ /код 701/,
- Цагдаагийн байгууллагад хуулиар харьяалуулсан зөрчлийг шалгаж, шийдвэрлэх үйл ажиллагаанд тоо бүртгэл хөтлөн, мэдээллийн сан бүрдүүлж, ашиглах ЦБҮАЖ /код 702/,
- Цагдаагийн байгууллагын хууль сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаандаа ашиглах судалгаа, хяналтын тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг ашиглах ЦБҮАЖ /код 703/.

Улсын хэмжээнд 2016 онд 27167, 2017 онд 32259, 2018 онд 36220, 2019 онд 31524, 2020 онд 23064 гэмт хэрэг тус тус бүртгэгдэж, сүүлийн 5 жил гэмт хэргийн гаралт тогтмол өсөлттэй байсан боловч нийгэм, эдийн засаг, цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан 2020 оноос буурсан үзүүлэлт байгаа ч Цагдаагийн байгууллага, тэр дундаа Эрүүгийн цагдаагийн албаны ачаалал байнга өсч байна.

*График 1. Сүүлийн 5 жил үйлдэгдсэн гэмт хэргийг харьцуулсан судалгаа.*




Тодруулбал Монгол Улсад явагдаж байгаа хууль тогтоомжийн шинэтгэлийн хүрээнд 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдснаас хойш Гүйцэтгэх ажилтнууд Мөрдөн шалгах ажиллагааг явуулах болсон.

Эрүүгийн цагдаагийн албаны "гүйцэтгэх ажилтан-мөрдөгч" нарын ажлын ачаалал эрс ихэсч, ажлын дүн мэдээ гаргах, алба хаагчийн хийсэн ажлыг дүгнэх үзүүлэлт боловсронгүй болгон шинэчлэн, ашиглааж байна. Гэвч манай улсын онцлог, нутаг дэвсгэр, хүн амын төвлөрөл зэргээс шалтгаалан одоо ашиглаж байгаа аргыг боловсронгүй болгох шаардлагатай байна. Тодруулбал жилд дудндджаар 2 хоногт 1 гэмт хэрэг үйлдэгддэг Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газрын эрүүгийн мөрдөгчийн ажлыг, өдөрт 2 гэмт хэрэг үйлдэгддэг Дархан Уул аймгийн, эсвэл хоногт 6 гэмт хэрэг үйлдэгддэг Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газарт ажилладаг эрүүгийн мөрдөгчийн ажилтай харьцуулан дүгнэж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авдаг.

*Хүснэгт 1. Говь-Алтай, Дархан Уул, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийг харьцуулсан байдал.*

| № | Нутаг дэвсгэр | Нутаг дэвсгэр | Хүн амь | Гэмт хэрэг | Бүх гэмт хэрэгтэй харьцуулсан хувь | Хүнд | Бүх хүнд хэрэгтэй харьцуулсан хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Говь-Алтай | 141.400м$^2$ | 58.343 | 151 | 0.65% | 40 | 1.05% |
| 2. | Дархан-Уул | 3.300м$^2$ | 103580 | 566 | 2.45% | 101 | 2.65% |
| 3. | Сонгинохайрхан | 1200.6 км$^2$ | 327.6 | 2337 | 10.13% | 550 | 14.41% |

Энэ нь цагдаагийн байгууллагын тодорхой алба, нэгжийн онцлог, гадаад болон дотоод хүчин зүйлээс шалтгаалан эрхэлж буй албан тушаалтай холбоотой нэмэлт үүргийг харгалзан алба хаагчид, тэр дундаа эрх бүхий алба хаагчдын ажлын дүн мэдээг гаргаж байгаа нь хангалтгүй, харьцуулалт буруу хийгдэж байна гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Тодруулбал нутаг дэвсгэрийн онцлогоос шалтгаалан аль нэг суманд хэрэг, төвөг гардаггүй тайван газарт хэсгийн төлөөлөгчийн ажил дүгнэх үзүүлэлтийг, төв суурин газар ажиллаж байгаа алба хаагчийн нэгэн адил дүгнэх нь харьцангуй ойлголт юм. Тухайн хэрэг

гардаггүй сум нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайн явуулж байна гэж дүгнэгдэж байгаа ч үндсэн ажлыг гэмт хэргийн илрүүлэлтээр дүгнэхэд гэмт хэрэг, зөрчил бараг гардаггүйгээс болж илрүүлсэн хэргээр нь улсын хэмжээнд жагсаахад сүүлийн байранд орж, сануулах, цалингийн хувь хасуулах зэрэг сахилгын шийтгэл хүлээхэд хүрч байгаа тул эрүүгийн мөрдөгчийн ажлыг дүгнэх аргыг боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

Судалгааны ажлын хүрээнд тодорхой эрүүгийн мөрдөгч, хэсгийн төлөөлөгч нартай ажлын дүн мэдээг тайлагаж байгаа, албан дээр нэгтгэн дүгэж байгаа байдлын талаар ярилцлага явуулахад 70 хувь нь ажил дүгнэх үзүүлэлтийг сайжруулж, боловсронгуй болгох шаардлагатай, уг ажиллагааг хийхдээ заавал нутаг дэвсгэр, гэмт хэргийн гаралт зэргийг харгалзан үзэж хийх ёстой гэж хариулж байсан бол 20 хувь нь тийм шаардлага байхгүй гэж хариулж байсан, бол 10 хувь нь буюу шинээр томилогдсон алба хаагчид тухай асуудлыг сайн мэдэхгүй тул, хариулах боломжгүй байна хариулж байсан.

*График 2. Эрүүгийн мөрдөгч, хэсгийн төлөөлөгч нартай хийсэн ярилцлагын үр дүнг харьцуулсан судалгаа.*




Мөн цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтын ажлын дүн мэдээг дүгнэх аргыг боловсронгуй болгоход үүнтэй уялдан тухайн ажилтны ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлага үүссэн байна.

## Гурав. Дүгнэлт хэсэг

Гүйцэтгэх ажилтан, тэр дундаа эрүүгийн мөрдөгч, хэсгийн төлөөлөгч нарын ажлын ачаалал, хүн амын тоо, нутаг дэвсгэрийн байршил, гэмт хэргийн гаралт зэргийг харгалзан, үндэслэл бүхий судалгаа явуулж, эрүүгийн мөрдөгчийн ажлыг дүгнэх аргыг боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэх зорилгоор энэхүү сэдвийг сонгон, судалгааны ажил явуулж байна.

# НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮН ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ

***Б.Батбаяр***
*ДХИС-ийн магистрант,*
*Цагдаагийн дэслэгч*

**Товчлол:** Насанд хүрээгүй хүн гэмт хэрэг, зөрчилд холбогдох, эрх ашиг нь зөрчигдөж, амь нас эрүүл мэнд, сэтгэл санаагаараа хохирч байгаа тул энэ өгүүллээрээ гэмт хэрэг үйлдээд, гэмт хэргийн халдлагад өртөөд буй асуудлыг судалж, цаашид анхаарах асуудлын талаар дурьдсан болно.

**Түлхүүр үг:** Хүүдэд учирч болзошгүй эрсдэл гэмт хэргийн шалтгаан нөхцөл бага насны хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам, шалтгаан, гэмт хэрэгт өртсөн хүүхдийн нийгмийн байдал

**Оршил:** Гэмт хэргийн хамгийн том хохирогч нь хүүхэд байдаг. Гэтэл сүүлийн үед бидний хойч ирээдүй болсон бяцхан үрс маань өөрсдөө гэмт хэрэг үйлддэг, гэмт хэрэгт холбогдох тохиолдол эрчимтэй нэмэгдэх хандлагатай байна. Ялангуяа нийгмийн стресс, бухимдал ихтэй энэ цаг үед үр хүүхдүүддээ тавих бидний хараа хяналт, тэдэндээ зориулах цаг хугацаа дэндүү хомсхон байгаа юм.

Мөн гэр бүлийн хайхрамжгүй байдал, гэр бүл салалт зэргээс шалтгаалж бага насны хүүхдүүд гэмт хэрэгт холбогдож байна. 2021 оны эхний 7 дугаар сарын байдлаар насанд хүрээгүй 296 хүүхэд гэмт хэрэгт холбогдоод байна.[31] Харамсалтай нь тэдний үйлдэж буй гэмт хэрэг нь ноцтой гэх ангилал руу алхам, алхамаар ойртсоор байгаа юм. Тиймээс ирээдүй болсон бяцхан үрсээ хамгаалж, ирээдүйг нь хэрхэн гэрэлтүүлэх талаар уг сэдвийг хөндөж буй билээ.

**Үндсэн хэсэг:** Үе тэнгийхэнтэйгээ найзалж, нөхөрлөж, инээж тоглож байх насандаа хүүхдүүд маань гэмт хэрэгт хөл алдах тохиолдол их болжээ. Гэмт хэрэг үйлдэж байгаа хүүхдүүд гол төлөв эрэгтэй хүүхдүүд байдаг бөгөөд хүүхдийн гэмт хэргийн 90 гаруй хувийг эзэлдэг. Харин охидууд гэмт хэрэг үйлдэх нь харьцангуй бага байдаг.

Гэвч нийт хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн 5-6 хувийг охидуудын гэмт хэрэг эзэлдэг байсан бол сүүлийн жилүүдэд хийсэн судалгаагаар 7-8 орчим хувь, зарим тохиолдолд 10% болж өсөх болсоныг судлаачид тэмдэглэж байна. Жишээлбэл, судалгаагаар гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй хүүхэд 93,3 хувь, эмэгтэй хүүхэд 6,7 хувийг эзлэж байгааг тогтоожээ[42].

Гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн хүмүүсийн дунд хийсэн судалгаанаас дүгнэлт хийхэд, хүүхэд гэмт хэрэгт өртөгдөж байгаа шалтгаан нь тэдний сэтгэхүйн онцлогтой холбоотой байдаг байна. Тухайлбал, амьдралын туршлаггүй, аливаа үйл явдлын мөн чанарт хандах чадвар мөхөс, бусдыг дууриах, тэдний харш үзэл бодол, үйл ажиллагааг ойлгохгүй уруу

3 Цагдаагийн ерөнхий газрын гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн судалгаа-2021 он

4 Хүүхэд гэмт хэрэгт холбогдож буй шалтгаан нөхцөл, насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судалсан судалгааны тайлан. Уб. 2014

татагдах, эцэг, эх болон ойрын хүмүүсээс тэдэнд тавих хараа хяналт сул, тэнэмэл зэрэг нөхцөл байдлууд нөлөөлдөг байна.

Ер нь хүүхдийг гэмт хэрэг үйлдсэнийх нь дараа ял шийтгэл оногдуулахаас илүүтэй гэмт хэрэгт өртөгдөх, дахин гэмт хэрэг үйлдэхээс нь урьдчилан сэргийлэх нь чухал юм. Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион явуулахад судалгаа шинжилгээ, тодорхой төлөвлөгөөгүй явуулах боломжгүй бөгөөд төрийн болон төрийн бус байгууллага, эцэг эх, сургууль, орон нутгийн байгууллагын оролцоотой хамтын үйл ажиллагаа явуулах нь зүйтэй юм.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгий хуулийн ерөнхий ангийн **6.2.1**-т “Гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан байдаг.[5] **2015** онд батлагдаж, одоо шинээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд нэр бүхий 12 гэмт хэргийг үйлдсэн байвал эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Тодруулбал: хүний эрүүл мэндэд хүнд гэмтэл санаатай учруулах, хүчин, хулгай, эд хөрөнгийг устгах, гэмтээх, мансруурулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах, цахим мэдээллийн системд хууль бусаар халдах гэх мэт хэргүүд багтсан байна.

Эдгээр хуульд заасан нэр бүхий гэмт хэргийг үйлдсэн 14-16 насны этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт байдаг. Харин 14-өөс доош насанд хүрээгүй бол тухайн хэргийг үйлдэгч эсвэл хохирогч ч бай бага насны хүүхэд гэж үздэг учраас ял оноох эрх зүйн зохицуулалтгүй байна.

Нийтлэг байдлаар авч үзвэл эцэг эхийн хайр халамж дутах, амьдралын түвшин доогуур, ядуурал, ажилгүйдэл, гуйлгачлал, түүнчлэн бусдын сөрөг нөлөө, гэр бүлийн хүчирхийлэл, бусдын дарамт, шахалт, сониуч гэнэн зан, бусдын нөлөөнд амархан автдаг байдал, багш, эцэг, эхчүүдийн таагүй харьцаа, сургууль завсардалт зэрэг олон нийгмийн сөрөг үзэгдэл нь энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл болдог.[6] Өөрөөр хэлбэл нийгэм, эдийн засаг, сургууль боловсрол, гэр бүлийн орчин хүүхдээс шалтгаалах дараах шалтгаан, нөхцөл байна. Үүнд:

1. Бусдын нөлөөнд амархан ордог. Хүүхэд сэтгэлзүй, зан төлөв, оюун ухааны хувьд бүрэн гүйцэт төлөвшөөгүй байдаг учир түүнийг хүрээлж буй гэр бүл, эцэг,эх, найз нөхөд, ойр дотны хүмүүсийн нөлөөнд автахад маш амархан.

Орчин тойрны хүмүүсийн ааш, зан яриа өгүүлэл, биеэ авч яваа байдал, бусдын үлгэргүй байдлаас шалтгаалж хүүхэд буруу зүйлийг илүү сонирхох, суралцах, үзсэн зүйлээ туршихыг хүсэх нь улмаар гэмт хэрэг үйлдэхэд хүргэдэг.

2. Амар хялбар аргаар мөнгөтэй болох хүсэл. Насанд хүрээгүй хүний тухайд эдийн засгийн хувьд бусдаас хараат байдгаараа онцлог байдаг. Өөрөөр хэлбэл хоол хүнс, хувцас, орон байрны хэрэгцээг түүний эцэг, эх болон харгалзан дэмжих үүрэгтэй этгээдүүд хангаж байдаг.

Хүүхэд өөрийнх нь хэрэгцээг хангаж чадахгүй нөхцөлд амьдралын түвшин хамаарахгүйгээр гэмт хэрэг үйлдэж, олсон мөнгөөрөө хоногийн хоол хүнс, хэрэгцээт зүйлс

5 Төрийн мэдээлэл. 2015. №7 Монгол Улсын Эрүүгийн хууль
6 Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, гэр бүлийн хүчирхийлэл, насанд хүрээгүйчүүдийн гэмт хэрэг дэх оролцоо, нөлөөлөл цаашдын чиг хандлага. Уб.2014. ЭШХ-ийн эмхэтгэл.

авахаасаа илүүтэй цахим тоглоом тоглох, ууж идэх, үзвэр үзэх зэргээр зугаацахад зарцуулдаг байна.

3. Чөлөөт цагийг өнгөрүүлэх газар дутмаг. Хүүхдэд зориулсан биеийн тамирын талбай, тоглоомын төв, усан бассейн, спортын цогцолбор, хүүхдийн ордон зэрэг чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх газар хомс, үйл ажиллагаа явуулж байгаа зарим газрууд нь өндөр төлбөртэй байгаагаас хичээлийн бус цагаар хэсэг бүлгээрээ нийлж, гадуур тэнэж сэлгүүцдэг.

4. Гэр бүлийн орчин. Хүүхдийн буруу хүмүүжил, нийгэмд харш зан төлөв нь гол төлөв гэр бүлийн хүрээнд тогтдог бөгөөд гэр бүл дэх таагүй уур амьсгал, архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл салах зэрэг нь хүүхдэд сөргөөр нөлөөлж байнгын стресст орох, уур бухимдлаа бусдад гаргах, хүчирхийлэл үйлдэхэд хүргэдэг.

5. Хүүхдийг зөв хүн болгон төлөвшүүлэхэд чиглэгдсэн хичээл сургалтын чанар. Ерөнхий боловсролын сургуулиудад “Иргэний боловсрол” болон “Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа” хичээлээр сурагчдад гэмт хэрэг, зөрчил, гэмт хорын тухай ойлголтыг тодорхой цагаар заадаг боловч хичээлийн агуулга нь өнөөгийн шаардлагатай уялдаагүй, багшлах боловсон хүчин дутмаг зэрэг шалтгаанаар төдийлөн үр дүнд хүрэхгүй байгаа юм.

Сурагчдын тоо олон, зарим үед 3 ээлжээр хичээллэдэг учир хичээлийн бус цагаар хүүхдийн хүмүүжилд чиглэсэн ажил, арга хэмжээ бараг зохион байгуулагддагүй.

6. Хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилт хангалтгүй. Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас эрх нь зөрчигдсөн хүүхдийн асуудлаар “Хүүхдийн хууль зүйн хороо”, хүчирхийлэлд өртсөн хүүхдийн асуудлаар “Хамтарсан баг” ажиллахаар заасан боловч хэрэгжилт нь хангалтгүй, стандарт MNS 6444:2014 буюу “Сургуулийн бүс”-ийн техникийн ерөнхий шаардлагын дагуу сургуулийн орчинг тохижуулаагүй, сургуулийн автобусны тоо бага, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн талаар эцэг, эх, сурагчдын мэдлэг хомс, эцэг, эхчүүд хүүхдийг зориулалтын дагуу тээвэрлэдэггүй, бага насны хүүхдийг ганцааранг нь замын хөдөлгөөнд оролцуулдаг, эсхүл хүүхдийг хүүхдэд нь даатгаж /ах, эгчээр нь хүргүүлэх гм/ хөдөлгөөнд оролцуулдаг зэрэг байдлууд нь хүүхэд зам тээврийн осолд өртөхөд ихээр нөлөөлж байна.

7. Цахим орчин дахь хяналтгүй, сөрөг мэдээлэл. Мэдээллийн технологи, цахим орчин, гар утас нь хувь хүн, нийгмийн амьдралд шинэ дэвшлийг авч ирсэн хэдий ч энэ нь хүүхдийн тухайд садар самуун, хүчирхийлэл, гэмт хэргийн тухай санаа, сэдэл өгч, донтолт, ганцаардлыг бий болгох гол нөхцөл болсоор байна.

**Гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдийг насны түвшингөөр авч үзвэл:** 2021 оны эхний 7 сарын байдлаар насанд хүрээгүй гэмт хэрэгт холбогдогчдын 23 буюу 6.7 хувь нь эмэгтэй бол үлдсэн 93.3 хувь нь эрэгтэй хүүхдүүд үйлдсэн байна.[7]

Харин насны түвшингөөр нь авч үзвэл, 16-17 насны эрэгтэй 214, эмэгтэй 17, 15 хүртэлх насны эрэгтэй 106, эмэгтэй 6 гэсэн үзүүлэлттэй байна. Үйлдэгдсэн гэмт хэргийн 254 буюу 85.8 хувь нь хөнгөн, 142 буюу 42.2 хувь нь хүнд гэмт хэрэг ээлсэн. Үүнээс 72 хувь нь нийслэлд, 18 хувь нь орон нутагт бүртгэгдсэн.

7 https://police.gov.mn/home. Гэмт хэргийн 2021 оны эхний 7 сарын статистик тоо мэдээнээс хэсэгчилэн авав.

Гэмт хэргийн улмаас хохирсон, гэмтсэн, нас барсан хүн, насны бүлгээр, хүйсээр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар авч үзвэл:[8]

| Үзүүлэлт | Хохирсон хүн | | Гэмтсэн хүн | | Нас барсан хүн | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2020 1,2-р сар | 2021 1,2-р сар | 2020 1,2-р сар | 2021 1,2-р сар | 2020 1,2-р сар | 2021 1,2-р сар |
| 7 хүртэлх нас | 36 | 25 | 8 | 7 | 21 | 8 |
| 8-17 нас | 228 | 132 | 58 | 44 | 11 | 7 |
| 18-29 нас | 1619 | 872 | 468 | 353 | 31 | 27 |
| 30-39 нас | 2052 | 1207 | 515 | 428 | 48 | 47 |
| 40-49 нас | 1405 | 836 | 270 | 245 | 77 | 38 |
| 50-59 нас | 822 | 428 | 161 | 128 | 70 | 29 |
| 60-69 нас | 289 | 138 | 41 | 37 | 24 | 14 |
| 70 ба түүнээс дээш нас | 66 | 28 | 8 | 10 | 9 | 3 |
| эмэгтэйчүүд | 2724 | 1551 | 601 | 507 | 71 | 45 |

Гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2021 оны эхний 2 сард 3.7 мянга болж, 157 (4.3%) нь **18 хүртэлх насны хүүхэд**, 1551 (42.3%) нь эмэгтэйчүүд байна. Гэмт хэргийн улмаас 2021 оны эхний 2 сард 1252 хүн гэмтэж, 173 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс гэмтсэн хүн 277 (18.1%)-оор, нас барсан хүн 118 (40.5%) -аар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 2021 оны эхний 2 сард хохирсон 3666 хүний 25 (0.7%) нь **7 хүртэлх насных, 132 (3.6%) нь 8-17 насных**, 872 (23.8%) нь 18-29 насных, 1207 (32.9%) нь 30-39 насных, 836 (22.8%) нь 40-49 насных, 594 (16.2%) нь 50, түүнээс дээш насныхан байна.

**Гэр бүлийн орчин, эцэг, эх-хүүхдийн хүмүүжилд нөлөөлөх нь:**

Өнөөдөр манай улсын хувьд нийт хүн амын 34.6 хувийг 0-18 насны хүүхэд эзлэж байгаа бөгөөд хүүхдийн эрхийг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд гэр бүл, эцэг, эх бидний оролцоо хамгийн чухал юм. Учир нь хүүхдийн өв тэгш хүмүүжил, төлөвшилд гэр бүлийн халуун, дулаан уур амьсгал нэн чухал төдийгүй аз жаргалтай, бие биенээ ойлгодог, хүндэлдэг, сонсдог гэр бүлд хүүхэд бие бялдар, оюун ухааны хувьд өв тэгш хүмүүждэг байна.

Хүүхдийг зөв хүн болгон хүмүүжүүлэх, төлөвшүүлэх асуудал бол гэр бүл, эцэг эхээс шууд хамаардаг гэдгийг бид бүхэн мэддэг хэдий ч, өдөр тутмын алба, амины ажил гэж зүтгэсээр... нэг л мэдэхэд хүүхэд гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн улмаас эрх ашиг нь хохирох, хүчирхийлэлд өртөх, зам тээврийн осолд орох, хаягдах, төөрөх, архидан согтуурах, мансуурах,

8 Үндэсний статистикийн хорооны 2021 оны эхний 2 сарын тоо мэдээнээс хэсэгчилэн авав.

цахим тоглоомонд донтох, биеэ үнэлэх, гал түймэр, гол усны аюул, ахуйн осолд өртөх зэрэг олон асуудлын улмаас амь нас, эрүүл мэнд нь хохирсоор байна.

Монголчууд "Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа", "Буруу эрхэлсэн хүүхэд бухын хүзүүнээс ч хатуу" гэж сургадаг. Энэ нь хүүхдэд багаас нь хайр энэрлийг өгч, анхаарал, халамж тавьж, зөв дадал хэвшилтэй болгож хүмүүжүүлэхийн ач холбогдлыг цөөн үгээр илэрхийлсэн хэрэг. Хүүхдээ зөв хүн болгон хүмүүжүүлэх, төлөвшүүлэх, эрсдэлт нөхцлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах нь зөвхөн сайн эцэг, эхийн ухамсар, амьдралын туршлагатай холбоотой бус, бүх эцэг, эхчүүдийн хуулиар хүлээсэн заавал биелүүлэх ёстой үүрэг юм.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөдөр үйлчилж байгаа Зөрчлийн тухай хуульд "Хүүхдийн эрхийг зөрчих" гэсэн бүлгийг шинээр оруулж хүүхдийн эрхийг хангах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, хүүхдийн дэргэд архидан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хоёр зуун нэгжээс гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, дээрх үйлдлийн улмаас хүүхдийн эрүүл мэндэд хор уршиг учирсан, амь нас хохирсон бол Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлгийн 16.11 дүгээр зүйлд заасны дагуу дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна[7].[9]

Цагдаагийн байгууллагаас Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр Цагдаагийн албаны тухай хуулинд тусгайлсан заалтыг оруулж, холбогдох журмуудыг боловсруулан батлуулж, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр чиг үүргийнхээ хүрээнд хурал, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг, өдөрлөг, сургалт, сурталчилгааны ажлуудыг тасралтгүй зохион байгуулж, хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй хүүхдэд захиргааны хяналт тогтоох, хараа хяналтгүй хүүхдийн асуудлыг шийдэхэд туслалцаа үзүүлэх зэрэг ажлуудыг тогтмол зохион байгуулж байгаа боловч хүүхэд бүрт хүрч чадахгүй байгаа нь гэмт хэрэг өсөхөд нөлөөлдөг байна.

**Дүгнэлт:** Насанд хүрээгүй хүнээс гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэргийн халдлагад өртөж хохирсон талаарх нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тоймлон үзсэнээр дараах дүгнэлтэд хүрч байна.

- Манай улс орны хувьд насанд хүрээгүй хүн үйлдсэн гэмт хэргийн ихэнх хувийг хулгайлах гэмт хэрэг эзэлж байна. Хулгайлах гэмт хэрэг бол үндсэндээ хүн амын ажилгүйдэл, ядууралтай холбоотой ч гэр бүлээ тэжээх амьдралын аргагүй эрхэнд хулгай хийж байгаа хүүхэд тоотой хэд байх ч амар хялбараар мөнгө олох, зугаацах, мөнгө олж тоглоом тоглох зэрэг хүсэл сонирхолоор хулгайн гэмт хэрэг үйлддэг байна.

- Сүүлийн үед хүүхдийн хүмүүжил, ёс суртахууны төлөвшилөөс шалтгаалан бусдын бие махбодид хөнгөн, хүнд, хүндэвтэр гэмтэл санаатай болон санамсаргүйгээр гэмт хэрэг үйлдэж байна.

[9] Төрийн мэдээлэл. 2017. №24. Монгол Улсын зөрчлийн тухай хууль

- Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа нэгдмэл бус, зарим төрийн бус байгууллагууд гагцхүү ашиг олохын төлөө ажиллаж буй хандлага байгаа юм. хүүхдийн төлөө ажилладаг байгууллагууд хүүхдийн гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд оролцох нь дутмаг байна гэсэн дүгнэлтийг хийж байна.

**Санал.** Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хүүхдийн эрхийг хамгаалах, тэдний сурч боловсрох, чөлөөт цагийг өнгөрөөх, зөв төлөвшүүлэх чиглэлээр үнэ төлбөр багатай, үр дүнтэй сургалтыг дүүрэг, орон нутагт зохион байгуулж, эцэг, эх гэр бүлд нь эрх зүйн мэдлэг олгох;

2. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас цахим тоглоомын газруудад хяналт тавьж, зөвшөөрөгдсөн насны хүүхдүүдэд цагийн хязгаартай үйлчлэх.;

3. Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн сэтгэл зүйг засах мэрэгжлийн зөвөлгөө өгдөг байгууллагуудын үйл ажиллагааг төрөөс дэмжих, үйл ажилаагааг нь идэвхижүүлэх.

**Ашигласан материалын жагсаалт**


- Монгол Улсын Эрүүгийн хууль 2015 он
- Хүүхдийн эрхийн тухай хууль 2016 он
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2016 он
- Монгол улсын зөрчлийн тухай хууль 2017 он
- Үндэсний статистикийн хороо -2021 оны эхний 2 сарын байдлаар

# ПРАКТИКА НАЗНАЧЕНИЯ НАКАЗАНИЯ ЗА ЛЕГАЛИЗАЦИЮ (ОТМЫВАНИЕ) ДЕНЕЖНЫХ СРЕДСТВ ИЛИ ИНОГО ИМУЩЕСТВА, ПРИОБРЕТЕННЫХ ЛИЦОМ В РЕЗУЛЬТАТЕ СОВЕРШЕНИЯ ИМ ПРЕСТУПЛЕНИЯ, В РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ

***Бавсун М.В.***, заместитель начальника Санкт-Петербургского университета МВД России (по научной работе), доктор юридических наук, профессор

***Лупырь М.В.***, преподаватель кафедры уголовного права Омской академии МВД России, кандидат юридических наук

Для формирования четкого представления о том, как выглядит ситуация, связанная с применением санкций ст. 174[1] УК РФ, в 2019-2020 гг., нами были проанализированы в общей сложности более 140 материалов уголовных дел за указанный период[10]. По результатам анализа можно сделать предварительный вывод о том, что размер наказания за легализацию (отмывание) денежных средств или иного имущества, приобретенных лицом в результате совершения им преступления, как правило, зависит не от наличия или отсутствия смягчающих или отягчающих обстоятельств, относящихся непосредственно к совершаемому посягательству, а от тяжести предикатного преступления, исходя из которого определяется уровень общественной опасности действий, направленных на легализацию (отмывание) преступно приобретенного имущества.

В соответствии с ч. 1 ст. 174[1] УК РФ лицо, совершившее финансовую операцию или другую сделку с денежными средствами или иным имуществом, приобретенными им в результате совершения преступления, в целях придания правомерного вида владению, пользованию и распоряжению ими, подлежит ответственности в виде штрафа в размере до ста двадцати тысяч рублей или в размере заработной платы или иного дохода осужденного за период до одного года. Это единственный вид наказания, который предусмотрен за данное посягательство. Поскольку его нижняя граница не определена, то можно сказать, что штраф может быть назначен с минимальной суммы. По результатам анализа было установлено, что такая сумма в 2019 г. составила 10 тысяч, а в 2020 г. – 5 тысяч рублей, то есть минимально возможный размер в соответствии с ч. 2 ст. 46 УК РФ.

При этом за анализируемый период по части 1 ст. 174[1] УК РФ штраф назначался в следующих размерах:

1) от 10 до 80 тысяч рублей. Причем его размер зависел не от размера легализуемого имущества, а от тяжести предикатного преступления. Предикатными по части 1 ст. 174[1] УК РФ выступали составы преступлений, которые можно разделить на три группы:

1. Преступления против собственности: кража (ст. 158 УК РФ), мошенничество (ст. 159 УК РФ), присвоение или растрата (ст. 160 УК РФ);

2. Незаконные производство, сбыт или пересылка наркотических средств, психотропных веществ или их аналогов, а также незаконные сбыт или пересылка растений, содержащих

[10] Всего в 2019 г. было вынесено 355 обвинительных приговоров по ст. 174[1] УК РФ, а за 6 месяцев 2020 г. 132 обвинительных приговора суда. См. данные Судебного департамента при Верховном Суде Российской Федерации. Форма 10-А. URL: http://www.cdep.ru/index.php?id=79&item=5460; http://www.cdep.ru/index.php?id=79&item=5259

наркотические средства или психотропные вещества, либо их частей, содержащих наркотические средства или психотропные вещества (ст. $228^1$ УК РФ), и незаконный оборот сильнодействующих или ядовитых веществ в целях сбыта (ст. 234 УК РФ);

3. Превышение должностных полномочий (ст. 286 УК РФ) и получение взятки (ст. 290 УК РФ).

Для того чтобы проследить имеющиеся в назначении наказания за легализацию (отмывание) денежных средств или иного имущества закономерности, важно проиллюстрировать каждую из перечисленных групп предикатных преступлений. Так, характерным для первой группы может выступить приговор Ханты-Мансийского городского суда в отношении ФИО, обвиняемого по ч. 4 ст. 159 УК РФ в мошенничестве, а также в совершении преступления, предусмотренного ч. 1 ст. $174^1$ УК РФ, – легализации (отмывании) денежных средств, приобретенных им в результате совершения преступления, в сумме 980 тыс. рублей, он был привлечен к ответственности и понес наказание в виде штрафа в размере 10 тыс. рублей[11].

Из материалов другого уголовного дела, возбужденного по ч. 1 ст. $174^1$ УК РФ, в котором предикатным преступлением выступило получение взятки (ч. 6 ст. 290 УК РФ), следует, что общая сумма денежных средств, подвергнутых действиям, направленным на легализацию (отмывание), составила 750 тыс. рублей. Оценив все обстоятельства совершенного преступления, суд назначил обвиняемому наказание в виде штрафа в размере 50 тыс. рублей[12].

Из приговора, вынесенного Бузулукским районным судом Оренбургской области, следует, что ФИО обвинялся в совершении незаконного производства, сбыта или пересылки наркотических средств или психотропных веществ (ч. 3 ст. $228^1$ УК РФ), а также легализации (отмывании) денежных средств, приобретенных лицом в результате совершения предикатного преступления, на сумму 200 тыс. рублей. Исходя из данных обстоятельств, суд назначил обвиняемому наказание в виде штрафа в размере 80 тыс. рублей[13].

Таким образом, правоприменитель при назначении наказания за легализацию (отмывание) денежных средств или иного имущества, приобретенных лицом в результате совершения им преступления, исходит из общественной опасности предикатного преступления. В первом из приведенных примеров ч. 4 ст. 160 УК РФ относится к категории тяжкого преступления. Во втором примере ч. 6 ст. 290 УК РФ исходя из санкции статьи является особо тяжким преступлением. В третьем случае ч. 3 ст. $228^1$ УК РФ на основании санкции статьи выступает особо тяжким преступлением. В связи с этим можно предположить, что суд при вынесении приговора оценивал характер вреда, причиняемого при мошенничестве, объектом которого являются имущественные отношения, а также вреда, причиняемого при незаконном производстве, сбыте или пересылке наркотических средств или психотропных веществ, а в другом случае – при получении взятки, которые посягают на более значимые объекты.

---

[11] *Приговор* Ханты-Мансийского районного суда от 18 июня 2019 г. по делу № 1-207/2019. URL: https://sudact.ru/regular/doc/4oE7Rd5ZbOoZ/ (дата обращения: 02.10.2020).

[12] *Приговор* Октябрьского районного суда от 8 ноября 2019 г. по делу № 1-34/2019. URL: https://sudact.ru/regular/doc/Xis5xqTIZeo6/ (дата обращения: 02.10.2020).

[13] *Приговор* Бузулукского районного суда Оренбургской области от 18 июля 2019 г. по делу № 1[1]-261/2019. URL: https://sudact.ru/regular/doc/GIWSD8AKtIHC/ (дата обращения: 02.10.2020).

[71] Xianwen Wang, Chen Liu , Wenli Mao, Zhigang Hu & Li Gu. *Tracing the Largest Seasonal Migration on Earth.* 2014. https://www.researchgate.net/publication/267811689_Tracing_The_Largest_Seasonal_Migration_on_Earth.

[72] https://en.wikipedia.org/wiki/Tourism_in_Saudi_Arabia.

[73] https://vacayholics.com/list-of-most-crowded-beaches-in-world.

[74] https://tass.com/sport/1012057.

[75] http://superinfo.vn/detail/?id=1257&cate=12.

The overcrowding in these locations results in the complexity of crime in a short time compared to other times of the year. These events often create a favorable environment for criminal activities and attract criminals from other areas due to the concentration of high-value assets, people's carelessness in property management, chaos of social activities, loss of control by competent authorities, or increased demand for illegal acts.

In addition, these areas are also prone to accidents that cause many deaths or injuries. For example, a stampede incident at a water festival in Phnom Penh, Cambodia on November 23, 2010, resulted in 378 people killed and 755 injured[76]. The horrific trample on Mecca of Saudi Arabia on September 24, 2015, left at least 717 people dead and 450 injured[77]. On September 10, 2019, the path of Iman Hussein Temple, Iraq - where the ceremony was taking place collapsed, causing the crowd to flee, trampling, led to 31 deaths and more than 100 injuries[78].

*Secondly, level of crime to be considered "hot time"*

Up to now, there hasn't been any research that determines the criteria and complexity of crime at periods to be considered "hot time". When researching crime "hotspots", some authors have pointed out formulas or results to identify a "hotspot" of crime. For instance, in Minneapolis, only 3% of the addresses generated about 50% of citizen calls for service to the police[79]. Research by Wilpen Gor and Yong Jei Lee shows that in large cities around 50% of crime occurs in only 5% of a city's block-long street segments[80]. According to the Pareto principle (80/20), about 80% of the results come from 20% of the causes. Is it reasonable to hypothesize that 95% of crimes occur in about 5% of the time, or 20% of the time witnessing 80% of crimes compared to other periods? In this regard, there has not been a specific standard was established with a much high trust level. Applying the above formulas is also feasible to a certain extent, such as pointing out the times that are considered "hot", and taking special measures to control and cool down. However, leaving a certain time frame like 2 hours in 1 day, 2 days in a week, etc. accounting for 95% or 80% of crimes will definitely lead to serious consequences for crime prevention. In the author's viewpoint, the determination of a complicated period to be a "hot time" should be based on the reality, capability of the police agency, and the requirements of crime prevention strategy in each locality. Letting police units proactively identify "hot times" of crime will ensure flexibility and match their actual capabilities.

*Thirdly, classification of "hot time"*

The complexity of crime in general and each specific offense often fluctuates between different times of the day, week, month, or year. Some areas only become complicated for several days in a few years. Criminals also rely on actual conditions and ways of committing crimes to conduct acts, hence, its heat is also different from other crimes. The classification of "hot time" of crime can be divided into different time periods by hours, days, weeks, months, quarters, and years associated with each specific location. To understand deeply the rules of "hot times" and how they differ from other

---

[76] https://www.bbc.com/news/world-asia-pacific-11827313.

[77] https://www.nytimes.com/2015/09/25/world/middleeast/mecca-stampede.html.

[78] https://www.bbc.com/news/world-middle-east-49653401.

[79] Sherman, L., Buerger, M. and Gartin, P. *Repeat Call Address Policing: The Minneapolis RECAP Experiment*. Washington, DC: Crime Control Institute. USA., 1989.

[80] Wilpen Gor and Yong Jei Lee. *Chronic and Temporary Crime Hot Spots.* Routledge Publisher., 2017. p41.

periods, police agencies need to study for an appropriate period of time. The classification of "hot time" isn't applied similarly in all locations and years due to differences in geography, population, properties, environment, and crime situation among locations. It should be based on the goal of crime prevention, actual situation and research purpose. The goal of fighting drug-related crimes will be different from those of property-related crimes; furthermore, the level of complexity, the time rule of drug-related crime is not the same as that of property-related crime.

*Fourthly, the relation between "hot times" and "hotspots" of crime*

"Hotspots" of crime have been cared by many researchers through research works at different levels. Crime hotspots are areas with a much high concentration of crime than other areas. "Hotspots" are often approached from a geographical perspective. A hot spot can be determined as "a specific building", "a street address", "street segments"[81], car parks, markets, or bus stations, etc. Meanwhile, "hot time" is considered in terms of time. Crime "hot times" and "hotspots" are closely related, but there are also certain boundaries between them. "Hot time" can be considered part of "hotspot" studies because crimes committed during "hot time" are often done tied to specific locations. The sudden increase of crime during these periods contributes to the formation of "hotspots". Crime "hotspots" are often associated with one or a few specific locations and addresses which are limited or unlimited by geography. In contrast, "hot times" are not limited to crime "hotspots" but can be located in other areas with lower complexity of crime.

*Fifthly, the effectiveness of research on "hot times" of crime*

Researching and identifying sharp differences in the complexity and frequency of crimes between time frames allows the police agency to apply priority policies in hot periods. Some outstanding policies can be implemented such as strengthening management, patrolling, supplementing human resources and equipment, and disseminating laws to the people. Thereby, improving the ability of police units to control the situation, deter persons who intend to commit crimes, actively arrest and handle suspects, as well as raise people's awareness about crime self-prevention. The effectiveness of research on crime "hot times" is therefore indisputable. However, priority policies for crime "hot times" need to be focused on high complicated areas of crime. For less complex places, the research may not be absolutely necessary unless new complicated issues arise and there is a striking variation in crime between time frames. This is an important issue in order to save budget and ensure that policies are invested in focus.

*Sixthly, the combination of policies for crime "hot times" and "hotspots"*

As mentioned above, "hot times" and "hotspots" of crime are closely related, therefore, crime prevention policies need to link these two factors. Simultaneous application of measures to control and solve problems arising in both "hot times" and "hotspots" of crime will bring the highest efficiency. At the "hotspots" of crime, carrying out priority activities during "hot times" is also an essential issue. However, several crime "hotspots" may form and exist without unusual "hot times", some areas where "hot times" of crime arise but not in "hotspots", therefore, applicable policies need to be different.

---

[81] Lawrence W. Sherman, Stephen Williams, Barak Ariel, Lucinda R. Strang, Neil Wain, Molly Slothower, and Andre Norton. *An Integrated Theory Of Hot Spots Patrol Strategy: Implementing Prevention By Scaling Up And Feeding Back* //Journal of Contemporary Criminal Justice. 2014. Vol 30(2) 95–122. p98. (cited from Weisburd, Bushway, Lum, & Yang, 2004; Weisburd, Groff, & Yang, 2012).

### 3. Recommendations for the police agency

*First, conducting in-depth studies on "hot times" of crime*

The variation in crime between time periods is a problem that has appeared and existed for a long time associated with the change of crime. Social activities are increasingly changing, leading to the complexity of crime in a short period. There have not been many in-depth studies on "hot times" of crime in general; in particular, research on this issue has not been widely carried out in localities. Therefore, authorities, police agencies, and researchers need to conduct surveys on practice, assess the crime situation at different periods to determine "hot times". The scope of researches may be limited according to the targeted purpose, and the location where the research products will be applied. The objective is to identify and classify the frequency and extent of crime occurrence between different time periods within the time limits of the study, recognize when crimes occur the most, the least and other levels according to specific criteria. Each area and type of crime often has its own rule of time, so studies need to approach definite specific area and crime group. Besides, studies must point out the causes and conditions that form crime "hot times" , and propose core solutions to cool down and eliminate their existence.

*Secondly, applying priority policies in "hot times"of crime*

Identifying "hot times" is considered a significant way for the crime prevention strategy of each country. It is possible to consider priority solutions such as strengthening "directed patrols, proactive arrests, and problem-oriented policing[82]", installing security surveillance cameras, applying professional measures, calling on community, organizations, and individuals for support, eliminating the causes or conditions of crimes or violations in the above areas and periods. It is noteworthy that priority policies for "hot times" of crime only need to be strengthened for a certain period, after that the policies can be terminated or adjusted back to normal. Therefore, the police and other law enforcement agencies just need to change personnel, equipment or apply temporary solutions to control well during the necessary times. Temporary police units need to be organized at the places concentrated a huge number of visitors at certain times. These temporary police units are set up on the basis of mobilizing manpower, means, and facilities from other police units in a certain period according to actual demand. Another important requirement is that before big events take place, the police agencies must evaluate deeply the situation, predict the number of participants to plan and mobilize a reasonable human resource.

*Thirdly, building and improving crime mapping software associated with information about different time periods*

Instead of performing manual analysis as before, analyzing crime situation through computer software is a trend that has been widely applied in many countries around the world. A properly designed crime map will display information about the frequency of crimes occurring at different time frames. The software will automatically analyze, set up comparison charts and bring out conclusions based on the updated data. The analysis includes crime data at time frames, identifies the duration with the highest frequency of crimes and compares with other ones. At the same time, software using artificial intelligence can also assess the causes of "hot times" and offer preliminary solutions to

[82] Eck. 1997. 2002; Braga. 2002; Weisburd and Eck. 2004.

overcome the situation. In order to develop crime mapping software, police agencies need to strengthen cooperation and consult the authorities of countries that have a lot of experience in operating crime mapping software as well as based on the actual situation and national law.

***Figure 1. Frequency of crimes during a week in San Diego of the US***




*Resource: https://www.crimemapping.com/map*

*Fourthly, eliminate and minimize the causes and conditions leading to the formation and existence of crime "hot times"*

As noted, "hot times" often appear and remain associated with its causes and conditions. Therefore, the police need to clarify the factors that form "hot times" after gathering statistics on crimes in different time frames. At the same time, applying solutions to eliminate the roots for their existence such as petitioning competent authorities to adjust social activities, change traffic routes, install more lights in public places, or guide people to protect themselves and their property, etc. It is extremely difficult to reduce the concentration of people and crime in places where the "hot times" maintain for a long time because of cultural and historical, and religious factors. Therefore, it is necessary to implement solutions to minimize the possibility of crime, not to let the crime situation become more complicated, but still have to ensure that social activities take place normally.

# ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН СТРЕССИЙН ТҮВШИН, АЛБА ХААГЧДЫГ СӨРӨГ СТРЕССЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

***Д.Бат-Эрдэнэ***
*ДХИС-ийн магистрант,*
*цагдаагийн хошууч*

**Товчлол.** Стресс гэж хүнд гаднаас үйлчилж буй эерэг сөрөг хүчин зүйлийн үйлчлэлээр хүний бие организмаас хамгаалах хариу урвалыг хэлнэ. Хүн ямарваа аюулыг мэдрэх үед бие махбодь нь богино хугацаанд хамгаалалтын нөхцөл рүү автоматаар шилжиж, тэмцэх эсвэл зугатах гэсэн стрессийн хариу үйлдлийг үзүүлдэг байна.

Энэхүү өгүүлэлд стрессийн тухай ойлголт, цагдаагийн алба хаагчдын стрессийн түвшин, алба хаагчдыг сөрөг стрессээс урьдчилан сэргийлэх чиглэлээр удирдлагын зүгээс авч хэрэгжүүлбэл зохих зарим асуудлыг хөндсөн болно.

**Түлхүүр үг:** Стресс, нейротизм, эерэг стресс, сөрөг стресс.

**Үндсэн хэсэг.** Стресс, хамт олны дундах стрессийн түвшинг судлахын өмнө стрессийн талаарх зарим ойлголтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Стресс гэдэг нь англи үг бөгөөд сэтгэцийн “дарамт, ачаалал” гэсэн утгатай. Стрессийн хамгийн үнэнд ойртсон тодорхойлолт нь Стресс гэдэг нь организмд ямар нэг гадаад болон дотоод цочроогчоос үүсч байгаа нөлөөллийн бие болон оюун санааны хариу үйлдэл юм. Өөрөөр хэлбэл стресс нь хэрэгцээ нь хувь хүний дайчилж болох хувийн болон нийгмийн нөөцөөс хэтэрлээ гэдгийг ухамсарлах мэдрэмж эсвэл нөхцөл юм.

Шинж тэмдэг нь ерөнхийдөө бие махбодь, сэтгэлийн хувьд тайван бус байх явдал юм. Гэхдээ стресс нь заавал сөрөг үзэгдэл байх албагүй. Учир нь зарим стресс нь хүнийг хөгжүүлж, амжилттай ажиллахад нь нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл та түүнийг хэрхэн хүлээж авч байгаагаас шалтгаалдаг.[83]

Стрессийг дотор нь “эерэг” болон “сөрөг” стресс гэж ангилдаг бөгөөд эерэг стресс нь хийж бүтээх, тэмүүлэх эрч хүч өгдөг, харин сөрөг стресс нь бидний сэтгэл зүйн тогтвортой байдлыг алдагдуулж, уур бухимдал, гутралд оруулдаг.

Стессийг мөн бие махбодийн, сэтгэлийн гэж ангилж үздэг. Бие мах бодийн стресс хүн, амьтанд хоёуланд нь үүсдэг бөгөөд амархан тайлагдаж сэргэх боломжтой. Харин сэтгэл санааны стресс нь илүү хоруу чанартай бөгөөд хүнд удаан хугацаагаар хадгалагддаг, зөвхөн оновчтой үг, үйлдэл, үйл хөдөлгөөн зэргээр тайлагдах боломжтой.”[84] гэжээ.

Хүмүүсийг гадаад орчинтойгоо харилцах шинж чанараар ерөнхийд нь: экстраверт болон интроверт, мөн сэтгэл хөдлөлийн шинж чанараар нь өндөр болон нам нейротизмтэй гэж ангилж авч үздэг. /*Экстраверт – гадаад орчин түүнд илүү сонин, Интроверт – дотоод*

[83] https://oat.mn/post-31154/

[84] Э.Бямбажаргал нар., Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын стрессийн түвшинд хийсэн судалгааны тайлан. УБ., 2020.

*орчиндоо амьдрах дуртай хүн./*[85] Энэ нь бидний нэрлэж заншсанаар "гадагшаа" болон "дотогшоо" чиглэсэн хүнийг тодорхойлж байна гэсэн үг юм.

Стрессийг бие махбодод үзүүлж буй нөлөөллийн байдлаар нь:

а. Физиологийн

б. Сэтгэлзүйн

в. Мэдээллийн стресс гэж 3 ангилдаг.

**Физиологийн стресс:** Сэтгэл түгшилтийн голомт уураг тархинд байснаар зүрх, судас, сэтгэцийн өвчин, ходоод гэдэсний шархлаа зэрэг стрессийн гаралтай өвчин үүсэх үндсэн нөхцөл нь болдог. Илрэх шинж тэмдэг нь:

1. Гарын алга хөлрөх
2. Даралт ихсэж зүрх дэлсэх
3. Хүзүү нуруугаар хөших
4. Амархан ядрах
5. Толгой өвдөх
6. Хоолны дуршил буурах
7. Нойр хулжих
8. Амьсгал бачуурах гэх мэт.

**Сэтгэлзүйн стресс:** Гайхах, сэтгэл түгших, уурлаж бухимдах зэрэг сөрөг сэтгэл хөдлөлөөс болж үүсдэг. Илрэх шинж тэмдэг нь:

1. Уурлах
2. Сэтгэл зовох
3. Сэтгэл санаа тогтворгүй болох
4. Эргэлзэх
5. Өөртөө итгэлгүй болох
6. Гэмших
7. Гутрах
8. Ганцаардах

**Мэдээллийн стресс:** Хэт их ачаалал нь мэдээллийн стрессийг үүсгэдэг байна. Илрэх шинж тэмдэг:

1. Амархан уйлна
2. Хумсаа мэрж, шүдээ хавирах
3. Архи, мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэх
4. Төрөл бүрийн хорт зуршилтай болно
5. Хэт их иднэ
6. Хүчирхийлэл үйлдэнэ
7. Зөрүүдлэнэ

**Нийгмийн хувьд:**

- Бусдаас хөндийрнө.
- Бусадтай харилцахад бэрхшээлтэй болно.
- Ажил сургуулиасаа залхаж олон дахин солино.
- Зохион байгуулалтгүй болно.[86]

[85] http://mhri.mn/news/3600/

Стрессийн үйлчлэх механизм 3 үе шаттай явагддаг:

1. Түгшүүрийн үе: Бие махбодид стрессийн илрэлүүд бий болж эсэргүүцэх чадвар нь буурч ирнэ.

2. Эсэргүүцэх чадвар нэмэгдэх үе: Дахин давтагдсан үйлчилгээнд бие махбодь дасан зохицдог. 1-р үед илэрч байсан шинж тэмдгүүд арилж, дасан зохицолтыг харуулсан өөрчлөлт бий болж эсэргүүцэх чадвар нь нэмэгддэг.

3. Эцэж цуцах үе: Удаан үргэлжилсэн стресс нь хүч барагдуулж яваандаа эхний үед байсан шинж тэмдгүүд дахин илэрч эхэлдэг.

Стресс нь ерөнхийдөө өнчин тархинд байх *гипоталамус*-аас адреналин өндөр түвшинд ялгарснаар үүсдэг. Ингэснээр бие махбодийн дархлалын систем суларч өвчин эмзэг болдог.

Стресс үүсгэх хүчин зүйлийг үндсэнд нь гадаад ба дотоод гэж 2 ангилдаг:

1. Гадаад хүчин зүйл:

а. Хүрээлэн байгаа орчин , Дуу чимээ, Давчуу орон зай, Цаг агаарын таагүй байдал

б. Нийгэм хамт олны хүчин зүйл, Хэрүүл маргаан, Дотны хүн өвдөх, Будлиан

в. Амьдралын томоохон үйл явдалтай, холбоотой хүчин зүйл, Гэр бүл болох, Гэр бүл салах, Гэр бүлд шинэ хүн нэмэгдэх, Ажилгүй болох

г. Өдөр тутам тулгарч байдаг аар саар зүйлс, Цагаасаа хоцрох, Эд зүйлсээ алдах, гээх, Эд зүйлс эвдрэх гэх мэт.

2. Дотоод хүчин зүйлс:

а. Өдөр тутмын амьдралын хэв маягтай холбоотой , Архи, тамхи, кофе хэтрүүлэн хэрэглэх, Хэт их ачаалалтай ажиллах

б. хүний сэтгэлзүйн онцлогтой хүчин зүйлс, Өөрийгөө хэт шүүмжлэх, Өөрийгөө хэт буруутгах, Хөшүүн удаан сэтгэлгээтэй байх, Бодитой бус итгэл найдвар тавих, Аливаа юмтай хэтэрхий удаан зууралдах гэх мэт.

Өөрөөр хэлбэл стресс нь аливаа өөрчлөлтөд хүний биеийн үзүүлж буй тодорхой бус хариу үйлдэл юм. Стресст үзүүлэх хариу үйлдэл хүн бүрт ялгаатай учир бүх хүнд таарах стресс менежментийн арга гэж үгүй. Стресс менежмент гэдэгт боломжтой бол стресс үүсгэж буй нөхцөл байдлаа өөрчлөх, боломжгүй бол өөрийн үзүүлж буй хариу үйлдлээ өөрчлөх, өөртөө анхаарал тавих, амарч тайвшрахад цаг гаргах зэрэг багтана.

Стрессийг зохицуулах эрүүл бус аргууд нь богино хугацаанд стрессийг арилгах ч урт хугацаанд бүр илүү хор хохирол учруулдаг байна. Жишээ нь:

- Тамхи татах;
- Архи уух;
- Хэтрүүлэн идэх;
- ТВ, компьютерийн өмнө хэт их цагийг өнгөрөөх;
- Гэр бүл, найз нөхөд болон нийгмийн бусад арга хэмжээнээс хөндийрч, зугтах;
- Эм, мансууруулах бодис хэрэглэн тайвшрах;
- Хэт их унтах;
- Ажлаа хойшлуулах;
- Асуудалтай нүүр тулахгүй байх;

[86] https://oat.mn/post-31154/

- Бусдад стрессээ гаргах;
- Стресстэй тэмцэх стратеги.

Ерөнхийд нь үйлдлийн, сэтгэлийн, хүлээж авах стратеги гэж 3 ангилдаг:

Үйлдлийн стратеги – Энэ нь нөхцөлдүүлж байгаа шалтгааныг арилгахын тулд нөхцөл байдал, орчныг солих арга хэмжээ явдал юм.

Сэтгэлийн стратеги – Нөхцөл байдлыг өөрчилж чадахгүй бол өөрөөр тайлбарлах, ухамсарлах.

Хүлээж авах стратеги – Нөхцлийг өөрчилж өөрөөр тайлбарлах боломжгүй бол хүлээн зөвшөөрч эвлэрэх.

**Ажлын байрны стресс.** Ажил хийж байсан хүн бүр ямар нэгэн байдлаар ажилтай холбоотой стрессийг мэдэрдэг. Та тухайн хийж байгаа ажилдаа дуртай байсан бага зэргийн стресс үүсдэг. Богино хугацаанд ажлыг биелүүлэх болон бэрхшээлтэй ажил үүргийг биелүүлэхийн тулд сэтгэлзүйн дарамтанд орж болзошгүй. Хэтэрхий ажлын стресс хүндрэхэд энэ бие махбодийн болон сэтгэл санааны хувьд ч хор хөнөөлтэй байдаг.

Ажлын байран дээр стресс үүсэх зарим хүчин зүйлүүдийг авч үзвэл:

- Цалин багатай байх;
- Хэт их ачааллалтай байх;
- Өсөж дэвших боломж бага байх;
- Сонирхол татахаар биш, Хэт төвөгтэй ажил;
- Нийгмээс, хамт олноос ирэх дэмжлэг дутмаг байх;
- Ажил дээр шийдвэр гаргах боломж бага байх;
- Ажилчдын хоорондын харилцаа буюу нийгэм сэтгэл зүйн уур амьсгал таагүй байх;
- Ажил хөдөлмөрт нь зохих үнэлгээг өгөхгүй байх.

Ажлын байрны стресс нь гэртээ харихад алга болдоггүй. Стресс үргэлжлэх ба таны эрүүл мэнд, сэтгэлзүйн сайн сайхан байдалд ихээхэн нөлөөлдөг.

Стресс нь толгой өвдөх, гэдэс өвдөх, нойргүйдэх, уурлах, төвлөрөхөд төвөгтэй болох зэрэг шинж тэмдгүүд үүсдэг. Архаг стрессийн улмаас сэтгэл гутрал буюу **депресс** үүсэхэд сэтгэлийн түгшүүр үүсч, нойргүйдэх, цусны даралт ихсэх, дархлаа сулардаг.

Энэ нь сэтгэлийн хямрал, таргалалт, зүрхний өвчин зэрэг эрүүл мэндийн байдалд нөлөөлж болно. Асуудлыг улам хүндрүүлснээр хэт их стресст орсон хүмүүс хэт их идэх, эрүүл хоол хүнс идэх, тамхи татах, хар тамхи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх зэрэг эрүүл бус аргаар асуудлыг шийддэг. [87]

Монгол хүмүүсийн нейротизмын үзүүлэлт дунджаар 15,4, Европын улс орны хүмүүсийн үзүүлэлт дундажаар 9,8 байдаг.[88]

Монгол Улсад тээврийн хэрэгсэлийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаатай холбогдон замын цагдаагийн  нэг алба хаагчид ногдох тээврийн хэрэгсэлийн болон зам тээврийн осол, хэрэг, дуудлагын тоо нэмэгдэж, улмаар алба хаагчдын ажлын ачаалал ихсэж гэр бүл, эрүүл мэнд, өөрийгөө хөгжүүлэх, сурч боловсрох цаг зав багасч байгаа нь албанаас чөлөөлөгдөх,

[87] http://rtcc.mrtd.gov.mn/57/item/312

[88] Э.Бямбажаргал нар., Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын стрессийн түвшинд хийсэн судалгааны тайлан. УБ., 2020.

дутагдлаар халагдах улмаар сэтгэл зүйн тогтворгүй байдалд орох зэрэг сөрөг үр дагавруудыг бий болгож байна гэж үзэж болохоор байна.

2019 онд Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/121 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь “Сэтгэл санааны ерөнхий байдал, ажлаас халшрах хам шинжийн түвшинг тодорхойлох” багц судалгааг Улаанбаатар хотын цагдаагийн хүрээний алба, нэгж, байгууллагуудын нийт 3491 алба хаагч нарын дунд судалгаа явуулсан.

Судалгаанд алба хаагчдын 23.4 хувь 23,4 хувь нь ажлаас халшрах хам шинжийн мэдэгдэхүйц болон өндөр өөрчлөлттэй гэж үзсэн 815 алба хаагч, тэр дундаа ажлаас халшрах хам шинжийн өндөр өөрчлөлттэй нэр бүхий 150 алба хаагч хамрагдан судлагдсан.

Судалгаагаар ажлаас халшрах хам шинж бүхий сэтгэл зүйн байдлаас үүдэн алба хаагчийн үйл байдалд өөрчлөлт орж, бие организмд хоруу чанар илэрсэн. Тухайлбал, хоолны дуршил өөрчлөгдөх, нойрны хэмнэл гажих, нийгмийн хандлага нь бусадтай харилцах харилцааны үнэлэмж буурсан, бухимдал ихтэй, оновчтой шийдэл гаргах хэдий ч ихэнх тохиолдолд асуудалд зэрэг сэтгэлгээгээр хандахаа болих, шийдвэр гаргах үед эргэлзэж, өөртөө хэт өндөр хяналт тавих зэрэг хандлага илэрдэг болсон. Зарим тохиолдолд ажил, амралтаа зохицуулах тал алдагдаж, ажилд зориулагдсан мэт хэт улайрах эсвэл хайнга хандах, бага ажилд хэт их хүч шавхан ажиллах зэрэг байдал илэрсэн байна.

Иймд Цагдаагийн алба хаагчийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, сэтгэл зүйн тулгамдсан асуудлаас урьдчилан сэргийлэхэд байгууллагын болон хувь стресс менежментийг зөв төлөвлөн, зохион байгуулах шаардлага зүй ёсоор тулгараад байна.

**Монгол Улс дахь стрессийн түвшин**

Дэлхийн эдийн засгийн судалгааны “Блүмберг” төвөөс олон улсын стрессийн түвшинг нийт хүн амын дундах ажилгүйдлийн түвшин болон дундаж насжилттай уялдуулан судалсан байна. Энэхүү судалгаагаар хамгийн их стрессийн түвшин өндөртэй 15 улсыг сонгон авсан бөгөөд манай улс Нигериа, Өмнөд Африк, Елсалвадор улсын дараа 4 дүгээрт жагссан байна. /Хүснэгт-1/

*Хүснэгт-1. Хамгийн их стресст автсан орнууд*[89]

| NK | COUNTRY | SCORE | UR(%) | LE (YRS) |
|---|---|---|---|---|
| 1 | Nigeria | 70.1 | 23.9 | 53 |
| 2 | South Africa | 70.0 | 25.7 | 58 |
| 3 | El Salvador | 57.6 | 5.7 | 72 |
| **4** | **Mongolia** | **55.4** | **6.1** | **68** |
| 5 | Guatemala | 55.1 | 4.1 | 69 |
| 6 | Colombia | 53.6 | 10.3 | 78 |
| 7 | Pakistan | 52.7 | 9.2 | 67 |
| 8 | Jamaica | 52.3 | 13.0 | 75 |
| 9 | Macedonia | 52.0 | 30.0 | 75 |
| 10 | Bolivia | 51.5 | 5.4 | 67 |

[89] Bloomberg, 2013 (via United Nations Office on Drugs and Crime, International Monetary Fund, Central Intelligence Agency World Factbook, Transparency International, World Health Organization)

| | | | | |
|---|---|---|---|---|
| 11 | Iran | 51.4 | 13.4 | 73 |
| 12 | Venezuela | 51.1 | 7.8 | 75 |
| 13 | Bosnia and Herzegovina | 50.2 | 27.0 | 76 |
| 14 | India | 48.9 | 9.9 | 65 |
| 15 | Egypt | 46.4 | 13.6 | 73 |

**Тайлбар:** UR=Ажилгүйдлийн түвшин буюу Unemployment Rate (%), LE=Насжилт буюу Life Expectancy (years at birth)

Мөн дээрх судалгааны үр дүнг газрын зураг дээр байрлуулж, хамгийн их стресстэй улс, орнуудыг улаан өнгөөр ялгасан байна. /Зураг-1/

*Зураг-1. Улс, орнуудын стрессийн түвшин*




Дээрх судалгааны үр дүнгээс харахад манай улс нь бусад улс, орнуудтай харьцуулахад нийт хүн амын дунд стрессийн түвшин харьцангуй өндөр байна.

Тэр дундаа хууль сахиулах чиг үүргийн хүрээнд нийгмийн хамгийн стресстэй хэсэгт ажилладаг цагдаагийн алба хаагчдын стресст өртөх байдал ямар түвшинд байгаа талаар авч үзье.

**Цагдаагийн алба хаагчдын стрессийн түвшин**

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сэтгэл зүйчдийн багаас 2020 онд хийсэн судалгаагаар “Цагдаагийн алба хаагчдын 35,6 хувь нь нейротизм өндөр, өөрөөр хэлбэл сэтгэлийн хөдөлгөөний хариу үйлдэл их, санаа зовох, ургуулан бодох хандлагатай, аливаа зүйлийг эмзэг хүлээн авдаг.

Цагдаагийн 508 алба хаагчаас авсан судалгааны дүнгээр: Алба хаагчдын 28,8 хувьд сэтгэл зүйн ачаалал ихсэж, энэ нь ажиллах бүтээмжид нөлөөлөх эрсдэлтэй, 29,3 хувьд невроз буюу архаг ядаргаанд нийт оролцогчдын 38,5 хувьд ядарсан, бие хүмүүс хоорондын болон өөрийг нь зовоосон дотоод асуудлаас үүдэлтэй стресс илэрч байна. Харилцаанд 44,9 хувьд нь түрэмгийлэл илэрдэг[90] гэсэн байна.

Өөрөөр хэлбэл манай улсын нийт иргэдийн дунд стрессийн түвшин харьцангуй өндөр бөгөөд тэр дундаа цагдаагийн алба хаагчдын стрессийн түвшин улам их байдаг нь ажиглагдаж байна.

Түүнчлэн тухайн алба хаагчийн сэтгэл зүйн онцлогоос шалтгаалж, интроверт /дотоод орчиндоо амьдрах дуртай/ хэлбэрийн алба хаагчдын хувьд нийгмийн зүгээс болон удирдлага, хамт олны зүгээс ирэх сэтгэл зүйн дайралтыг тэсвэрлэхэд илүү бэрхшээлтэй байх нь тодорхой.

**Байгууллагын стрессийг удирдах, түүнээс урьдчилан сэргийлэх нь:**

Аливаа асуудалд их санаа зовсоны хэрээр хялбар шийдэгддэггүй бөгөөд удирдлагын зүгээс тухайн алба хаагчийг өргөсөн тангарагтаа үнэнч, цагдаагийн алба хаагчийн ёс зүйг мөрдөж, хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллахыг үүрэг болгож, алдаа гаргасан тохиолдолд хүлээх хариуцлагыг урьдчилан анхааруулах замаар хариуцлагын механизмыг хэрэгжүүлж байгаа нь тухайн алба хаагч үүргээ гүйцэтгэх явцдаа алдаа гаргахаас урьдчилан сэргийлэхэд хэтэрхий их анхаарч, үйл хөдлөл бүртээ няхуур ажиллах шаардлага үүсдэг нь угтаа стрессийн үндэс суурийг тавьж байна.

Өөрөөр хэлбэл удирдлагын зүгээс алба хаагчдын өдөр тутмын ажил үүрэгт хяналт тавьж, “айдсаар удирдах” явдал түгээмэл байгаагаас шалтгаалан алба хаагчид ажилдаа дур сонирхолгүй болох, ажлын бүтээмж муудаж, өөрийн санаачлагаар ажиллах идэвхи буурахад нөлөөлж байна.

Түүнчлэн албан ажлаа зохих ёсоор, эсхүл сайн гүйцэтгэсэн тохиолдолд зөвхөн цалинг нэмэх байдлаар урамшуулдаг гэсэн ойлголт түгээмэл байгаа бөгөөд төсөв санхүүгийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан тэр бүр цалинг нь нэмж чаддаггүйгээс тухайн алба хаагчид ямар нэгэн мотиваци өгч чаддаггүй.

Зүй нь алба хаагчийг үүргээ сайн гүйцэтгэсний төлөө хамт олны өмнө сайшаах, эсвэл өөрт нь урмын үг хайрлах, магтах зэргээр эерэг үйлдлийг нь сайшааж хэвших нь удирдлагын багт ажиллаж буй албан тушаалтны зайлшгүй эзэмших ёстой зан үйл юм.

Мөн удирдах албан тушаалтан өөрийн харъяа нэгжийн сэтгэл зүйчидтэй ойр ажиллаж, алба хаагчдын сэтгэл зүйн байдал, тэдний юу хүсч, мэдэрч байгааг ойлгож авахаас гадна стрессээс өөрийгөө хамгаалах арга, дадалд алба хаагчдаа сургах нь тухайн байгууллагын стрессийг удирдах, түүнээс урьдчилан сэргийлэх хамгийн чухал алхам бөгөөд удирдагчийн хувьд манлайллаа хэрэгжүүлэх хамгийн гол шалгуур байх учиртай.

Стрессийг удирдах 7 арга байдаг талаар эмчид зөвлөдөг. Тухайлбал:

1. Хөдөл. Дасгал хөдөлгөөн хий.
2. Нийгмийн идэвхитэй бай.

3. Шаардлагагүй стрессээс зайлсхий. Стресс нь таны мэдрэлийн системээс автоматаар үзүүлж буй хариу үйлдэл боловч зарим стресс үүсгэгч хүчин зүйлүүдийг урьдчилж мэдэх

[90] Э.Бямбажаргал нар., Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын стрессийн түвшинд хийсэн судалгааны тайлан. УБ., 2020.

боломжтой байдаг. Энэ тохиолдолд стресс үүсгэж буй нөхцөл байдлыг өөрчил, эсвэл өөрийн хариу үйлдлээ өөрчлөөрэй.

4. Нөхцөл байдлыг өөрчил. Сэтгэл хөдлөлөө нууж, хадгалаад байлгүй илэрхийл. Харилцан буулт хий. Цагаа зөв зохицуул.

5. Стресс үүсгэгчид дасан зохиц. Асуудлыг өөрөөр хар. Асуудлыг цаад шалтгааныг хай. Өөрийн шалгуураа өөрчил.

6. Өөрчилж чадахгүй бол хүлээн зөвшөөр. Бүх зүйлийг хянаж, удирдана гэдэг боломжгүй. Уучилж сур.

7. Амралт, зугаа цэнгэлд цаг гарга.[91]

Стэнфордын их сургуулийн судлаачдын судалснаар ажлын байраа алдах вий гэсэн санаа зоволт эрүүл мэндээ муутгах нөхцлийг 50 хувиар, хэт их шаардлага тавьсан буюу ачаалалтай ажил өвчлөлийг 35 хувиар нэмэгдүүлдэг гэж үзжээ. Ийм нөхцөлд ажилтан ажиллах дургүй, сонирхолгүй байдгийг судалгаагаар нотолжээ. Цаашлаад дарамт нь хэтэрсэн, зохицуулах боломжгүй үед стресст оруулж тэдний эрүүл мэнд ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлдөг байна.[92]

**Дүгнэлт.** Ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэх явцад ажиллах нөхцөл, ажлын ачаалал, хамт олны уур амьсгал, харилцаанаас тэдний сэтгэл санаа, бие организмд үүссэн дарамт, түүнийг даван туулах, дасан зохицох гэсэн хүч энерги бүхий хариу үйлдлийг ажлын байрны стресс гэж үздэг юм байна.

Аливаа хүн страстэй байх юм бол ямар ч ажил хийсэн үр дүн муутай байх юм байна. Нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, сөрөг энерги агуулсан этгээдтэй хамгийн түрүүн уулзаж учирдаг хүн бол цагдаагийн алба хаагч юм байна. Тиймээс цагдаагийн алба хаагчид стрессээс өөрийгөө хамгаалах арга, дадалд маш сайн суралцсан байх шаардлага тулгарч байна.

**Санал.** Дээрхи дүгнэлт дээр үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. үүнд:

1. Алба хаагчдын зөв зан үйлийг материаллаг зүйлээс бусад хэлбэрээр урамшуулж хэвших;

2. Удирдлагын зүгээс сэтгэл зүйчээр дамжуулан алба хаагчдын хүсэл сонирхлыг байнга сонсож, стресст өртүүлэхгүй байхад анхаарах;

3. Алба хаагчид стресснээс салах, урьдчилан сэргийлэх уламжлалт аргуудыг зааж өгөх сургалтыг жил бүр явуулж байх;

4. Алба хаагчдыг айдсаар биш урам зоригоор удирдаж, байгууллагын зорилго, зорилтын төлөө хамт олныг идэвхижүүлж, зорилгыг нэг зүгт хандуулах.

[91] http://andlog2.blogspot.com/

[92] https://www.facebook.com/458008187934323/posts/935019040233233/. Монголын урлагын сэтгэл заслын мэргэжлийн холбоо

## Ашигласан материал


1. Э.Бямбажаргал нар., Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын стрессийн түвшинд хийсэн судалгааны тайлан. УБ., 2020.
2. Bloomberg, 2013 (via United Nations Office on Drugs and Crime, International Monetary Fund, Central Intelligence Agency World Factbook, Transparency International, World Health Organization)
3. https://www.facebook.com/hashtag/ монголын сэтгэл зүй сэтгэц хэмжил зүйн үндэсний хүрээлэн
4. http://mhri.mn/news/3600/
5. https://oat.mn/post-31154/
6. http://andlog2.blogspot.com/
7. http://rtcc.mrtd.gov.mn
8. https://www.facebook.com

# ЭРТНИЙ МОНГОЛ УЛСЫН ЗЭР ЗЭВСЭГЛЭЛ, ОРЧИН ЦАГИЙН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ТҮҮНИЙ ХАРЬЦУУЛАЛТ

**Б.Алтанцэцэг**
*ДХИС-ын магистрант,*
*цагдаагийн ахмад*

**Товчлол.** Эртний монгол улсууд нь хөнгөн болон хүнд морин цэрэгтэй байсан бөгөөд зэр зэвсэг нь дуулга, хуяг, жад, илд, сэлэм, ялтсан хуяг, нум сумыг хэрэглэж ирсэн түүх нь эдүгээ цагийг хүртэлх хугацаанд Монголын цагдаагийн байгууллагад уламжлагдан ирсэн эсэхийг харьцуулан дүгнэв.

**Түлхүүр үг:** түүх, цэрэг, цагдаа, тусгай хэрэгсэл, чиг үүрэг, зэвсэг, техник, дайн, арга, хэрэгсэл

**Удиртгал.** Дэлхий дээр улс болон тогтнох явдал бол эх түүхээсээ улбаатай бөгөөд өөрийн улс үндэсний түүхийг хүн бүр мэдэж байх нь тухайн улс орныг батлан хамгаалах нэг арга болой. Улс үндэстэн түүх соёл, газар шороо, эх нутгаа эрхэм чухлыг мэдэж ухах аваас монгол хүн бүхэн улс төр үндэс угсаа, газар шороогоо хамгаалах хүсэл эрмэлзэлтэй болох амуй. Монголын түүх гэдэг нь монгол үндэстний анх сонсогдож мэдэгдэх ба түүхэнд тэмдэглэгдэх болсон цагаас эхлэн өгүүлэх аваас бодитой бүрэн бүтэн түүх хэмээж болно. Түүхийг бүтээхэд тухайн үед оршин тогтнож байсан улс орны цэрэг, зэвсэглэл гол хүчин зүйл нь болж иржээ. Аливаа улсын цэргийн хүчирхэг байх зүйл бол зэвсэг бөгөөд түүний түүхээс харахад уламжлагдан ирсэн дэвшилтэт технологитой, хамгаалах хэрэгсэл сайтай, нарийн бүтэц хийцтэй байдаг байна. Иймд цагдаагийн байгууллагын түүхэнд ашиглагдаж байсан тусгай хэрэгсэл нь эртний монгол улс, аймгуудаас эхлэлтэй юу? гэдэг асуултыг цагдаагийн байгууллагын түүхт 100 жилийн ойгоо угтан асуух нь зөв болой. Тэр дундаа эртний улсуудын чиг үүрэг, зэр зэвсэгийг орчин цагийн цагдаагийн байгууллагын техник хэрэгсэлтэй хэрхэн холбогдохыг судлахад оршино.

## Үндсэн хэсэг

Монголын түүх нь Монголчуудын нүүдэл ба суурьшлын түүхтэй салшгүй холбоотой. Өнөөгийн Монгол улсын нутаг дэвсгэрт хүн суурьшсан цагаас эхлэн нүүдэлчид эзэгнэн, Хүннү, Сяньби гүрнүүд ч байгуулагдаж хүчирхэгжиж иржээ...

Монгол улсад оршин байсан эртний улсын цэргүүд дайн байлдаанд цэргийн агсамжийн иж бүрдэлдийг заавал хэрэглэж, тэдгээрт илд, жад, дуулга, бамбай, нум, сум зэрэг ордог байжээ. Монгол улсын цэргийн хүч чадал, зэр зэвсгийг харуулах зүйл бол Монгол улсад оршин тогтнож байсан эртний Хүннү, Сянби, Нирун, Түрэг, Уйгар зэрэг улсуудын түүх юм. Эртний улсуудын чиг үүрэг, зэр зэвсгийг орчин цагийн цагдаагийн байгууллагын техник хэрэгсэлтэй хэрхэн холбогдохыг хүснэгтээр авч үзье.

***Монгол нутагт байсан эртний улсуудын цэрэг, зэвсэг***[93]

| | **Хүннү улс /МЭӨ 209-МЭ 93 он/** | **Сүмбэ улс /МЭ II-IY зуун/** | **Нирун улс /IY-YI зуун/** |
|---|---|---|---|
| | Аравт, зуут, мянгат түмт гэсэн захиргаа цэргийн зохион байгуулалттай нэгдсэн байнгын цэрэг. Цэрэг нь нум сум, хуягтай, морьтой байв. | Аравтлах захиргаа цэргийн зохион байгуулалттай хуяг бүхий морин цэрэг | Аравтлах захиргаа цэргийн зохион байгуулалттай хөнгөн болон хүнд хуягласан морин цэрэг |
| Зэвсэглэл, уналга хэрэгсэл | Нум нь 140 см орчим урт, зүймэл, алсын тусгалтай цэцэн. Сум нь өдтэй, исгэрдэг зэв нь хүрэл, төмөр илд бамбай | Нум сум, төмөр илд, бамбай бүхий морин цэрэг, хоёр, дөрөв дугуйтай морин тэрэг хэрэглэж байв | Нум сум нь улам боловсронгуй болж тусгал цэг нь улам сайжрав. Сум нь дуут, оньт, гуурст гэх зэрэг 10 шахам төрөл байв. Хүнийг мориноос нь татаж унагах дэгээ, бас дүүгүүр хэрэглэж байв. |
| | **Түрэг улс /552-745 он/** | **Их монгол улс** | **Өнөөгийн Монгол улс** |
| Цэргийн зохион байгуулалт, зэвсэг хэрэгсэл | Түрэг улсын шүүгчийн захиргаан дор цэрэг нь хөнгөн болон хүнд морин цэрэгтэй байв.[94] | Нум сум, илд, жад, төмөг юмуу алма/сүх/, дүүгүүр цалам, манцуурга, сөргөө, шийдмээс аваад хатуу ширэн тулам, сум зүйлэх сумч хутга, хуурай, хэт цахиур, шөвөг, зүү утас хүртэл авч явдаг, арьс шир төмөрлөгөөр үйлдсэн хуяг дуулга, төмөр гутал, бамбай халх хэрэглэдэг байжээ. Мөн хот цайзыг дайлахад зориулсан элдэв төрлийн чөдөр оньс, гал чулуу урбугуур, хэрэм эвдэх оньсон төхөөрөг, төмөр тэрэг, үүлэн шат, дарьт зэвсэг хүртэл үйлдвэрлэж байсан байна.[95] | Цагдаагийн байгууллага алба хаагч нь<br>-гар, хөл, хурууны гав<br>- Хүлэг, ороох цамц<br>- **Бороохой**<br>- Цахилгаан бороохой<br>-Нулимс асгаруулагчаар цэнэглэсэн буу шүршүүр<br>-Амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн цэнэглэсэн буу шүршүүр<br>-Резинэн хуванцар сумтай буу<br>-Будагч бодисоор шүршигч<br>*Хүн нэг бүрийг хамгаалалтын иж бүрэн хувцас*<br>**-хатуу биетээс хамгаалах дуулган малгай**<br>-өвдөгвч, тохойвч<br>**-хатуу биетээс хамгаалах хамгаалалтын хуванцар бамбай**<br>**- сум үл нэвтхэр хантааз**<br>- хутганаас хамгаалах бээлий [96] |

[93] Ч.Лувсандорж, Д.Дүгэрээ. Монголын түүх /тэргүүн дэвтэр/. , УБ., 1998 он. 29 дах тал
[94] С.Дамба. Эртний Монгол нутагт оршин байсан Эртний улсуудын төрийн түүхэн хэсгээс. УБ., 1999 он. 54 дэх тал
[95] Монгол цэргийн түүхийн товчоон. УБ., 1996 он. 140 дэх тал
[96] Ш.Чулуун. Цагдаагийн албаны галт зэвсэг тусгай хэрэгсэл. УБ., 2015 он. 206 дах тал

Хүннү, Сүмбэ, Нирун улсын үед байсан цэргийн аравтын тогтолцоо Түрэгийн үед цэргийн хүрээнээс гарч нутаг дэвсгэрийн нарийн хувиартай болж

Зэр зэвсгийн хувьд сэлэм, тахир сэлэм, төрөл бүрийн чигчлүүр хутга, дуулга, хуягийн төмөр ялтас, сумны төрөл бүрийн зэв, хоромсогны дэгээ, морь унааны хэрэглэл зэргийг дархчууд өөрсдөө хийж байжээ. Эртний улсуудын холбогдох археологийн олдвороос үзэхэд мухар тэгш иртэй төмөр зэв, мөн хоёр хянгатай зэв, дуут зэвний гуран булцуу, гурван хянгатай зэв, ясан наалт бүхий нум, сум бүхий үйсэн хоромсог, төмөр хутга олдсоор буй нь зэр зэвсгийн талаар судлах боломж олгож байна.

Цэргийн зэр зэвсэг болох дуулга, хуяг, жад, илд, сэлэм нь тухайн үеийн бие хамгаалах хэрэгсэлийн иж бүрдэлд багтдаг ба хамгаалах хэрэгслийн төрөл хэлбэрээс үүдэн тухайн цэргийн төрөл, гүйцэтгэх үүргийн тодорхойлох нь бий.[97]

Харьцуулсан хүснэгтээс үзэхэд Монгол улсад оршин байсан эртний улсуудын хэрэглэдэг дуулга, хуяг, жад, илд, сэлэм, нум сум, ялтсан хуяг нь Их монгол улсын үед мөн уламжлагдан хэрэгэгдэж төрөл хэлбэр нь хөгжиж ирсэн байна. Харин эртний улсуудын ашиглаж байсан зэвсэг хэрэгсэлийг өнөөгийн цагдаагийн байгууллагын тусгай хэрэгсэлтэй харьцуулаж үзвэл:**бороохой** нь илд, жадтай төсөөтэй илд, жад нь боловсронгуй бол бороохойг зохион бүтээх үндэс болсон гэж судлаач миний бие үзэж байна. Хүн нэг бүрийг хамгаалалтын иж бүрэн хувцас болох **хатуу биетээс хамгаалах дуулган малгай нь** –хатуу биетээс хамгаалах хамгаалалтын хуванцар бамбай-, **сум үл нэвтхэр хантааз нь**-ялтсан хуягтай ижил зориулалтай хэрэглэгдэж эртний улсуудын үеэс уламжлагдан хөгжиж боловсронгуй болсон гэж үзэж байна.

## Дүгнэлт

Эртний монгол улсуудын цэргийн зэр зэвсэг болох дуулга, хуяг, жад, илд, сэлэм нь тухайн үеийн бие хамгаалах хэрэгсэлийн иж бүрдэлд багтдаг ба хамгаалах хэрэгслийн төрөл хэлбэрээс үүдэн тухайн цэргийн төрөл, гүйцэтгэх үүргийн тодорхойлодог байсан нь Их монгол улсын үед улам боловсронгуй болж тухайн үеийн дэвшилтэт технологийг өөрсдийн цэргийн зэв зэвсэгт нэвтрүүлж чадснаар хүчирхэг Монгол улсыг байгуулж байжээ.

Тухайн үед Монголчууд өөрсдөө зэр зэвсэг, тусгай хэрэгсэл, агсамжаа үйлдвэрлэдэг байсан бол эдүгээ бид тусгай хэрэгсэлээ бүгдийг нь импортоор авч ашиглаж байгаад залуу үеийхэн маань эртний уламжлалт зэр зэвсэг, тусгай хэрэгслэлд уламжлалт арга болон шинэ техник технологи зайлшгүй нэвтрүүлэх шаардлагатай байна.

Эртний улсуудын ашиглаж байсан илд, жаднаас улбаалан Цагдаагийн байгууллагын нэг бүрийн тусгай хэрэгсэл бороохойг зохион бүтээх үндэс болсон гэж үзэж байна. Харин хүн нэг бүрийг хамгаалалтын иж бүрэн хувцас болох хатуу биетээс хамгаалах малгай нь дуулга, сум үл нэвтрэх хантааз нь ялтсан хуягтай ижил зориулалттай хэрэглэгдэж Түрэг болон Их Монгол улсын үеэс уламжлагдан хөгжиж боловсронгуй болжээ.

[97] Монголын цэргийн түүх соёмбо нэвтэрхий толь. УБ., 2015 он. 46 дах тал

ДХИС-ын багш цагдаагийн хурандаа З.Цэрэнбат 2016 онд санаачилсан суран гав нь эртний монгол уламжлалт тусгай хэрэгсэл ба уламжлагдсан шинж чанарыг хадгалсан судалгааны ажил болсон.

Монгол улсын салбар бүр нь эх түүхээсээ улбаалан тэр л жим мөрөөр замнан түүхийн сургамжинд суурилан хөгжиж ирсэн тул түүхт 100 жилээ бүтээлцэж байгаа цагдаагийн алба хаагчид бид салбараа хөгжүүлэхийн тулд нарийвчилсан үр дүнтэй бодит судалгааг чиглэл тус бүрээр хийж, нэгтгэн зангидаж, эрдэмтэн багш төдийгүй бие биенээсээ суралцах шаардлагатай байна.

Бурууг хэл зөвийг сонсох өвгөдийнхөө мэргэн ухаанд шүтэн энэ мэт бичсэн нь алдаа, эндэгдэл бий аваас залруулан хэлж, зөвлөн ухааруулж мөхөс оюуныг минь тэлнэ гэдэгт итгэлтэй байна.

## Санал

- Цагдаагийн байгууллагаас үйл ажиллагаандаа ажиглаж байгаа нэг бүрийн болон нийтийг хамарсан үед хэрэглэх тусгай хэрэгсэлийг Монгол хүний зан араншин, өнөөгийн нийгмийн харилцаа хандлагад тулгуурлан эртний Монгол улс аймгуудын хэрэглэж байсан түүхий эд материалаар дотооддоо үйлдвэрлэх боломж нөхцөлийг судлан хэрэгжүүлэх
- ДХИС-ын багш цагдаагийн хурандаа З.Цэрэнбат 2016 онд санаачилсан суран гавыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд /тэр тусмаа өвлийн улиралд/ туршилтын журмаар үйлдвэрлэн хэрэглэх, боловсронгуй болгон хөгжүүлэх

## Ашигласан материалын жагсаалт


- Ч.Лувсандорж, Д.Дүгэрээ. Монголын түүх /тэргүүн дэвтэр/. , УБ., 1998 он.
- С.Дамба. Эртний Монгол нутагт оршин байсан Эртний улсуудын төрийн түүхэн хэсгээс. УБ., 1999 он.
- Монгол цэргийн түүхийн товчоон. УБ., 1996 он.
- Ш.Чулуун. Цагдаагийн албаны галт зэвсэг тусгай хэрэгсэл. УБ., 2015 он
- Заанхүү Ж., “Монголын түүхийн лекцүүд” УБ., 1999 он.
- “Монголын цэргийн түүх соёмбо нэвтэрхий толь”, УБ., 2015 он.

# ТИПИЧНЫЕ СПОСОБЫ НЕЗАКОННОЙ РУБКИ ЛЕСНЫХ НАСАЖДЕНИЙ

(по материалам Российской Федерации и Монголии)

***Амарсайхан Манлай***
*адъюнкт факультета подготовки*
*научных и научно-педагогических кадров*
*капитан полиции*
*(Академия управления МВД России)*
*E-mail: amarsaikhanmanlai@gmail.com*

**Аннотация:** вызвана существенным ростом в последние годы в Монголии количества ежегодно регистрируемых преступлений в виде незаконной рубки лесных насаждений, а также повышением опасности указанных преступлений. Проведение сравнения типичных способов незаконной рубки древесины в Монголии и Российской Федерации, а также выявление недостатков правового регулирования. Выработать предложения по оптимизации первоначального этапа расследования незаконной рубки лесных насаждений в Монголии. Автор приходит к выводу о том, что типичные способы незаконной рубки лесных насаждений Монголии и Российской Федерации имеют большое сходство и важное криминалистическое значение для формирования методики расследования преступлений указанной категории. В то же время уголовно-правовое регулирование ответственности за незаконной оборот древесены в Монголии нуждается в совершенствовании.

**Ключевые слова:** расследование преступлений, незаконная рубка лесных насаждений, сравнительный анализ правового регулирования, методика расследования незаконной рубки, способы преступления.

В последние годы (2017−2018 г.) на территории Монголии фиксируется значительный рост незаконных рубок лесных насаждений. За 2019 г. на территории Монголии зарегистрировано 316 преступлений, предусмотренных ст. 24.6 УК Монголии, предусматривающей ответственность за незаконную рубку лесных насаждений, а за 2020 г. – 396. Этот уровень превзошел цифровые годовые показатели 2018 года более чем в 3,3 раза (104 преступления), а 2017 года - более чем в 7 раз (47 преступлений) [6, с. 222–226]. Причины существенного роста количества совершенных преступлений весьма разнообразны и в рамках данной статьи нами не рассматривались.

Интенсификация правоприменительной деятельности создает необходимость и возможность совершенствования методики расследования таких посягательств, обеспечения неотвратимости привлечения виновных к уголовной ответственности и последующего наказания. При данных обстоятельствах анализ криминалистически значимых особенностей способа совершения преступления приобретает повышенную актуальность.

Предметом настоящей статьи является исследование наиболее типичных способов незаконной рубки лесных насаждений, выявляемых при расследовании преступлений,

предусмотренных ст. 24.6 УК Монголии и ст. 260 УК Российкой Федерации. В сравнительном аспекте представляется важным обратиться к российскому криминалистическому опыту, поскольку в структуре экологической преступности незаконная рубка лесных насаждений, наряду с незаконной охотой и незаконной добычей биологических ресурсов, занимает лидирующие позиции [7, с. 304].

Способ совершения преступления справедливо признается «ключевым звеном преступной деятельности» [1, с. 520] и в этом качестве занимает важное место в структуре криминалистической характеристики общественно опасных посягательств. Обращаясь к типичным способам, использующимся для совершения незаконной рубки лесных насаждений, можно выделить следующие.

Во-первых, незаконные рубки, сопряженные с «прикрытием» легальной или поддельной разрешительной документацией. В том числе, в эту группу способов входят рубки, при совершении которых используется подмена видов вырубаемых насаждений (например, вместо сухостойных деревьев вырубаются молодые, зеленые деревья). При использовании данного способа совершения преступления широко применяются бензопилы и иные технические средства (аккумуляторные пилы, ручные пилы, топоры).

Во-вторых, незаконные рубки, сопряженные с отсутствием разрешительных документов. В данном случае место совершения преступления выбирается виновным инициативно и осуществляется вырубка лесных насаждений выбранного им вида. При данных обстоятельствах незаконная деятельность тщательно скрывается, поскольку ее противоправность становится очевидной при обнаружении. При использовании данного способа совершения преступления также в большинстве случаев применяются бензопилы, с помощью которых процесс вырубки лесных насаждений существенно оптимизируется. Необходимо отметить, что и первый, и второй способы отличают применение бензопил и электропил в качестве средств совершения преступления.

Оба способа совершения преступления характерны как для Российской Федерации, так и для Монголии. При этом, поскольку на территории Монголии такие действия часто совершаются лицами, проживающими в сельской местности и использующими древесину для отопления жилищ, средства совершения преступления преимущественно обладают низкими бюджетной стоимостью и техническими характеристиками. Также в этой связи в Монголии преступные действия относительно часто (25% уголовных дел) совершаются в районе, прилегающем к району места жительства преступника. Вследствие сильной разреженности лесных участков в Монголии практикуется также вырубка подлеска, примеры чего в российской практике фиксируются редко.

В рассматриваемом контексте некоторые авторы используют своеобразную «привязку» способа незаконной рубки к терминологии, установленной Лесным кодексом Российской Федерации, и выделяют валку (спиливание, срезание, срубание) и иные технологические процессы, характеризующие обработку древесины (распиловка, трелевка) [2, с.145–155]. Такой подход вызывает некоторые возражения: так, и ст. 260 УК РФ, и ст. 24.6 УК Монголии предусматривают ответственность именно за рубку лесных насаждений, а последующие манипуляции с древесиной не охватывают процесса рубки и не соотносятся с объективной стороной состава данного преступления. Можно обратить внимание на то, что незаконный оборот такой древесины получил самостоятельную криминализацию в ст. 191.1 УК РФ, а в УК

Монголии такое преступление в данный момент отсутствует, вследствие чего исследование способов его совершения выходит за пределы настоящего исследования. Вместе с тем, мы считаем, что целесообразно в УК Монголии ввести уголовную ответственность за незаконный оборот древесины аналогично той, которая предусмотрена в ст. 191.1 УК РФ, поскольку это позволит подвергать уголовному преследованию лиц, занимающихся этим в виде промысла и с целью незаконного обогащения.

В России вследствие разных климатических условий, рельефа, географических и территориальных характеристик способы незаконной рубки лесных насаждений могут существенно отличаться [5, с. 26]. В Монголии совокупность различий не является настолько выраженной, поэтому все названные способы совершения преступления используются в криминальной деятельности. По результатам исследования, проведенного автором с учетом опыта расследования преступлений данного вида, можно заключить, что в Монголии чаще выявляются несанкционированные рубки лесных насаждений, совершаемые без разрешительной документации в местах, труднодоступных для незамедлительного обнаружения. При этом вырубаются в большей части хвойные, нежели лиственные породы, поскольку в растительности Монголии последние представлены в меньшей степени. Также в ряде случаев преступные действия обращаются на кустарники, так как в данном случае рубка и последующая погрузка может быть осуществлена в сжатые сроки и не требует дополнительных технических средств. В 98% случаев виновными используются бензопилы, гарантирующие быстрое завершение начатого преступного деяния (при этом лица, осуществляющие незаконную деятельность единолично, осуществляют и распиловку древесины в месте ее незаконной заготовки). Использование погрузочно-разгрузочной техники свидетельствует как о намерении быстрого сокрытия следов преступления, так и о том, что незаконно заготовленная древесина станет в будущем предметом незаконной купли-продажи (в частности, преступниками используются гидроманипуляторы, позволяющие осуществлять как погрузку, так и выгрузку древесины). Об этом же говорит достаточно высокая распространенность групповой преступной деятельности (свыше 40% уголовных дел).

Практические проблемы выявления незаконной рубки лесных насаждений обусловлены, как представляется, двумя обстоятельствами. Первое из них – дефекты нормативного закрепления положений об уголовной ответственности за совершение данного преступления. В России эта проблема преодолена: после нескольких корректировок ст. 260 УК РФ в ней закреплен четкий перечень наказуемых деяний, «оснащенный» ясными правоприменителю конструктивными признаками. В уголовном законе Монголии вследствие использования оценочных понятий, снижающих правовую определенность уголовно-правового запрета, и в условиях констатируемого учеными широкого применения семантической и семантико-синтаксической транспозиции [10, с. 142–145] структура состава незаконной рубки лесных насаждений имеет бланкетный характер, что осложняет правоприменительную деятельность.

Второе обстоятельство заключается в использовании при совершении незаконной рубки лесных насаждений такого составного элемента механизма преступления как сокрытие следов преступления. Наиболее часто в данном случае имеет место инсценировка путем случайного возникновения лесного пожара. В условиях выхода возгорания из-под контроля и привлечения значительных сил для ликвидации его очага происходит полная утрата следовой обстановки, уничтожаются значительные площади лесных насаждений, а выявление криминального

источника возгорания затрудняется, поскольку в таких случаях приоритетно осуществляются меры по спасению людей, возможному отселению их из зоны пожаров, а также меры по пожаротушению, для реализации которых привлекаются значительные человеческие ресурсы. В данном случае незаконные рубки лесных насаждений приобретают черты искусственной латентности.

Кроме того, в целях сокрытия следов преступления широко используется установление связей коррупционной направленности, участниками которых становятся как должностные лица контролирующих органов, так и, к сожалению, сотрудники полиции. Подобные аспекты уже исследовались российскими учеными [3, с. 19–23; 9, с. 268], и в России данная проблема уже получила частичное решение. Кроме того, в регионах с наиболее высокой распространенностью незаконной рубки лесных насаждений практикуются регулярные рейды, осуществляемые силами подразделений МВД России и приводящие, как правило, к дополнительному выявлению как мест незаконных рубок, так и лиц, их осуществляющих. В Монголии, как и в России, проводятся регулярные рейды сотрудников правоохранительных органов, а также в целях владения информацией, сотрудники полиции тесно контактируют с сотрудниками по охране леса.

Выявленное сходство типичных способов совершения незаконной рубки леса имеет важное криминалистическое значение, которое может быть отражено в создании алгоритма расследования этих преступлений. Способ рубки очевиден при обнаружении признаков преступления и требует подробной фиксации в протоколе осмотра места происшествия. В дальнейшем в результате оперативно-розыскных мероприятий могут быть установлены средства совершения преступления, использованные виновными, а также непосредственно круг лиц, причастных к преступной деятельности. Соответственно, эффективный алгоритм на первоначальном этапе расследования незаконных рубок лесных насаждений должен включать следующие этапы.

Во-первых, необходимо тщательное проведение следственного осмотра, по результатам которого могут быть получены сведения о вероятном способе совершения преступления. В целях их проверки может быть направлено отдельное поручение органам дознания, содержащее требование установить тип технических средств и собственников таких предметов, проживающих в районе места совершения преступления.

Во-вторых, когда будет установлен перечень владельцев технических средств, должна быть проверена причастность этих лиц к совершению преступления или их информированность о его совершении. На этой основе может быть осуществлено привлечение к уголовной ответственности конкретных лиц. Для этого могут использоваться как оперативно-розыскные мероприятия (например, опрос), так и процессуальные и следственные действия (получение объяснений, допрос в качестве свидетеля), а впоследствии – предъявление обвинения и допрос обвиняемого.

В-третьих, если преступление совершено в целях последующего личного использования заготовленной древесины, она может быть обнаружена и изъята по месту их проживания. В целях определения размера ущерба, причиненного преступлением, могут быть назначены экспертизы, по результатам которых может быть предъявлено обвинение в окончательной форме.

Предложенный алгоритм прост по своему содержанию, относительно удобен и подразумевает использование как следственных, так и оперативно-розыскных инструментов, позволяющих оптимизировать первоначальный этап расследования незаконной рубки лесных насаждений.

В то же время, российские исследователи отмечают крайне низкую выявляемость преступления, тесно связанного с незаконной рубкой лесных насаждений, а именно, - состава, предусмотренного ст. 191.1 УК РФ и устанавливающего ответственность за различные виды оборота незаконно заготовленной древесины: их соотношение составляет примерно 95:5, хотя при этом присутствует тесная территориальная взаимосвязь, в силу которой в регионах России с наибольшей распространенностью первого деяния максимально часто выявляется и второе [4, с. 100–103; 8, с. 224]. Для монгольского законодателя, возможно, установление уголовной ответственности за приобретение, хранение, перевозку и сбыт незаконно заготовленной древесины станет перспективным направлением борьбы с уничтожением и повреждением лесных насаждений, а для правоприменителя – способом пресечения таких действий и осуществления их профилактики.

Достаточно интересно, что в Монголии, как и в России, незаконная рубка лесных насаждений чаще совершается в целях последующего корыстного оборота незаконно добытой древесины. В то же время, нередки случаи, когда вырубка леса происходит в целях последующего размещения на этом участке территории предприятия (в том числе, относящегося к добывающей промышленности), либо осуществления застройки вырубленной территории. К сожалению, такая деятельность имеет высокую латентность, поскольку зачастую установить не только заинтересованность, но и непосредственное участие в организации незаконной рубки лесных насаждений со стороны предпринимателей, рассчитывающих в будущем на извлечение прибыли, не представляется возможным.

Завершая изложенное, можно заключить, что способы незаконной рубки лесных насаждений, использующиеся при совершении преступления, предусмотренного ст. 24.6 УК Монголии, не отличаются значительным разнообразием и имеют определенное сходство с теми, которые выявляются при расследовании уголовных дел российскими правоохранительными органами. Тем не менее, имеется значительная разница в диспозициях статей УК РФ и Монголии. На основании проведенного исследования мы считаем целесообразным ввести изменения в диспозицию ст. 24.6 УК Монголии и предусмотреть в ней такие способы совершения данного преступления, как незаконная рубка, а равно повреждение до степени прекращения роста лесных насаждений. Данные понятия более подробно раскрывают объективную сторону преступления, чем понятие «заготовка древесины». В целом фактическое сходство этого элемента криминалистической характеристики позволяет предположить, что в перспективе методика расследования этих преступлений, использующаяся в России, может быть адаптирована к потребностям правоприменительной деятельности в Монголии. В условиях существенного роста выявляемых фактов незаконной рубки лесных насаждений такие потребности имеются. В данный момент предложенный нами алгоритм первоначального этапа расследования может способствовать его оптимизации.

## СПИСОК ЛИТЕРАТУРЫ:

4.Белкин Р. С. Криминалистика: проблемы, тенденции, перспективы. Общая и частные теории. М.: Юрид. лит., 1987.

5.Бельков В. А. Способ совершения незаконной рубки лесных насаждений как элемент криминалистической характеристики преступления / В. А. Бельков // Юридическая наука и правоохранительная практика. 2018. № 3.

6.Васильева М. А. Вопросы интеграции в решении криминалистических задач по расследованию экологических преступлений// Вестник Томского государственного университета. Право. 2019. № 32.

7.Васильева М. А. Криминалистические проблемы расследования приобретения, хранения, перевозки, переработки в целях сбыта или сбыта заведомо незаконно заготовленной древесины// Труды Академии управления МВД России. 2018. № 1(45).

8.Васильева М. А. Первоначальный этап расследования незаконных рубок лесных насаждений (по материалам Дальневосточного региона России) : автореферат дис. … канд. юрид. наук: 12.00.12 / М.А. Васильева. М., 2014.

9.Мунхдорж Б., Цолмон Б. Статистические возможности анализа состояния преступности в Монголии / Б. Мунхдорж, Б. Цолмон // Социология уголовного права и реформирование уголовного законодательства : сб. мат-лов междунар. научн.-практ. конф. / отв. ред. Э.Л. Раднаева. М.: ИД «Юриспруденция», 2018.

10. Тимошенко Ю. А. Ответственность за экологические преступления. Научно-практический комментарий к постановлениям Пленума Верховного Суда РФ: теория и практика / Ю.А. Тимошенко. М.: Проспект, 2016.

11. Фиськов И. А. Уголовная ответственность за незаконное использование лесов : дис. … канд. юрид. наук: 12.00.08 / И.А. Фиськов. Хабаровск, 2019.

12. Чураков Д. Б. Противодействие преступным посягательствам на сохранность лесных и иных насаждений (уголовно-правовые и криминологические меры) : дис. … канд. юрид. наук: 12.00.08 / Д. Б. Чураков. М., 2017.

13. Шашкова В. Н., Ербол С. Механизмы номинации в статьях Уголовного кодекса Российской Федерации, Уголовного кодекса Монголии и Кодекса Соединенных штатов Америки, посвященных назначению наказания / В. Н. Шашкова, С. Ербол // Международный научно-исследовательский журнал. 2018. № 11. Ч. 1.

# ЭКОЛОГИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ АЛБА ХААГЧДЫН АЖИЛ ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

***Б.Зоригт***
*Дотоод хэргийн их сургуулийн*
*магистрант, цагдаагийн ахмад*

**Товчлол.** Энэхүү өгүүлэлд Экологийн цагдаагийн албаны алба хаагчдын чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажил үүргийн хуваарь, алба хаагчдаас хийж гүйцэтгэсэн ажил нь бодитойгоор дүгнэгддэг эсэх, тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, санал, зөвлөмж боловсруулахыг зорилоо.

**Түлхүүр үг.** Экологийн цагдаагийн алба, ажил байдлын тодорхойлолт, ажил дүгнэх шалгуур үзүүлэлт.

**Үндсэн хэсэг.** Манай улсад сүүлийн жилүүдэд уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж олборлолт, ашиглалтын технологийн онцлог, дэд бүтцийн байгууламжийг харилцан уялдаатай төлөвлөөгүйгээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажил хоцрогдож, хүний буруутай үйл ажиллагааны улмаас Монгол орны өндөр уулын мөнх цас, мөсөн голын усны нөөц багасч, 391 нуур тойром, 344 гол горхи, 760 булаг шанд ширгэж, цөлжилт нэмэгдэх, томоохон төв суурин газруудын ундны усны нөөц шавхагдах зэрэг бодит аюул тулгараад байна.

Иймд хүрээлэн байгаа орчныг хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, байгаль экологид учрах хохирлыг бууруулах нэгдсэн бодлого хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын мөн оны А/09 дүгээр тушаалаар цагдаагийн төв байгууллагын бүтцэд Экологийн цагдаагийн албыг байгуулсан.

Мөн тус албаны бүтэцийг шинэчилж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны Б/173 дугаар тушаалаар Мөрдөн байцаах албаны Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийг тус албанд шилжүүлж, 2021 оны А/52 дугаар тушаалаар “Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтэс”-ийг шинээр байгуулснаар 6 хэлтэс, 21 аймаг, 64 суманд экологийн асуудал хариуцсан 175 алба хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээр алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргийн хуваарь, алба хаагчдаас хийж гүйцэтгэсэн ажил нь бодитойгоор дүгнэх шаардлага тулгарч байгаа юм.

Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйл, Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 10.4.4, Цагдаагийн албаны тухай хуулийн 72 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчийн ажлыг үнэлэх /код 111/ журам” болон тухайн байгууллагын дотоод журамд заасны дагуу дүгнэж байна.

Алба хаагчийг эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхээс гадна алба хаагч нэг бүрийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэхдээ ялгаварлалтгүй хандах нь цагдаагийн байгууллага болон харьяа нэгжүүдийн үндсэн үүрэг юм.

Засгийн газраас төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэсэн ажил түүний биелэлтийг үнэлж, дүгнэх эрх зүйн хэм хэмжээг богино хугацаанд өөрчилж байгаа нь төрийн жинхэнэ албан хаагчдад тухайн хэм хэмжээг нэг мөр ойлгоход хүндрэл учирч байна. Жишээ нь: 2013-2019 онд Төрийн албаны салбар зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын[98] дагуу алба хаагчдын ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг "Үр дүнгийн гэрээ"-гээр дүгнэж байсан бөгөөд 2019-2020 он буюу 1 жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор[99] "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-аар, мөн Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор[100] Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ыг шинэчлэн баталж одоогоор хүчин төгөлдөр мөрдөж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолд төрийн жинхэнэ албан хаагч хийж гүйцэтгэсэн ажлаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас баталсан загварын дагуу сар бүр дүгнэж байсныг 2020 оны 218 дугаар тогтоолоор хагас, бүтэн жилээр дүгнэхээр заасан бол ажлын цаг ашиглалтын байдлыг дүгнэх заалтыг хассан байна.

Мөн албан хаагчдын гүйцэтгэлийг "Бүрэн хангалттай", "Хангалттай", "Хангалтгүй" гэсэн үнэлгээгээр дүгнэхээр журамласан байсан бол шинэчилсэн журамд "A буюу Маш сайн", "B буюу Сайн", "C буюу Хангалттай", "D буюу Сайжруулах шаардлагатай", "F буюу Хангалтгүй" гэсэн үнэлгээг алба хаагчдад өгөхөөр болсон.

Дээрх журмууд богино хугацаанд шинэчлэгдэн батлагдаж байгаа нь албан хаагчдад гүйцэтгэлийн үнэлгээг нэг мөр ойлгоход болон тухайн байгууллагын дагаж мөрдөх журамд өөрчлөлт орохоос авхуулаад хүндрэл учирж байгаа юм.

Иймд дээрх журмууд болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"[101]-г нэг мөр ойлгох, байгууллагын дотоод журамд ойлгомжтойгоор тусгах шаардлага тулгарч байна.

Аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны тухай, Цагдаагийн албаны тухай хууль[102], Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02, 03 дугаар тогтоолд заасан албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагад нийцүүлэн, боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/153 дугаар тушаалаар батлуулан, мөрдөн ажиллаж байна.

Мөн Экологийн цагдаагийн албаны зохион байгуулалтын бүтцийн нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын экологийн асуудал хариуцсан алба хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлж, дүгнэхэд харгалзах үзүүлэлт болгох шалгуур

---

98 https://www.legalinfo.mn/law/details/11188
99 https://www.legalinfo.mn/law/details/14109
100 https://www.legalinfo.mn/law/details/15841
101 https://cabinet.gov.mn/4523.html
102 Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

үзүүлэлт, ажил дүгнэх хүснэгтийг тус албаны даргын 2020 оны А/13 дугаар тушаалаар баталсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/52 дугаар тушаалаар “Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтэс”-ийг шинээр байгуулан тус албаны бүтэцэд өөрчлөлт орсон боловч шинээр нэмэгдсэн зохион байгуулалтын бүтэцийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийг нэмж тусган батлаагүй байна.

Экологийн цагдаагийн албаны Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтэс нь Дэд бөгөөд Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсийн дарга - 1, хяналт шалгалт хариуцсан чиглэлийн ахлах байцаагч - 1, хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагч – 2, хяналт шалгалт хариуцсан байцаагч – 1, дүн шинжилгээ, үнэлгээ хариуцсан чиглэлийн ахлах байцаагч – 1, дүн шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах байцаагч – 1, дүн шинжилгээ, үнэлгээ хариуцсан байцаагч – 2, мэдээлэл, судалгааны ахлах мэргэжилтэн – 1, нийт 10 алба хаагчийн орон тоотойгоор байгуулагдсан.[103]

Тус хэлтсийн албан тушаалтнуудын ажлын чиглэл, хамрах хүрээ болон ажил дүгнэх шалгуураас тэдний үйл ажиллагааны хэрхэн ажилласан үр дүн бодитой тодорхойлох боломжтой болох юм. Тиймээс тус хэлтсийн 9 алба хаагчтой фокус ярилцлага хийж, санаа бодлыг нь сонсож, ажилласны үндсэн дээр дараах ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийн саналыг гаргалаа.

**Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтэс.**

Тус хэлтсийн үйл ажиллагааг үнэлэхдээ дараах шалгуурыг ажил дүгнэх үзүүлэлтэндээ тусгах нь ажлыг бодитой, үнэн зөв үнэлж дүгнэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Тухайлбал:

- Байгууллагын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээллийг шалган, шийдвэрлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хэрэгжүүлсэн ажил;
- Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах, эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр заавар, зөвлөмжийг боловсруулан, гүйцэтгэл, үр дүнг тооцсон байдал;
- Албаны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн ажлын дүн мэдээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангах;
- Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг бэхжүүлэх талаар зохион байгуулж буй ажил, үр дүн, энэ чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн;
- Сахилга, ёс зүйн зөрчилд нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг тогтоон, дүн шинжилгээ хийж, илрүүлсэн зөрчил, сахилгын мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, санд шивж, холбогдох нэгжид хүргүүлсэн эсэх;
- Улсын хэмжээнд бүртгэгдсэн хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлс, чиг хандлагыг тодорхойлж, удирдлагыг мэдээллээр хангах;
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасан, албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх зэрэг болно.

[103] Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/52 дугаар тушаал.

Түүнчлэн Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтэст үүрэг гүйцэтгэх алба хаагчдын ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг тэдгээрийн гүйцэтгэж байгаа ажил үүргийн онцлог, чиглэл, хамтрах хүрээ зэрэг олон талаас нь харж боловсруулах шаардлагатай юм.Тиймээс тус хэлтэст ажиллах бүх албан тушаалтнуудын ажлын онцлогыг харгалзан дор дурдсан шалгуур үзүүлэлтүүдийг оруулах нь зөв гэж үзсэний үндсэн дээр санал дэвшүүлж байна.

**Хяналт шалгалт хариуцсан чиглэлийн ахлах байцаагч**

Чиглэлийн ахлах байцаагчийн ажил дүгнэх үзүүлэлтэд дараах шалгуурыг нэмж тусган сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- "Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах /код 112/ журам"-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ;
- Албаны шалгалтыг журамд заасан үндэслэл, журмын дагуу явуулж, зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг бүрэн тогтоож, арилгах талаар авч хэрэгжүүлсэн ажил;
- Албаны шалгалт бүрт  дугаар олгож, мэдээ тайланг үнэн зөв гаргаж, санд тухай бүр оруулсан байдал;
- Алба хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйг бэхжүүлэх талаар зохион байгуулж буй ажил, үр дүн, Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудаас энэ чиглэлээр өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн;
- Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах, эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр заавар, зөвлөмжийг боловсруулан, гүйцэтгэл, үр дүнг тооцсон байдал;
- Сахилга, ёс зүйн зөрчилд нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг тогтоон, дүн шинжилгээ хийж, илрүүлсэн зөрчил, сахилгын мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, санд шивж, холбогдох нэгжид хүргүүлэх;
- Ахлах байцаагч, байцаагч нарын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх, үр дүнг тооцох зэрэг болно.

**Хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагч**

Ахлах байцаагч нь хяналт шалгалтын байцаагч нарын үйл ажиллагааг ахлан оролцох, мэргэжил, арга зүйгээр удирдан чиглүүлэх зэрэг олон ажил үүргийг хариуцдаг тул дараах шалгуур үзүүлэлтүүд байх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан дээд удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг, даалгавар, ажлын чиглэлийг албаны хэмжээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн байдал;
- Байгууллага, алба хаагчийн дотоод аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил;
- Албаны хэмжээнд алба хаагчдын сахилга ёс зүйн байдалд дүн шинжилгээ хийж, албаны шалгалт явуулж, түүнийг бэхжүүлэх, сайжруулах, зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг төлөвлөн зохион байгуулан үр дүнг тооцсон байдал;
- Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг засуулах, шалтгааныг тогтоож, цаашид авч хэрэгжүүлэх, арга хэмжээний саналыг тодорхойлсон байдал;
- Байцаагчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, арга зүйн зөвлөгөө өгч,

дэмжлэг үзүүлэх, үр дүнг тооцох;

- Цагдаагийн алба хаагчийн нийтлэг чиг үүргийг гүйцэтгэх, хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг хэрэгжүүлэх.

**Хяналт шалгалт хариуцсан байцаагч:**

Энэ албан тушаалын ажил дүгнэх шалгуур үзүүлэлтэд дараах чиглэлийн шалгуурыг оруулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан дээд удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг, даалгавар, ажлын чиглэлийг албаны хэмжээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн байдал;
- Байгууллага, алба хаагчийн дотоод аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил;
- Албаны хэмжээнд алба хаагчдын ёс зүйн байдалд дүн шинжилгээ хийж, албаны шалгалт явуулж, түүнийг бэхжүүлэх, сайжруулах, зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг төлөвлөн зохион байгуулан үр дүнг тооцсон байдал;
- Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг засуулах, шалтгааныг тогтоож, цаашид авч хэрэгжүүлэх, арга хэмжээний саналыг тодорхойлсон байдал;
- Цагдаагийн алба хаагчийн нийтлэг чиг үүргийг гүйцэтгэх, хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг хэрэгжүүлэх.

**Дүн шинжилгээ, үнэлгээ хариуцсан чиглэлийн ахлах байцаагч**

Чиглэлийн ахлах байцаагчийн ажил дүгнэх шалгуур үзүүлэлтэд дараах чиглэлийн шалгууруудыг оруулж, сайжруулах нь зөв гэж судлаачийн хувьд үзлээ. Үүнд:

- Улсын хэмжээнд бүртгэгдсэн хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлс, чиг хандлагыг тодорхойлж, удирдлагыг мэдээллээр хангах;
- Албаны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн ажлын дүн мэдээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангах;
- Хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулах баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох газарт хүргүүлэх;
- Харъяалах гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл бэлтгэн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;
- Ахлах байцаагч, байцаагч нарын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх, үр дүнг тооцох;
- Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх, дүнг танилцуулах;
- Цагдаагийн алба хаагчийн нийтлэг чиг үүргийг гүйцэтгэх, хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг хэрэгжүүлэх.

**Дүн шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах байцаагч**

Ахлах байцаагчийн ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг дараах чиглэлийн шалгууруудыг тусгах нь ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

- Улсын хэмжээнд бүртгэгдсэн хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлс, чиг хандлагыг тодорхойлж, удирдлагыг мэдээллээр хангах;

- Албаны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн ажлын дүн мэдээнд хяналт шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангах;
- Харъяалах гэмт хэрэг, зөрчлийн талаарх судалгаа, мэдээлэл бэлтгэн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;
- Хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулах баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох газарт хүргүүлэх;
- Байцаагчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх, үр дүнг тооцох;
- Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх, дүнг танилцуулах;
- Цагдаагийн алба хаагчийн нийтлэг чиг үүргийг гүйцэтгэх, хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг хэрэгжүүлэх.

**Дүн шинжилгээ, үнэлгээ хариуцсан байцаагч**

Байцаагчийн ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа дараах чиглэлийн шалгууруудыг оруулж тусгах нь ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

- Улсын хэмжээнд бүртгэгдсэн хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлс, чиг хандлагыг тодорхойлж, удирдлагыг мэдээллээр хангах;
- Албаны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн ажлын дүн мэдээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангах;
- Харъяалах гэмт хэрэг, зөрчлийн талаарх судалгаа, мэдээлэл бэлтгэн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;
- Хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулах баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, холбогдох газарт хүргүүлэх;
- Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх, дүнг танилцуулах;
- Цагдаагийн алба хаагчийн нийтлэг чиг үүргийг гүйцэтгэх, хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг хэрэгжүүлэх зэрэг санал болно.

**Мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн**

Ахлах мэргэжилтний ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулахад дараах чиглэлийн шалгууруудыг оруулж тусгах нь үр дүнтэй гэж үзэж байна. Үүнд:

- Гэмт хэрэг, зөрчил, гомдол мэдээллийн санд мэдээллийг хугацаанд нь оруулсан байдал, хэлтсийн дарга нараас хяналт тавьж ажилласан байдал;
- Хариуцсан чиглэлээр гэмт хэрэг, зөрчил, гомдол мэдээллийн цагаан мэдээ гаргах, нөхцөл байдлын судалгаа, дүн шинжилгээ хийж, судалгаа, мэдээлэл, танилцуулга бэлтгэсэн байдал;
- Дээд шатны байгууллага, албан тушаалтныг мэдээ, мэдээллээр хангасан байдал;
- Мэдээллийн сангаас алба хаагчдад гаргасан судалгаа, болон эрүүгийн хариуцлага хүлээсэн эсэх талаар лавлагаа олгосон байдал зэрэг болно.

Аливаа нэгжийн үйл ажиллагааны үр дүн нь ажилтнуудын хамтын хүч, ажилтан бүрийн ажлын бүтээмжээс ихээхэн хамаардаг. Тэгвэл ажлын үр дүнг ажил дүгнэх шалгуур үзүүлэлт бодитой үнэлэх боломжийг олгодог байна.

**Дүгнэлт**: Шинээр байгуулагдсан хэлтсийн болон алба хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргийн хуваарийн дагуу албан тушаал нэг бүрээр ажил дүгнэх

шалгуур үзүүлэлтийг боловсруулан, яаралтай батлах шаардлагатай байна.

Ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг батлаагүйгээс алба хаагчид хийж гүйцэтгэсэн ажлаа бодитоор дүгнүүлэхгүй, ажлын хийдэл гарч болзошгүй нь тулгамдсан асуудал болсон байна.

**Санал:** Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Экологийн цагдаагийн албаны Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсийн болон тус хэлтсийн алба хаагчдын ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд нийцүүлэн батлуулах
2. Хэлтсийн алба хаагчдын гаргасан саналыг ажил дүгнэх шалгуур үзүүлэлтдээ тусгаж өгөх
3. Шалгуур үзүүлэлтэд алба хаагч бүрийн сар бүр хийдэггүй ажлыг нэмэлт үзүүлэлтэд оруулж, оноо өгөх

## Ашигласан материал

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам.
2. https://www.legalinfo.mn/
3. https://cabinet.gov.mn
4. Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль
5. Экологийн цагдаагийн албаны 2020 он болон 2021 оны эхний хагас жилийн тайлан.
6. Экологийн цагдаагийн албаны 2020 оны архивын материал.

# ОРОН НУТГИЙН АВТОЗАМД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

***Г.Ариунгэрэл***
*ДХИС-ийн магистрант,*
*цагдаагийн ахмад*

**Товчлол.** Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахын тулд замын хөдөлгөөнд оролцогчдын зан үйлийг өөрчлөхийн зэрэгцээ зам, орчин, тээврийн хэрэгсэл, замын хөдөлгөөнд оролцогчдод чиглэсэн арга хэмжээг шинжлэх ухааны үндэстэйгээр цогцоор нь шийдвэрлэх байгууллага хоорондын уялдаа холбоог хангаж байж үр дүнд хүрэх боломжтой юм.

Энэхүү өгүүлэлд хөдөө, орон нутгийн замд гарч буй зам тээврийн осол зөрчлийн нөхцөл байдал /Дорнод аймгийн жишээн дээр/, үйлдэгдсэн арга хэлбэр, нөлөөлсөн хүчин зүйлийг судалж, дүн шинжилгээ хийн осол, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, бууруулах зарим арга замын талаар товч авч тусгасан болно.

**Түлхүүр үг.** Тээврийн хэрэгсэл, зам, тээврийн осол, зөрчил, хохирол, урьдчилан сэргийлэх ажил,

**Үндсэн хэсэг.** Дэлхий дахинд осол гэмтлийн улмаас жил бүр 5.8 сая хүн амь насаа алдаж, 600 гаруй сая хүн бэртэж гэмтэж, хөгжлийн бэрхшээлтэй болж, 700 тэрбум ам.долларын хохирол учирч байгаа бол үүнээс зам тээврийн ослын улмаас 1.25 сая гаруй хүн амь насаа алдаж 50 гаруй сая хүн бэртэж гэмтэж 65 тэрбум ам.долларын хохирол учруулж байгаа нь хүн амын нас баралтын гурав дахь гол шалтгаан болж байгаа тухай дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас онцлон тэмдэглэсэн байдаг.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас баталсан "“Тогтвортой хөгжил -2030 хөтөлбөр”-ийг анх 2012 онд Рио Де Жанейро хотод улс орнуудын төрийн тэргүүнүүд оролцсон НҮБ-ын “Тогтвортой хөгжил” бага хурлын үеэр санаачилсан.[104] Уг хөтөлбөрт 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 25 хувиар бууруулах, зам тээврийн ослоос шалтгаалсан нас баралтыг 50 хувиар бууруулах зорилт дэвшүүлэн осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулахыг улс орнуудад уриалсан байдаг. [105]

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Замын хөдөлгөөнийг зохион байгуулах болон түүний төсөл, бүдүүвчийг гүйцэтгэхэд холбогдох хууль тогтоомж, техникийн норм, дүрэм, стандарт, Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг мөрдлөг болгон шинжлэх ухааны үндэслэл, тооцоо, судалгаа, дэвшилтэт технологи, техник хэрэгсэл, инженерийн оновчтой шийдлийг иж бүрэн ашиглана”, 19 дүгээр зүйлийн 19.4-т заасан “Зам, замын байгууламжийг төлөвлөх, барих, өргөтгөх, засварлах ажлыг замын хөдөлгөөний аюулгүй байдлын холбогдох шаардлагад нийцүүлэх үүргийг авто замын асуудал

[104] https://sdg.1212.mn/
[105] Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном. Уб. 2018

эрхэлсэн Засгийн газрын гишүүн хариуцна”[106] гэсэн заалтуудыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой болно гэж үзэж байна.

Монгол Улсын авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутаг, тусгай зориулалт, аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто зам гэж ангилагддаг бөгөөд нийтдээ 112 414.2 км авто замаас бүрддэг.[107] Нийт авто замын сүлжээнээс 4 282.3 км авто зам нь олон улсын, 14 918.7 км нь улсын чанартай авто замд хамаарагдах бөгөөд үүний 6 511.4 км нь хатуу хучилттай авто зам байна. Тусгай зориулалтын буюу уул уурхайн тээвэрлэлтийн зориулалт бүхий 872.7 км авто зам ашиглагдаж байна.

Монгол Улс нь Азийн авто замын сүлжээ /АН-3, АН-4, АН-32, АН-35/, Төв азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC) /4а, 4b, 4c/, Их түмэн гол санаачилга (GTI) /1а, 1b/ зэрэг олон улсын авто замын сүлжээнд нэгдэн орсон бөгөөд ОХУ, БНХАУ, Монгол Улс хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт 2 чиглэлд авто замын коридорыг хөгжүүлэх зорилт тусгагдсан. [108]

Зураг №1




Дорнод аймгийн нутаг дэвсгэр дээр улсын чанартай 1573,42 км, орон нутгийн чанартай 1804 км, Чойбалсан хотын дотор 79,2 км, тусгай зориулалтын авто зам /Уул уурхайн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн/ 435,5 км авто зам байна. Үүнээс улсын чанартай авто замын 153,4 км, Чойбалсан хотын дотор 40,7 км нь хатуу хучилттай, Чойбалсан - Баян-Уул, Өндөрхаан - Баян-Уул - Ульхан чиглэлийн 291 км сайжруулсан хайрган зам бусад нь ердийн хөрсөн шороон зам байна. Улсын чанартай төмөр бетон гүүр 6, модон гүүр 18, орон нутгийн чанартай төмөр бетон гүүр 2, модон гүүр 11 буюу 881 у/м төмөрбетон гүүр, 1045 у/м модон гүүр байна.

Дорнод аймгийн зам тээврийн гэмт хэргийн нөхцөл байдлыг 2020 оны байдлаар үзэхэд үйлдэгдсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийг урьд онтой харьцуулбал 37 нэгжээр буюу 22.4 хувиар, нас барсан хүний тоо 10 нэгжээр буюу 36.2 хувиар, гэмтсэн хүний тоо 36 нэгжээр буюу 58 хувиар тус тус өсөж цаашид энэ тоо нэмэгдэх хандлагатай байгаа.

[106] Төрийн мэдээлэл. 2015. №28. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хууль
[107] https://mrtd.gov.mn/t/53. Зам тээврийн хөгжлийн яам
[108] ТХХТ-ийн төслүүдийн онолын болон практик асуудлууд. (n.d.). *Liběna Tetrevova, Vadyba Management.*

Аймгийн хэмжээнд сүүлийн 4 жилд зам тээврийн хэрэг, осол 579 бүртгэгдсэнээс хэргийн улмаас 70 хүн нас барсан, үүнээс явган зорчигч 15, тээврийн хэрэгслийн зорчигч 23, жолооч 32, хэргийн улмаас 197 хүн гэмтсэн, үүнээс явган зорчигч 94, зорчигч 65, жолооч 38 бүртгэгдсэн байна. Нийт хэрэг, осол 2017 онд 176 бүртгэгдсэн нь 2018 онд 160 бүртгэгдсэн нь 9.1 хувиар буурсан, 2019 онд 165 бүртгэгдсэн нь 6.2 хувиар, 2020 оны жилээр 78 бүртгэгдсэн нь 11.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 2017 онд 15 хүн нас барсан, 2018 онд 24 хүн нас барсан нь урьд оноос 9 нэгжээр буюу 37.5 хувиар өссөн, 2019 онд 22 хүн нас барсныг 2017 онтой харьцуулахад 7 нэгжээр буюу 31.8 хувиар өссөн, 2020 оны эхний хагас жил 9 хүн нас барсныг 2017 онтой харьцуулахад 3 нэгжээр буюу 16.6 хувиар өсөх магадлалтай байна.

График №1




Халхгол 5, Матад 9, Баятүмэн 12, Булган 18, Хөлөнбуйр 16, Сэргэлэн 8, Цагаан-овоо 7, Баян-уул 14, Дашбалбар 13, Баяндун 14, Чулуунхороот 1, Чойбалсан 8, Хэрлэн 48 хөдөгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд гарсан зам тээврийн 187 гэмт хэргийн 102 буюу 54,5 хувь Дорнод аймгаас гадагш чиглэлд сумдын нутаг дэвсгэрт ердийн хөрсөн зам болон сайжруулсан шороон зам дээр ихэвчлэн онхолдох хэлбэрээр, цагдаагийн байгууллагаас тавих хяналт султай газруудад үйлдэгдсэн байна.

Улсын чанартай авто зам дагуу цагдаагийн байгууллагын хяналт шалгалтыг сайжруулсан, ажиллах хүн хүчийг нэмэгдүүлж өгсөнөөр 2019, 2020 онуудад Чойбалсал Өндөрхаан чиглэлийн А0502 улсын чанартай авто зам дагуу үйлдэгдэх зам тээврийн хэрэг ослын гаралт 1 дахин буурсан эерэг үзүүлэлт гарсан гэж дүгнэж болохоор байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 8 сарын байдлаар 17 хүн нас барсан, үүнээс явган зорчигч 9 нас жолоочид мөргөгдөх, дайрагдах хэлбэрээр нас барсан хэргүүд нь замын хөдөлгөөний дүрмийн зэргэлдээх замын ангилалд багтах хашаан дотроо, гэрийнхээ гадна эцэг эх асран хамгаалагч нь тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөн эхлэх үедээ зам орчны байдлыг биеэр шалгалгүй хөдлөлгөөн эхлэж бага насны хүүхдийг мөргөх, дайрах хэлбэрээр амь насыг хохироосон харамсалтай хэрэг 7 бүртгэгдсэн байна.

Хэрэг гарсан байршлыг нь сумдаар нь авч Матад-1, Баян-Ул-1, Баяндун-1, Сэргэлэн-2, Цагаан-Овоо-1, Дашбалбар-1 сумдад бүртгэгдсэн.

Бага насны хүүхэд зам тээврийн ослын улмаас нас барсан тоон үзүүлэлт 2018 онтой харьцуулахад 2019 онд 5 дахин, 2020 онд 7 дахин өссөн тоон мэдээнээс харахад цагдаагийн байгууллагаас нийтийн хэрэгцээний авто зам дээр бус замын зэргэлдээх нутаг дэвсгэрт /сумдын замын хөдөлгөөнд/ хяналт сул, хүүхдийг зам тээврийн хэрэг, ослоос хамгаалах, эцэг эхчүүд рүү чиглэсэн урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг хүүхэд хамгаалах үүрэг бүхий Хүүхэд гэр бүл хөгжлийн байгууллага, Боловсролын шат шатны байгууллага, Цагдаагийн байгууллагаас тавьж байгаа хяналт, ажил арга хэмжээ “Хангалтгүй” байгаатай холбон ойлгож болохоор байна.

Сүүлийн 4 жилд нийт 78 хүн нас барсаны 24 буюу 30.7 хувь нь тээврийн хэрэгслээр зорчин явсан зорчигч нас барсан байх бөгөөд дээрхи зорчигчид хамгаалах бүсийг хэрэглээгүй замын хөдөлгөөнд оролцож явсан нь аймгийн хэмжээнд зорчигчдоос хамгаалах бүс хэрэглэх шаардлага, хариуцлагыг Замын цагдаагийн алба хаагчдаас тооцож, шаардаж ажиллахгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Нийт гэмтсэн /2017-2020 он/ иргэдийн 65 буюу 32.9 хувийг явган зорчигч эзлэж байгаа нь цаашид Цагдаагийн байгууллагаас явган зорчигчийн хөдөлгөөний соёлыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулах, тэдний замын хөдөлгөөнд оролцох аятай нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр явган гарцны тэмдэглэлийг сайжруулж, зам орчны байдалд анхааран ажиллах.

Аймгийн хэмжээнд сүүлийн 4 жилд /2017-2020 он/ үйлдэгдсэн зам тээврийн ослын жолоочийн буруутай үйлдлийн улмаас 579 осол бүртгэдсэнээс дараах зөрчлүүд давамгайлж байна. Үүнд: согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 74 буюу нийт үйлдэгдсэн ослын 13,8 хувийг, хурдыг зөв тохируулж яваагүй 35 буюу нийт үйлдэгдсэн ослын 6.2 хувийг, бүрэн бус тээврийн хэрэгсэл 11, анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцсон 135 буюу нийт үйлдэгдсэн ослын 26.3 хувийг, зогсоох арга хэмжээ аваагүй 117 буюу 21,1 хувийг эзлэж бусад зөрчлүүд бага хувийг эзлэж байна.

Ослыг хэлбэрээр /2017-2020 он/ нь авч үзэхэд онхолдох хэлбэрээр 171 буюу нийт ослын 29,5 хувь, мөргөлдөх хэлбэрээр 240 буюу 41.4 хувь, үл хөдлөх зүйл мөргөсөн 25 буюу 4.2 хувь, явган зорчигчийг мөргөсөн 67 буюу 11.5 хувь, мал, амьтан мөргөсөн 12 буюу 2,0 хувь, бусад 20 буюу 3,8 хувь төрлөөр үйлдэгдсэн байна.

Тээврийн хэрэгслийн төрлөөр /2017-2020 он/ нь авч үзвэл суудлын авто машин 389, ачааны авто машин 36, мотоцикль 59 холбогдон Цагдаагийн байгууллагаар шалгагдсан байна. Үйлдэгдсэн гарагаар /2017-2020 он/ нь авч үзэхэд Даваа 70, Мягмар 59, Лхагва 81, Пүрэв 87, Баасан 65, Бямба 72, Ням 55 хэрэг, осол бүртгэгдсэн байна. Үйлдэгдсэн цагаар /2017-2019 он/ нь авч үзвэл 0-4 цагт 22, 5-9 цагт 42, 10-14 цагт 75, 15-19 цагт 93, 20-24 цагт 112 зам тээврийн хэрэг, осол бүртгэгдсэн байна.

Дорнод аймгийн цагдаагийн газраас 2017 онд 312 зөрчлийг илрүүлсэн бол 2018 онд 1004 зөрчил илрүүлсэн 3.2 дахин, 2019 онд 755 зөрчил илрүүлсэн нь 2.4 дахин, 2020 оны эхний 8 сарын байдлаар 664 зөрчил илрүүлсэн нь 2.1 дахин нэмэгдүүлсэн эерэг үзүүлэлт гарсан нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоноос зам тээврийн осол гаргасан шалтгаан 2017 оноос хойш жил бүр буурсан байна.

Аймгийн хэмжээнд сүүлийн 4 жилд мотоциклтой холбоотой зам тээврийн хэрэг осол 59 бүртгэгдсэнээс, хэргийн улмаас 24 хүн нас барж, 37 хүн гэмтсэн. Хэргийн улмаас 2017 онд 6

хүн барсан, 2018 онд 7 хүн нас барсан, 2019 онд 9 хүн нас барсан бол 2020 онд 2 хүн нас барж урьд онтой харьцуулахад 4,5 дахин буурсан, гэмтсэн хүн 2020 онд 2.5 дахин буурсан эерэг үзүүлэлт гарсан байна..

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол өнгөрсөн оны үзүүлэлтээс буурсан хэдий ч замын хөдөлгөөнд оролцож байхдаа осолд өртөх, хохирох үзүүлэлт буурахгүй байна. Замын нөхцлөөс шалтгаалан гарсан осол улсын хэмжээнд 48 бүртгэгдсэнээс нийслэлд 24, орон нутагт 24 байна.

Энэхүү хүчин зүйлд техникийн гэмтэл, замын гэрэл, зам орчны нөхцлийг багтаан авч үзэж байгаа ч авто зам, замын байгууламж хариуцсан байгууллагад ослын акт тавигдаж арга хэмжээ тооцсон байдал хангалтгүй, замын нөхцлөөс гарсан ослын үзүүлэлт бага хэвээр байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал, шуурхай байх үндсэн нөхцлийн нэг нь зам, замын дэд бүтэц байдаг. Замын эвдрэл, гэмтэл нь Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж, зам тээврийн осол хэрэг гарах шалтгаан нөхцлүүдийн нэг болдог байна. Өнөөг хүртэл замын эвдрэл гэмтэл, онгорхой нүх, овоолсон шороо, зузаан мөстсөн замын хэсэг, замын бусад хангалтгүй нөхцлийг тойрох гэсэн автомашины жолооч хөдөлгөөний чиглэлээ гэнэт өөрчлөх, тойрч эсрэг урсгалд орсноос гарсан ослын тохиолдлын бурууг жолоочид хүлээлгэх байдлаар хариуцлага тооцож байна.

Европын Хөдөлгөөний аюулгүй байдлын асуудал эрхэлсэн тээврийн хорооны тайланд дурьдсанаар 100 зам тээврийн осолд 250-300 шалтгаан нөлөөлсөн байдаг гээд замаас шалтгаалсан осол 22-28 хувийг, тээврийн хэрэгслээс шалтгаалсан осол 13-18 хувийг эзэлж байна.

Замын нөхцлөөс шалтгаалсан зам тээврийн ослын хохирлыг тухайн зам, байгууламжийг хариуцсан байгууллага, аж ахуйн нэгж бүрэн хариуцдаг учраас энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжийн хариуцлага маш өндөр байдаг гэж Европын Хөдөлгөөний аюулгүй байдлын асуудал эрхэлсэн тээврийн хорооны тайланд дурьджээ.

Монгол Улсад гарч байгаа зам тээврийн ослын шалтгаан нөхцлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, зөв тодорхойлохын тулд алба хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, цагдаа болон зам тээврийн салбарын шинжлэн шалгах байгууллагыг бий болгох, орчин үеийн шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангах явдал ихээхэн чухал байна..

График №2



Дорнод аймгийн нийт жолоочийн жолоодох эрхийн ангиллаар авч үзвэл: 2018 оны байдлаар “В” ангилалын жолооч 895206 буюу нийт жолоодох эрхийн ангилалын 74.1 хувийг эзэлж байхад “ВС” ангилалын жолооч 147249 буюу 12.2 хувь, “ВСД” ангилал 60128 буюу 5.0 хувийг тус тус эзэлж байна.

График №3




**Зам тээврийн ослын шалтгаант шинэ өвчлөл, насны бүлэг хүйсээр /2018.**

2018 онд зам тээврийн ослын улмаас гэмтсэн 10 хүн тутмын 3-4 нь суудлын машинаар зорчиж явахдаа, 10 хүн тутмын 2 нь явганаар зорчиж байхдаа, мөн 10 хүн тутмын 2 нь мотоциклоор зорчин явахдаа осолдсон байна..

График №4




Тээврийн хэрэгслийн төрлийг хүйсээр харьцуулан харвал унадаг дугуй, мотоцикл, ердийн хөсөг буюу морь тэмээнээс унаж гэмтсэн тохиолдол эрэгтэйчүүдэд их байна.

Дорнод аймгийн иргэдийн замын хөдөлгөөнд оролцох соёлыг дээшлүүлэх бүх төрлийн ажил арга хэмжээг зохион байгуулах, хүүхдэд зөв дадал, мэдлэгийг олгох, зам тээврийн гэмт хэрэг, ослын улмаас нас барсан, гэмтсэн хүний тоог 50 хувиар бууруулахад дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлбэл үр дүнтэй гэж үзэж байна.

**Нэг. Мэргэжлийн хяналтын байгууллагууд хамтарч, хяналт шалгалтыг чангатган хууль бус зорчигч тээврийн үйлчилгээг таслан зогсоож, аюулгүй нийтийн тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх**

- Нийтийн тээврийн үйлчилгээ болон такси үйлчилгээг холбогдох стандарт, шаардлагад нийцүүлэх, хууль бус тээвэрлэлтийг таслан зогсоох, нийтийн тээврийн хэрэгсэл, такси зогсоолын тоог нэмэгдүүлэх, шинээр бий болгох.

- Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг жолооч нарын замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгийг сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийх.
- Хот хоорондын авто замд чиглэсэн хяналтыг сайжруулах замаар хууль бус зорчигч тээврийн үйлчилгээг хязгаарлах.
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор тээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд согтуурал шалгагч драгер багажын хэрэглээг нэвтрүүлэх асуудлыг өөрсдийнх нь нөөц бололцоонд тулгуурлан шийдвэрлүүлэх.
- Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглагдаж байгаа автобусны тоог нэмэгдүүлэх /тендер, сонгон шалгаруулалтаар гуравдагч аж ахуйн нэгжийг оролцуулах/
- Хот дотор такчи үйлчилгээнд явж байгаа тээврийн хэрэгслүүдийн стандартын шаардлагад нийцүүлэн дугаар, таних тэмдэгтэй болгох асуудлыг холбогдох байгууллагуудаар дамжуулан шийдвэрлэх.

**Хоёр. Хүүхдийг зөв тээвэрлэх дадал хэвшүүлэх**

- Иргэдэд хүүхдийг зөв тээвэрлэх ач хоблогдол, учрах хор уршгийн талаар сургалт, сурталчилгааг холбогдох байгууллагуудаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлах.
- Хүүхдийг зөв тээвэрлэж байгаа байдалд хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар хууль тогтоомжид заасан арга хэмжээг холбогдох байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

**Гурав. Хамгаалах бүс, хамгаалах малгайны хэрэглээг хэвшүүлэх**

- Хамгаалах бүс, хамгаалах малгайны хэрэглээг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, зурагт хуудас, тараах материалаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлан таниулах.
- Мотоцикл худалдан борлуулдаг цэгүүдэд стандартын шаардлагад нийцсэн хамгаалах малгай дагалдуулан өгч байх талаар албан даалгавар, мэдэгдэл, албан шаардлага хүргүүлэн биелэлтэд холбогдох байгууллагуудаар дамжуулан хяналт тавих.
- Хамгаалах бүс, хамгаалах малгайны хэрэглээний талаар богино хэмжээний санамж, сэрэмжлүүлгийг бэлтгэж иргэд, олон нийтэд хүргэх.
- Хамгаалах бүс, хамгаалах малгайны хэрэглээг сайжруулах, хэвшүүлэх чиглэлээр ялангуяа мотоцклоор хөдөлгөөнд оролцож байгаа иргэдийн хамгаалах малгайг стандартын шаардлагад нийцлүүлэх талаар чиглэсэн ажил, арга хэмжээг зохион байгуулах.

**Дөрөв. Замын хөдөлгөөнийг хянаж, зохицуулах ажилд орчин үеийн дэвшилт техник технологийг нэвтрүүлэх, тэдгээрийн ашиглалт, арчлалт, хамгаалалтыг сайжруулах**

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цагдаагийн алба хаагчдад хөдөлгөөнт эргүүлийн автомашин, цагдаагийн шалгах багаж буюу бэлэн бус торгуулийн төхөөрөмж, тээврийн хэрэгслийн хурд хэмжигч зэрэг орчин үеийн дэвшилтэт техник, хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах төсвийн асуудлыг шийдвэрлэж дэмжлэг үзүүлэх.
- Гэмт хэрэг, эрх зүйн зөрчил нийгмийн тогтоосон харилцааг зөрчиж буй үйлдлийг таслан зогсоох илрүүлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой өндөр хүчин чадал бүхий телекамерын хяналтыг нэвтрүүлэн Чойбалсан

хот руу орох, гарах хөдөлгөөнд хяналт тавих системыг сайжруулан, Чойбалсан-Хөлөнбуйр, Хөлөнбуйр-Чойбалсан чиглэлийн авто замд дундаж хурдны камерын системыг Замын хяналтын постыг түшиглэн бий болгох ажлыг хэрэгжүүлэх.

- Сургууль орчмын бүсийн явган зорчигчийн гарцны тэмдэглэлийг шөнийн цагт гэрэлтүүлэх боломжийг судлан, Хэрлэн сумын Ерөнхий боловсролын сургуулиудын явган зорчигчийн гарц нэг бүрийг гэрэлтүүлэх.
- Авто замын уулзваруудын гэрлэн дохионы хэвийн ажиллагааг хангах, засвар, үйлчилгээг цаг тухай бүрт нь хийлгэх, гэрлэн дохиогоор зохицуулах уулзварын тоог нэмэгдүүлэх.
- Зам тээврийн осол, хэрэг, зөрчил ихээр гардаг зам, /хар/ цэгүүдэд мэргэжлийн байгууллагуудаар судалгаа, шинжилгээ, дүгнэлтийг хийлгэж зам тээврийн осол, хэрэг, зөрчил гарах эрсдлийг бууруулах ажлыг зохион байгуулах.
- Хөдөлгөөний зохион байгуулалт хангалтгүйгээс замын хөдөлгөөний түгжрэл, саатал бий болдог болон хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхүйц авто зам, уулзвар, гарцуудыг өөрчлөх, шинэчлэх, нэг түвшин, огтлолцолтой болгох ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.
- Замын хөдөлгөөн зохицуулах үүрэг бүхий алба хаагчийн ажлын байрны эрсдлийг бууруулах, хотын доторх замын хөдөлгөөний соёлыг дээшлүүлэх, түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд тээврийн хэрэгсэл зөөн шилжүүлэх ажлыг бусад байгууллагаар гүйцэтгүүлэх.
- Замын хөдөлгөөнд хяналт тавих үүрэг бүхий алба хаагчдыг ажиллах орчин сайжруулах чиглэлээр Хэрлэн сумын доторх авто зам дагуу Замын цагдаагийн хяналтын постыг байргуулах, туулах чадвар сайтай /хурд хүчтэй/ тусгай тоноглол бүхий тээврийн хэрэгслээр хангах, алба хаагчдын аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр дэвшилтэд технологи бүхий энгэрийн камер зэрэг нэг тусгай хэрэгсэлээр хангах.

Дорнод аймгийн хувьд дээрх ажлыг аймаг, сум, багийн хэмжээнд хэрэгжүүлэх бөгөөд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн хамтын ажиллагаа санал, санаачилга, оролцоонд тулгуурлах нь үр дүнтэй гэж үзэж байна. Мөн хэрэгжүүлэх ажлыг аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймаг, сумын Засаг дарга, ажлын алба, багийн иргэдийн нийтийн хурал болон багийн дарга нар уялдуулан зохион байгуулж, хяналт тавин ажиллахаар төлөвлөсөн байна.

Хүн бүр замын хөдөлгөөнд явганаар оролцдог учир хүүхдийг багаас нь замын хөдөлгөөнд ялангуяа явганаар хөдөлгөөнд оролцох мэдлэг, хандлага, дадлыг эзэмшүүлэхэд илүү анхаарал хандуулах шаардлагатай байна.

Монгол улсад хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, тэдний амь нас эрүүл мэндийг хамгаалах нь чухал бөгөөд хүүхэд зам тээврийн осолд өртөж буй тохиолдол нь эцэг, эх, багш сурган хүмүүжүүлэгчид, жолооч нар хамгийн их буруутай гэж үзэж байна.

Мэдээллийн технологи, мэдээлэл зүй, цахим ертөнц эрчимтэй хөгжиж буй энэ нийгэмд эцэг, эх, багш, томчууд бид тэдний мэдээллийн технологи, интернэтийн орчинд ажиллах эсвэл хэлний мэдлэг гэх мэтчилэн бусад мэдлэг боловсролд анхаарал хэт хандуулдаг ч замын хөдөлгөөнд зөв оролцох, замын хөдөлгөөний мэдлэг, боловсролд анхаарал хандуулахгүй орхигдуулах, тэдний замын хөдөлгөөний мэдлэг, хандлага, дадлыг сайжруулах чиглэлээр бодитой арга хэмжээ авахгүй байна.

Хүүхдүүд эрүүл саруул өсч торниж байгааг эцэг, эх, гэр бүлийнхэн бид харахыг хүсдэг. Тэгвэл хүүхдэд багаас нь сургуулийн өмнөх наснаас нь замын хөдөлгөөнд аюулгүй оролцох боловсрол, мэдлэг, хандлага, дадлыг эзэмшүүлсэнээр бидний хүүхдүүд замын хөдөлгөөнд зөв оролцож аюулгүй зорчих үндэс нь болж өгөх юм.

**Дүгнэлт.** Зам тээврийн осол бол сэргийлэх боломжтой, ихээхэн судлагдаж, нөлөөлдөг үндсэн эрсдэлт хүчин зүйл нь тодорхой болсон асуудал юм. Иймээс энэхүү тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор зам тээврийн осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөнд оролцогсдын мэдлэг хандлагыг өөрчлөн зохистой зан үйлийг төлөвшүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах замаар зам тээврийн осол гэмтлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Сүүлийн 20 жилийн хугацаанд хөгжингүй орнуудад замын хөдөлгөөний аюулгүй байдалд системийн хандлагыг хэрэглэж зам тээврийн ослыг бууруулж чадсан байна. Системийн хандлага нь дан ганц замын хөдөлгөөнд оролцогсдын зан үйлийг өөрчлөх замаар бус замын орчин, тээврийн хэрэгсэл, замын хөдөлгөөнд оролцогсдод чиглэсэн арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлэх арга юм байна.

Замын хөдөлгөөний осол зөрчлийн ангиллыг хянаж, осол зөрчлийн буруутай эзнийг тогтооход голлон анхаарах бус, шалтгаан нөхцөл, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийг тогтооход түлхүү анхааралаа төвлөрүүлэх хэрэгтэй байна. Дорнод аймгийн хувьд өнөөгийн гаргасан шийдвэр, хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдээ дахин үнэлэх, өнөөгийн шаардлагад нийцүүлж сайжруулах, шинэчлэх шаардлагатай харагдаж байна.

**Санал.** Дээрхи дүгнэлтийг үндэслэн зам тээврийн осол, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах саналыг дэвшүүлж байна. үүнд;

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой стандарт, норм дүрэм, журмыг боловсронгуй болгохын зэрэгцээ авто замын сүлжээ өндөр хөгжсөн орнуудын ISO, AASHTO, ASTM, BS-ын стандартыг нутагшуулах, нарийвчлан хэм хэмжээ тогтоож өгдөг заавал мөрдөх шаардлага бүхий техникийн зохицуулалтуудыг шинээр бий болгох
2. Зам тээврийн ослоор амь насаа алдагсдын 70 хувь нь эмнэлгийн анхны тусламж авч чадаагүй буюу энэ тусламжийг буруу үзүүлснээс, 20 хувь нь эмнэлгийн тусламж хоцорч очсоноос, 10 хувь нь аврах боломжгүй гэмтэл байдаг гэсэн олон улсын судалгааны дүнд үндэслэн эмнэлгийн анхны тусламжийг цаг алдалгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, тусламж үзүүлэх чадвар бүхий иргэдийн хүрээг нэмэгдүүлэх
3. Жолооны хүрдний зөв байрлал бүхий тээврийн хэрэгслийн ашиглалтыг дэмжих, тухайлбал, баруун талдаа жолооны хүрдтэй автомашин импортыг хязгаарлах зэрэг асуудлыг шийдвэрлэх
4. Жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөр, арга механизм, шалгалт авч буй тогтолцоо, аргыг цогцоор нь шинэчлэн ур чадвар, сэтгэл зүй, ухамсарын төвшинд төлөвшсөн жолооч бэлтгэх тогтолцоог бүрдүүлэн жолоочоос шалтгаалсан ослыг бууруулахад чиглэсэн бусад дэвшилдэт аргуудыг нэвтрүүлэх;
5. Төрийн албан хаагчид автомашинаасаа өөрөө татгалзах, нийтийн тээврийн үйлчилгээ, явганаар болон унадаг дугуйгаар замын хөдөлгөөнд оролцох дэд бүтэц, орчинг бүрдүүлэх.

**Ашигласан материал**

1. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл. (2017). Улаанбаатар: Адмон ХХК.
2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном-2018.
3. ТХХТ-ийн төслүүдийн онолын болон практик асуудлууд. (n.d.). *Liběna Tetrevova, adyba Management.*
4. Төрийн мэдээлэл. 2015. №28
5. https://sdg.1212.mn
6. https://mrtd.gov.mn

# ДОТООДЫН ЦЭРГИЙН "ХАРУУЛЧИН" МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

***Д.Батцоож***
*ДХИС-ийн магистрант,*
*хошууч*

**Товчлол:** Улсын онц чухал объектыг хамгаалж буй дотоодын цэргийн алба хаагчдын тэр дундаа харуулчин ахлагч бүрэлдэхүүний сургалтын, хөгжилд анхаарах нь тэдний үйл ажиллагааг идэвхжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх нь мэргэшсэн чадварлаг, зөв хандлагатай алба хаагч бэлтгэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Энэхүү өгүүлэлд Дотоодын цэргийн ахлагч бүрэлдэхүүнийг бэлтгэж буй сургалтын үйл ажиллагааны өнөөгийн байдал, давуу болон сул тал, гарч болох эрсдэл, гадаадын зарим оронд мэргэжлийн ахлагч бэлтгэж буй сургалтын хугацаа, түүнчлэн ахлагч бэлтгэх сургалтыг боловсронгуй болгох зарим асуудлыг талаар товч тусгасан болно.

**Түлхүүр үг:** Дотоодын цэрэг, харуулчин-мэргэжил, ахлагч бүрэлдэхүүн, сургалт, SWOT/TOWS матриц шинжилгээ .

**Үндсэн хэсэг.** Хүн төрөлхтний түүхийн аль ч үед нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөшүүрэг нь хүний нөөц, түүний хөгжил байсаар ирсэн билээ. Монгол Улсын Дотоодын цэргийн байгууллага нь тухайн цаг үеийхээ нийгэм эдийн засгийн хөгжилтэй шууд уялдан хөгжиж улсын онц чухал обьектыг хамгаалах, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлсээр ирсэн байдаг.

Сүүлийн 30 гаруй жил манай улсын Дотоодын цэргийн анги, байгууллагын ахлагч бүрэлдэхүүний сургалт /мэргэжлийн сургалт/ нь тогтвортой бус, хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явж ирсэн байна.

Өнөөдөр Дотоодын цэргийн ахлагч бүрэлдэхүүнийг бэлтгэх сургалтыг Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургууль хариуцан явуулж байна.

Ахлагчийн сургууль нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 1997 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 239 дүгээр тушаалаар Цагдаагийн академийн харьяанд "Цагдаагийн анхан шатны сургалтын төв" нэртэйгээр анх бие даан байгуулагдсан түүхтэй.

Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 267 дугаар тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийн бүрэлдэхүүн сургууль болон өргөжин үйл ажиллагаа явуулж байна.

Тус сургууль нь Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газрын захиалгаар төрийн тусгай

албан хаагчийн ахлагч болон офицер, бусад байгууллагын захиалгаар гэрээт харуул хамгаалалтын алба хаагч бэлтгэх сургалтыг зохион байгуулдаг.[109]

Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуульд Дотоодын цэргийн ахлагч бүрэлдэхүүнийг сургаж байгаа сургалтын тогтолцооны өнөөгийн байдлыг авч үзвэл:




Дотоодын цэргийн ахлагч бүрэлдэхүүнийг 1993 оноос бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой иргэдийг сонгон шалгаруулж 30-45 хоногийн хугацаатайгаар ЦЕГ-ын Дотоодын цэргийн 805-р ангид, 2007 оноос Дотоодын цэргээр дамжуулан 1 жилээр, 2009 оноос Дотоодын цэргийн 805-р ангид 3 сараар 21 удаагийн төгсөлтөөр 827 харуулчин ахлагч бэлтгэж байгаад 2017 оноос цэргийн алба хаасан болон дээд боловсролтой иргэдийг сонгон шалгаруулж Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуульд 3 сарын хугацаатайгаар сургаж, өдгөө 267 төгсөгчдөд чадамжийн гэрчилгээ, энгэрийн тэмдэг олгосон байна.




Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургууль нь Дотоодын цэргийн “Харуулчин” мэргэжлээр 3 сарын хугацаатай батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу мэргэжлийн сургалтыг зохион байгуулдаг.

Сургалтын хугацаанд 596 орчим цагийн багтаамжтайгаар “Дотоодын цэргийн алба үйл ажиллагааны эрх зүйн үндсийг судлах”, “Улсын онц чухал обьектын хамгаалалтын үйл

[109] https://uia.gov.mn/school/83

ажиллагаанд суралцах”,  “Обьектын хамгаалалтын инженер техник, холбоо дохиолол, теле хяналтын хэрэгслийг ашиглах”, “Дотоодын цэргийн алба, үйл ажиллагааны үед хүний эрхийг хангах”, “ Албан хэрэг хөтлөлтийг судлах”, “Цэргийн нийтлэг дүрмүүдийг судлах”, “Гэмт хэрэг, зөрчлийн тухай ойлголт, урьдчилан сэргийлэх ажлыг судлах”, “ Бие хамгаалах бэлтгэлийг эзэмших”, “Цэргийн байр зүйн бэлтгэлийг эзэмших”, “Эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх”, “Алба хаагчийн ёс зүй , сэтгэл зүй ур чадварыг эзэмших”, “Дотоодын цэрэг гэмт хэрэг, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад оролцох”, “Онцгой нөхцөл байдал үүссэн үеийн арга ажиллагаанд суралцах”,  “Обьектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх ажиллагаанд суралцах”, “Албаны тусгай хэрэгсэл хэрэглэх”, “Албаны галт зэвсэг хэрэглэх”,  “Алба хаагчийн ёс зүй, харилцааны ур чадвар, сэтгэл зүйг судлах”, “Амьд үлдэх ур чадвар эзэмших ” зэрэг 18 төрлийн хичээлийг үзэж судалдаг[110] байна.

Түүнчлэн Дотоодын цэргийн мэргэжлийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгуулах саналыг жил бүр ЦЕГ, Дотоодын цэргийн штаб болон төгсөгчдөөс авч, суралцагчдын сахилга ёс зүй төлөвшил, хүний эрхийн мэдлэг, мэргэжлийн чадамжийг дээшлүүлэх сургалтыг хичээлийн хөтөлбөрт түлхүү оруулах талаар санал солилцож, хамтран ажилладаг нь сургалтын чанарыг дээшлүүлэх чиглэлээр хийж ирсэн томоохон ажлуудын нэг билээ..

Дотоодын цэргийн мэргэжлийн сургалтын 30-35%-ийг онолын хичээл, дадлага, практикийн хичээл нь 65-70%-ийг эзэлдэг. Мөн танилцах дадлага, үйлдвэрлэлийн дадлага, хээрийн бэлтгэлд оролцуулж байна.

Ахлагчийн сургуулиас сургалтын үйл ажиллагаа, чанарыг сайжруулах, захиалагч агентлаг байгууллагатай харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх, ахлагч бүрэлдэхүүний тулгамдсан асуудлыг тодрхойлон шийдвэрлэх арга замыг нээн илрүүлэх зорилгоор жил бүр “Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд ахлагч бүрэлдэхүүний оролцоо, тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг уламжлал болгон зохион байгуулж, хурлаас гарсан зөвлөмжийг зохих байгууллагын удирдлагад /ЦЕГ, ДЦШ, ШШГЕГ, ОБЕГ, ХХЕГ г,м/ хүргүүлж байгаа нь ахлагч бүрэлдэхүүнийг дэмжих, хөгжүүлэх бодит ажил болжээ.

АНУ-ын Калифорнийн их сургуулийн профессор Блаугийн тодорхойлсноор шинэ үеийн цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь өөрийн үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомжтой, үйл ажиллагаа нь олон нийтэд чиглэсэн, мэргэшсэн, тусгай чиг үүрэг гүйцэтгэдэг байх гэж тодорхойлоод хамгийн гол шинж нь мэргэжлийн болон мэргэшсэн байх явдал гэж тус тус дүгнэжээ.[111]

АНУ, ХБНГУ, БНСУ, Турк улсын Дотоодын цэргийн мэргэжлийн, давтан сургалтын дундаж хугацаа 2 - 3 жилийн хугацаатайгаар коллежи, их сургуулийн түвшинд шаталсан байдалтайгаар сургалтуудаа явуулж байна.

ХБНГУ-ын Бавари мужийн “Нийтийн захиргаа, хууль сахиулах дээд сургууль”-ийн Дотоодын цэргийн мэргэжлийн сургалтын хөтөлбөр нь 2.5 жилийн хугацаатайгаар “Дотоодын

[110] “Цагдаа”, “Цагдаа-жолооч”, “Харуулчин” сургалтын хөтөлбөр. ДХИС-ийн харьяа Ахлагчийн сургууль 2020 он
[111] Blau P. M. “A Formal Theory of Differentiation in Organisations”, American Sociological Review 35:1999. 201-218 p

цэргийг"[112] бэлтгэж байна. Уг сургуульд элсэн суралцах иргэн нь Герман улсын бүрэн дунд боловсролтой, эрүүл мэндийн хувьд зохих шалгуурыг хангасан иргэн байхыг шаарддаг байна.

Үүнээс харахад зарим улс орны Дотоодын цэргийн мэргэжлийн ахлагч бэлтгэх сургалтын тогтолцоонд мэргэжлийн, давтан сургалтын эзлэх байр суурь нэгдүгээрт эрэмблэгдэж сургалтын төлөвлөгөөний үлэмж хэсэг нь чиглэгдсэн байна. Тухайн улсын онцлогоос хамааран "Дотоодын цэргийн" мэргэжлийн, давтан сургалт нь хэд хэдэн үе шатыг багтаасан иж бүрэн, тасралтгүй шинжтэй явагддаг байна.

Манай улсын хувьд Дотоодын цэргийн алба хаагчид түүний дотор ахлагч бүрэлдэхүүний албан үүргээ гүйцэтгэх мэдлэг, чадварын түвшин, ёс зүй, харилцааны соёл, Улсын онц чухал обьектыг хамгаалах, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах чадвар харьцангуй сул байгааг "Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний судалгаа"[113], "Хүний эрхийн тайлан"[114]-д тус тус дурьдаад сонгон шалгаруулалт болон сургалтад анхаарал хандуулахыг зөвлөсөн байна.

**Дотоодын цэргийн "Харуулчин" мэргэжлийн сургалтын**
**SWOT/TOWS матриц шинжилгээ**

Дотоодын цэргийн "Харуулчин" мэргэжлийн сургалтын үйл ажиллагааны үр дүнг ДХИС-ийн харьяа Ахлагчийн сургууль, ЦЕГ-ын "Цагдаа, Дотоодын цэргийн сургалын нэгдсэн төв"-ийн сургалтын үйл ажиллагаанд үндэслэн дүн шинжилгээ хийж, дотоод орчинд давуу болон сул талыг, харин сургуулийн гадаад орчин буюу боловсролын макро түвшинд боломж, эрсдлийг тооцож SWOT шинжилгээг хийв. Цаашдын стратегийг тодорхойлох зорилгоор SWOT/TOWS шинжилгээний матрицийг боловсруулан хүснэгтэд харуулав.

**SWOT/TOWS шинжилгээний дүн**

| | **Давуу тал (S)** | **Сул тал (W)** |
|---|---|---|
| | - Төрийн санхүүжилтээр төсөв, үйл ажиллагааны зардал, барилга байгууламжийг сайжруулах боломжтой.<br>- ДХИС-ийн Ахлагчийн сургууль нь стандарт шаардлага хангасан барилга байгууламжтай MNS 6541:2015 стандартад нийцсэн.<br>-ДХИС-ийн Ахлагчийн сургууль нь Дотоодын цэргийн "Харуулчин" мэргэжлийн хөтөлбөрийг дотоод чанарын баталгаажуулалт хийж бүсийн арга зүйн төвөөр батлуулсан.<br>- Мэдээлэл технологийн орчин үеийн техник, программ хангамжуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн, сүлжээний | - Сургалтын хугацаа хэт богино, олон хичээл шахуу цагаар хичээллэдэг<br>-Танилцах болон үйлдвэрлэлийн дадлагын хугацаа богино, сургагч ахлагч нараар дадлагажуулагч багш томилдоггүй<br>-ДХИС-ийн харьяа Ахлагчийн сургууль, ЦЕГ-ын "Цагдаа, Дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв" нь бие даан төсвийг захиран зарцуулах эрхгүй, нэмэлт орлого олох боломж хомс.<br>- Компьютер, техник, тоног төхөөрөмж хуучирсан, |

[112] Олон улсын түвшинд "цагдаа" гэдэг нэр томьёог олон нийтийн хэв журам хамгаалах улсын үйлчилгээний байгуулага, Дотоодын цэргийг зэвсэгт цагдаа, үндэсний аюулгүй байдлын гвард, дотоод аюулгүй байдлы хангагч цэрэг гэж ихэнх улс оронд тайлбарладаг.
[113] Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний судалгаа, УБ хот, 2015 он
[114] Хүний эрхийн тайлан, УБ хот, 2018, 2019 он

| | | |
|---|---|---|
| | хамгаалалтын галт хана төхөөрөмжийг лицензтэйгээр ашиглаж байна.<br>- Сонсогч, суралцагчдад шаардлагатай мэдээ мэдээлэл, гарын авлага, сурах бичгийг биет болон цахим хэлбэрээр судлах боломж бүрдсэн.<br>- Мэдээлэл технологийн орчин үеийн техник, программ хангамжуудыг түшиглэн цахим сургалт явуулах боломжтой.<br>- ДХИС-ийн 2016-2025 оны хөгжлийн стратеги хөтөлбөрт 3.1, 3.2-т сургуулийн барилга байгууламжийг хөгжүүлэх стратегийг тодорхойлсон. | сургалтын нэгдсэн систем, програм хангамжийн хүртээмж муу, боловсон хүчин дутмаг |
| **Боломж (O)** | **Давуу тал ба боломж стратеги (SO)** | **Сул тал ба боломж стратеги (WO)** |
| - Төрийн санхүүжилтээр төсөв, үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлэх боломжтой.<br>- Төрийн санхүүжилтээр хичээлийн байр, дасгал дадлагын барилга байгууламжийг шинээр барих боломжтой.<br>- ЦЕГ-ын Мэдээлэл шуурхай удирдлагын төвтэй холбогдсон шилэн кабелиар бусад төрийн байгууллагуудтай холбогдох боломжтой. | -ДХИС-ийн Ахлагчийн сургууль нь материаллаг бааз, номын сан, санхүү, мэдээлэл технологийн давуу талууд нь ЦЕГ бусад захилагч байгуулллагын өсөн нэмэгдэх боловсон хүчний сургалтыг боловсон хүчнээр бүрэн хангаж ажиллах боломжтой.<br>-Дотоодын цэргийн “Харуулчин” мэргэжлийн сургалтын бусад мэргэжлийн хөтөлбөрийг дотоод чанарын баталгаажуулалт хийж бүсийн арга зүйн төвөөр батлуулах боломжтой. Мэргэжлийн тоо, индексийг нэмэх боломжтой.<br>- Мэдээлэл технологийн орчин үеийн техник, программ хангамжуудыг түшиглэн цахим сургалт явуулах боломжтой. | - Төрийн санхүүжилтээр хичээлийн байр, дасгал дадлагын барилга байгууламжийг засварлах, шинээр барих боломжтой.<br>- Цар тахал болон бусад онцгой нөхцөл байдлын үед танхимын сургалтыг явуулах боломжгүй болович захиалагч ЦЕГ, ДЦШ-тай хамтран цахимаар сургалтыг явуулах боломжтой. |
| **Эрсдэл (T)** | **Давуу тал ба эрсдэл стратеги (ST)** | **Сул тал ба эрсдэл стратеги (WT)** |
| - Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж, төсвийн санхүүжилт буурах, тасалдал үүсэх<br>-Захиалагч байгууллагын эрэлт хэрэгцээ өссөнөөс шалтгаалан сургалт явуулах байр танхим хүрэлцэхгүй байх | -Материаллаг баазын хувьд бэхжсэн ч захиалагч байгууллагын эрэлт хэрэгцээ өссөнөөс шалтгаалан сургалт явуулах байр танхим хүрэлцэхгүй байх.<br>-Цахим сургалтын материаллаг бааз, цахим хичээлийн фонд үүсгэсэн ч захиалагч байгууллагын хүсэлтээр сургалтыг цахимаар явуулах үед техник, технологийн хоцрогдсон байдал эрсдэл учруулах боломжой. | - Сургалтын хугацаа богино байгаагаас шалтгаалан мэдлэг, чадвар сул алба хаагч төгсөж Дотоодын цэргийн анги байгууллагад ажиллах, Сургалтад чиглэгдсэн ДЦ-ийн ном, сурах бичиг, гарын авлагууд бага учраас улмаар хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх, алба хаагч болон иргэний эрүүл мэнд, амь насанд хохирол учрах,обьектын хэвийн үйл |

| | | |
|---|---|---|
| | | ажиллагаа алдагдах,үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх.<br>-Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж, төсвийн санхүүжилт буурах, тасалдал үүсэх үед анги, танхим, дадлага, дасгалын талбай, цахим хэрэгсэл, бусад сургалтын материаалаг баазыг засварлах, шинээр худалдан авах боломжгүй болох. |

Дээрхи шинжилгээнээс үзвэл Дотоодын цэргийн ахлагч бэлтгэх сургалтын давуу талыг авч үзэхээс илүүтэй сул талыг нь анхааралдаа авч цаашид ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Сургалтын сул талыг нь онцгойлон авч үзвэл:

- Сургалтын хугацаа хэт богино, олон хичээл шахуу цагаар хичээллэдэг;
- Танилцах болон үйлдвэрлэлийн дадлагын хугацаа богино, сургагч ахлагч нараар дадлагажуулагч багш томилдоггүй;
- ДХИС-ийн харьяа Ахлагчийн сургууль, ЦЕГ-ын “Цагдаа, Дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв” нь бие даан төсвийг захиран зарцуулах эрхгүй, нэмэлт орлого олох боломж хомс;
- Компьютер, техник, тоног төхөөрөмж хуучирсан, сургалтын нэгдсэн систем, програм хангамжийн хүртээмж муу, боловсон хүчин дутмаг зэрэг нөхцөл байдал шинжилгээгээр илэрсэн байна.

Бид Дотоодын цэргийн мэргэшсэн ахлагч нарыг бэлтгэхийн тулд дээрхи сургалтын сул талуудыг арилгах арга хэмжээг нэг дор биш ч тодорхой үе шаттайгаар арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл сургалтын чанар сайжирна гэж үзэж байна.

**Дүгнэлт:** Цаашид манай улс Дотоодын цэргийн мэргэжлийн болон давтан сургалтыг УИХ-ын 2020 оны 52-р тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050”[115] урт хугацааны хөгжлийн хөтөлбөрт тусгасан “Олон улсын шаардлага хангасан дээд боловсролын сургалтын байгууллагын тоог нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэн олон улсад эрэмбэлэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр бүхий үндэсний судалгааны их сургуультай болсон байна, боловсролын засаглал, удирдлагын тогтолцоог тодорхой болгож, тасралтгүй сайжрах хариуцлагын тогтолцоог бүрдүүлсэн байна”, “Монгол улсын дунд хугацааны хөгжлийн стратеги”-т “Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан дээд боловсролын салбар дундын сургалтын баазыг байгуулж, суралцагчдад ур чадварын дадлага, туршлага олгох”[116], УИХ-ын 2015 оны 12-р тогтоолоор батлагдсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д “Боловсролын олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн орон нутаг, үндэсний онцлогт суурилсан сургалтын тогтолцоог бий болгох”[117], 2014 оны Засгийн газрын 79 дүгээр тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгуулллагын хөгжлийн хөтөлбөр”-т заасан “эрүүл, чадварлаг хүний нөөц” бүрдүүлэх зорилго, зорилтуудтай тус тус уялдуулан олон улсын “Дотоодын цэргийн мэргэжлийн сургалт”-ын жишигт нийцүүлэх шаардлагатай байна.

[115] https://www.legalinfo.mn/law/details/15406
[116] http://nda.gov.mn/backend/f/tailan3.pdf
[117] https://www.legalinfo.mn/annex/details/6661?lawid=10935

Түүнчлэн ХБНГУ, БНСУ, БНТУ, ОХУ, БНХАУ зэрэг гадаадын зарим орны Дотоодын цэргийн мэргэжлийн ахлагч бэлтгэх сургалтын хөтөлбөр төлөвлөгөөнд иж бүрэн судалгаа хийж, манай орны онцлогт тохируулан боловсруулж сургалтын хугацааг 1 жилээс 2 жил хүртэл хугацаагаар явуулах нь зүйтэй гэж судлаачийн хувьд үзэж байна.

**Санал.** Хөгжингүй орны Дотоодын цэрэг, түүнтэй адилтгах сургалтын жишиг, “Цагдаа Дотоодын цэргийн анги байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний судалгаа”, “Хүний эрхийн тайлан”, SWOT/TOWS шинжилгээ зэргийг үндэслэн Дотоодын цэргийн мэргэжлийн сургалтыг сайжруулах дараах арга замыг санал болгож байна.

1. Дотоодын цэргийн мэргэжлийн сургалтын нэгдсэн стандарттай болох шаардлагатай байна.
2. ДХИС-ийн харьяа Ахлагчийн сургууль, ЦЕГ-ын “Цагдаа, Дотоодын цэргийн сургалын нэгдсэн төв”-ийн дэд бүтцийг сайжруулах
3. Мультимедиа төвийн дэд бүтцийг сайжруулах, цахим хичээл хийх боломжийг нэмэгдүүлэх, цахим сургалтыг тогтмолжуулах саналтай байна.

**Ашигласан материал:**


1. Дотоодын цэргийн тухай хууль
2. Дотоодын цэргийн алба ажиллагааны дүрэм. Уб. 2017
3. Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам. Уб.2018
4. Улсын онц чухал обьектын хамгаалалтын үйл ажиллагааны стандарт 2018
5. Т.Хүрэлбаатар. Обьектын хамгаалалтын зарим асуудлууд. Уб.2007
6. Blau P. M. “A Formal Theory of Differentiation in Organisations”, American Sociological Review 35:1999.
7. Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний судалгаа, Уб. 2015.
8. Хүний эрхийн тайлан, Уб.2018-2019
9. https://www.legalinfo.mn
10. http://nda.gov.mn
11. https://uia.gov.mn

# ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

***Д.Мөнхцэцэг***
*ДХИС-ийн магистрант, дэслэгч*
*moogii9480@gmail.com*

**Товчлол:** Аливаа улс оронд төрт ёс үүсэн бий болж, хөгжин ирсэн түүхэн замнал нь үе үеийн хууль сахиулах чиг үүрэг бүхий тусгайлан оногдуулсан үүрэг хүлээсэн хүмүүс /цагдаа, цэрэг, хуяг/-тэй салшгүй холбоотой бөгөөд ажиллах хүн хүчний нөхөн бүрдүүлэлт, хууль эрх зүйн зохицуулалт бол гол зүйл юм.

Тэднийг идэвх, зүтгэл, үр бүтээлтэй ажиллуулах, ажилдаа хандах хандлагыг судлах, хэрхэн сонгон шалгаруулж ажиллуулах нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад тулгамдаж буй асуудлуудын нэг байсаар ирсэн.

**Abstract:**

The history of the establishment and development of statehood in any country is inextricably linked with the generation of law enforcement officers (police, soldiers, bodyguards), and the retraining and legal regulation of the workforce thing.

One of the challenges for the Judiciary is to keep them active, diligent and productive, to study their attitudes and how to select them.

**Түлхүүр үг:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, бие бүрэлдэхүүн, хүний нөөц, ажиллах хүч, сонгон шалгаруулалт, манлайлал, жендэр

**Keywords:** General Executive Agency of Court Decision, personnel, human resources, workforce, selection, leadership, gender

**Зорилго:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлогод жендэрийн асуудлыг тусган үр дүнтэй хэрэгжүүлэх, бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй зарим асуудлуудыг тодорхойлоход оршино.

**Зорилт:**

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлогод жендэрийн асуудлыг тусган, үр дүнтэй хэрэгжүүлэх нь,

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлт, бүрдүүлэлтийн эх үүсвэрүүд ба аргууд,

- Бүрдүүлэлт ба бусад үйл ажиллагаануудын харилцан холбоо, үнэлэх нь, хүний нөөцийн оновчтой сонгон шалгаруулалт,

- Дүгнэлт,

- Дэвшүүлж буй санал,

- Ашигласан материал, ном зүй

**Судалгааны арга:**

-Баримт бичгийн

-Ажиглалтын

**Шинэлэг тал, ач холбогдол:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлого, нөхөн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалттай холбоотой эрх зүйн зохицуулалтыг судласны үндсэн дээр тэдэнд тулгамдаж буй асуудлыг авч үзсэнд оршино.

## I БҮЛЭГ: Байгууллагын хүний нөөцийн бодлогод жендэрийн асуудлыг тусган, үр дүнтэй хэрэгжүүлэх нь




БАЙГУУЛЛАГА ДАХЬ ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ




- ✓ Байгууллагын бодлого, үйл ажиллагааг хүн төвтэй болгох боломж,
- ✓ Үйл ажиллагаагаа илүү оновчтой, үр дүнтэй болгох, нөөц (хүний, цаг хугацааны, санхүүгийн) хэмнэх боломж,
- ✓ Байгууллагын соёлыг дээшлүүлэх, хөгжүүлэх боломж



Байгууллагад ажиллаж буй нас, хүйс, гарал угсаа, хэл соёл, шашин шүтлэг бие махбодийн хувьд ялгаатай хүмүүсийг үл гадуурхсан, үл ялгаварласан уур амьсгал, хандлага, харилцааг, тэдний хэрэгцээнд нийцсэн ажлын орчныг бий болгох буюу хүмүүсийн олон янз байдлыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэх зарчимд тулгуурласан байх ёстой.

## II БҮЛЭГ: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлт, бүрдүүлэлтийн эх үүсвэрүүд ба аргууд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлт:

Бүрдүүлэлт гэдэг нь шаардлагатай тоо, чанарыг хангах чадварлаг ажил горилогчдыг олж цуглуулах, ингэснээр байгууллагын хувьд тухайн ажлын байранд хамгийн сайн тохирох хүмүүсийг шилж сонгох боломжийг олгох нягт нарийн үйл ажиллагаа гэж ойлгодог.

Нөгөө талаас байгууллагын шаардлагад нийцэхүйц боловсрол мэдлэг чадвартай хүнийг олох явдал юм.




Бүрдүүлэлтийн эх үүсвэрүүд ба аргууд

Дотоод арга зам:

1. Аж ахуйн нэгж дотроо зарлал гаргах,
2. Өөр ажилд шилжүүлэх,
3. Хүний нөөцийг хөгжүүлэх,
4. Хавсарган ажиллуулах.

Гадаад арга зам:

1. Хөдөлмөр зуучлалын албаар дамжуулах,
2. Ажлын байр /сонин, хэвлэлээр/-ыг зарлах,
3. Зар сурталчилгаа,
4. Интернэт,
5. Чадварлаг хүний нөөцөөё шууд сурталчилгааны аргаар элсүүлэх,
6. Зохион байгуулалтын арга хэмжээ,
7. Түр хугацааны ажил,
8. Хүний нөөцийн зөвлөхийн тусламжтайгаар сонгох




**III БҮЛЭГ:**

**Бүрдүүлэлт ба бусад үйл ажиллагаануудын харилцан холбоо, үнэлэх нь**

-Хүний нөөцийн төлөвлөлт,

-Ажлын шинжилгээ,

-Сургалт ба хөгжил.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд:

-Үндсэн ажилтнууд,

-Гэрээт ажиллагсад,

-Ажилд орох хүсэлт гаргасан ажил сонирхогчид,

-Нөөцөнд байгаа ажилтнууд болон иргэдээс бүрддэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн оновчтой сонгон шалгаруулалтын үед чадварлаг нөөцийн хомсдол, хуурамч талентууд, алдаатай сонгон шалгаруулалт, ажилтны чадавхийн асуудал, байгууллагын нэр хүнд зэрэг хүндрэл гардаг бөгөөд монгол хүний сэтгэлгээ, ажилд хандах хандлагын талаар судалгаанаас харахад хэт хялбарчлах /аливаад хөнгөн хандах/, хувийн зохион байгуулалтгүй, мэдрэмжгүй, цалин хөлсийг голдог зэрэг байдал ажиглагдаж байна.

## АЖИЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА




## ҮНДСЭН ШАЛГУУРУУД

1. Манлайлал ба өөриймсөг сэтгэлгээ
2. Шийдэл гаргах, олох чадвар
3. Шинэ санаа, санаачлага гаргах чадвар
4. Эрсдэл хүлээх ба зорилгодоо хүрэх чадвар
5. Хамтран ажиллах ба харилцааны ур чадвар
6. Чадавхи потенциал
7. Мэргэжлийн ур чадвар ба хувийн зохион байгуулалт

Шагнал, урамшууллын тогтолцоо: Дотоод /Reward systems/ болон гадаад /Extrinsic reward/ гэж урамшууллын төрөлтэй байдаг бөгөөд бүх шатны удирдлага өөрийн удирдлаган доорх ажилтнуудаа урамшуулах, тэдний хувь нэмрийг цаг алдалгүй үнэлэх зорилготой байдаг.

Шагнал урамшууллын зөв бодлогын үр дүнд чадварлаг мэргэшсэн ажилтнуудыг ажилд авах, тогтоон барих үндсэн нөхцөл, ажилтнуудын ажиллах урам зориг, хүсэл эрмэлзлийг бий болгох гол хөшүүрэг болдог мөн байгууллагын зорилгод хүрэхэд түлхэц үзүүлдэг байна.

Дээрхээс гадна ажиллах сонирхолтой хүмүүсийн сонголтын хүрээ нэмэгдэж, байгууллагын доторх өрсөлдөөнт, бүтээлч уур амьсгал, өөрийгөө дайчлах хүсэл сонирхол бүрддэгийг дурдах хэрэгтэй.

**ДҮГНЭЛТ**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулиар хүлээсэн чиг үүрэг, стратеги зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, хүний нөөцийн төлөвлөлт, зохион байгуулалтыг боловсронгуй болгоход гол анхаарлаа чиглүүлэн ажилласаар ирсэн.

Мөн чиг үүргийн дагуу алба хаагчдыг ажилд нь дадлагажуулах, тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч тодорхой арга хэмжээ зохион байгуулдаг хэдий ч сүүлийн 09 дүгээр сарын байдлаар 165 алба хаагч албан тушаалаас чөлөөлөгдсөн бөгөөд шалтгаан нөхцөлийг

судлахад удирдах албан тушаалтны дарамт шахалт, зүй бус харьцаа, ажлын ачаалал, орчин нөхцөлөөс шалтгаалж гарах тохиолдол эзэлсэн байна.

*Дэвшүүлж буй санал 1*: Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "*ШШГБ-ын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив*"-д заасны дагуу хүний нөөцийн нөхөн хангалтыг хийж, нөөцийг хангалттай түвшинд бүрдүүлж, алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах, илүү цагаар ажиллуулахгүй байх

*Дэвшүүлж буй санал 2:* Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сургалт ба хөгжлийн тогтолцоог бий болгох буюу хөгжүүлэх, байгууллагын онцлог, үйл ажиллагааг сайтар таниулах,

*Дэвшүүлж буй санал 3:* Байгууллагын эрхэм зорилго, зорилт, байгууллагын онцлог, чиг үүргийн хүрээнд ажилтан эсвэл хамт олны ажлын үр дүнг болон аливаа амжилтыг цаг алдалгүй үнэлэн бусдад үлгэрлэн таниулах зорилгоор шагнаж урамшуулах

**Хэрэгжүүлэх арга зам:**

1. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "*ШШГБ-ын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив*"-д заасны дагуу хүний нөөцийн хангалтыг бүрдүүлж чадсанаар алба хаагчдын ажлын ачаалал буурч гэр бүлдээ зарцуулах цаг нэмэгдэж улмаар ажилдаа хандах хандлага нь сайжирна.

2. Алба хаагчдыг сурган дадлагажуулах сургалтыг тогтмол зохион байгуулснаар нэгт ажлаас гарах эрсдлээс сэргийлэх, хоёрт хөгжүүлэх давуу талыг бий болгохын зэрэгцээ сургалтын хэрэгцээ нь байгууллагад шинээр хүн ажилд орох, ажилтныг шинэ ажил, албан тушаалд томилох, ажлын ур чадвар бүтээмж нэмэгдүүлэх, ажлын мэдлэг, ур чадвар дутагдах зэрэг шалтгааныг арилгах чухал ач холбогдолтой.

3. Алба хаагчдыг сайшааж талархах, байгууллагын болон бусад шагналаар шагнаж урамшуулахад үнэлгээ шударга ил тод, цаг үеэ олсон, мэдэгдэхүйц, ач холбогдол бүхий, тооны хязгаар тавьж болохгүй ба материаллаг болон сэтгэл санааны урамшууллыг хослуулсан байвал үр дүнтэй.